

**Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын
“Нийгмийн эрүүл мэнд” –ийн чиглэлийн жишиг сорилууд**

Сорилын зөв хариулт

1-B, 2-A, 3-E, 4-D, 5-E, 6-B, 7-C, 8-B, 9-E, 10-C, 11-A, 12-D, 13-D, 14-C, 15-B, 16-B, 17-B, 18-D, 19-C, 20-D, 21-A, 22-B, 23-D, 24-A, 25-E, 26-E, 27-C, 28-C, 29-B, 30-E, 31-C, 32-D, 33-C, 34-A, 35-B, 36-E, 37-C, 38-D, 39-B, 40-C, 41-B, 42-B, 43-C, 44-B, 45-B, 46-B, 47-B, 48-D, 49-B, 50-C, 51-C, 52-C, 53-E, 54-A, 55-D, 56-D, 57-B, 58-E, 59-B, 60-A, 61-A, 62-E, 63-E, 64-C, 65-A, 66-D, 67-B, 68-C, 69-B, 70-E, 71-A, 72-B, 73-C, 74-C, 75-A, 76-C, 77-B, 78-E, 79-A, 80-B, 81-D, 82-E, 83-E, 84-D, 85-D, 86-E, 87-B, 88-D, 89-E, 90-C, 91-A, 92-E, 93-C, 94-A, 95-E, 96-E, 97-E, 98-B, 99-E, 100-A, 101-A, 102-C, 103-A, 104-A, 105-E, 106-E, 107-E, 108-B, 109-A, 110-A, 111-C, 112-C, 113-E, 114-E, 115-E, 116-E, 117-C, 118-E, 119-E, 120-E, 121-A, 122-E, 123-E, 124-E, 125-C, 126-A, 127-A, 128-B, 129-B, 130-E, 131-A, 132-E, 133-E, 134-B, 135-E, 136-A, 137-A, 138-E, 139-A, 140-A, 141-E, 142-B, 143-C, 144-B, 145-B, 146-A, 147-B, 148-E, 149-E, 150-A, 151-E, 152-E, 153-E, 154-A, 155-A, 156-E, 157-A, 158-A, 159-A, 160-E, 161-E,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)

/1./ Агаарын бохирдолттой тэмцэх хамгийн үр дүнтэй аргыг заана уу?

- A. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох
- B. Хийн түлш хэрэглэх
- C. Сайжруулсан зуух хэрэглэх
- D. Шахмал түлш хэрэглэх
- E. Шингэн түлш хэрэглэх

/2./ Үе тэнгийн сургагчийн талаарх БУРУУ ойлголтыг дугуйлна уу.

- A. Заавал мэргэжлийн хүн байх шаардлагатай
- B. Үе тэнгийн сургалтыг удирдан чиглүүлж буй хүн
- C. Үе тэнгийн сургалтанд суусан, сургагчаар бэлтгэгдсэн хүн
- D. Үе тэнгийнхэндээ мэдээлэл дамжуулах үүрэг хүлээсэн хүн

/3./ Гуравдагч сэргийлэлтийн чиглэл юу?

- A. Шалтгааныг тогтоох
- B. Шалтгааныг багасгах
- C. Эрт илрүүлэх
- D. Эмчлэх
- E. Үр дагавар, хүндрэлийг бууруулах

/4./ АГ-тэй хүмүүсийн хяналтын үзлэг хоорондын зай юунаас хамаарах вэ?

- A. Эмнэлэгт хэмжсэн анхны АД-ын түвшин
- B. Эмэн эмчилгээ хийлгэснээс 2 долоо хоногийн дараа хэмжсэн АД-ын түвшин
- C. Өвчтөний гэр бүлийн байдлаас
- D. ЗСӨ-ний нийт эрсдэлт хүчин зүйлсээс
- E. ЗСӨ-ний талаар удамшлын өгүүлэмжтэй байх

/5./ Манай улсад тархалт нь эпидемийн хэмжээнд хүрсэн хэрнээ анхаарлын гадна орхигдсоор байгаа урьдчилан сэргийлэх харьцангуй хялбар аргатай өвчнийг тодорхойлно уу?

- A. Умайн хүзүүний өмөн
- B. Гүйлсэн булчирхайн үрэвсэл

- C. Харшил
- D. Элэгний өмөн
- E. Ясны сийрэгжилт

/6./ Тархинд цус харвах өвчнөөс урьдчилан сэргийлэхэд аль түвшингийн урьдчилан сэргийлэлт илүү чухал вэ?

- A. Анхдагч
- B. Хоёрдогч
- C. Гуравдагч
- D. Дөрөвдөгч
- E. Бүх түвшинд

/7./ Халдварт өвчний голомт гэж юуг хэлэх вэ?

- A. Халдварын эх уурхай оршиж буй газар нутаг
- B. Халдварт өвчтэй хүн байгаа газар
- C. Эпидемийн процессын 3 хэлхээ бүрдсэн газар нутаг
- D. Халдвар хадгалагч, өвчтөн байгаа газар
- E. Бохирдсон хоол, хүнс, ус

/8./ Сүүлийн 10 жилийн байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд аль өвчин орохгүй байгаа вэ?

- A. Цусны эргэлтийн тогтолцооны эмгэг
- B. Шээс, бэлэгсийн өвчин
- C. Хорт хавдар
- D. Амьсгалын тогтолцооны эмгэг
- E. Хоол шингээх эрхтний эмгэг

/9./ Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн зорилтот хүн амыг сонгохдоо аль үзүүлэлтийг тооцох шаардлагатай вэ?

- A. Нас
- B. Хүйс
- C. Нийгэм эдийн засгийн
- D. Газар зүйн онцлог
- E. Дээрх бүгд

/10./ Улс орны эдийн засгийн байдал ба НЭМ-ийн байдал хоорондын доорх хамаарлын аль нь зөв бэ?

- A. Үндэсний нийт бүтээгдэхүүн нь эрүүл мэндийн байдалд шууд нөлөө үзүүлэхгүй.
- B. Нэг хүнд оногдох орлого буурах тутам хүн амын эрүүл мэндийн байдал дээшилдэг.
- C. Хүн амын дундаж наслалт эдийн засгийн хөгжлөөс шууд хамааралтай.
- D. Хүн амын дундаж наслалт эдийн засгийн хөгжлөөс шууд бус хамааралтай

/11./ Доорхоос аль нь өвчтөн төвтэй үзлэг зөвлөгөөний зарчим бэ?

- A. Өвчтөн өөрийнхөө өвчин эмгэгийн тухай юу гэж бодож байгаа, эмчээс юу хүлээж байгааг асууж мэдэх нь маш чухал
- B. Өвчтөнийхөө хүсч буй шинжилгээ, нарийн мэргэжлийн эмчид ямар нэг саад хориггүйгээр илгээх
- C. Өвчтөн санаачлагыг гартаа авч эмчийн юу хийх ёстойг заах
- D. Эмч санаачлагыг гартаа авч өвчтөний бодол санаа, мэдрэмж, хүсэлтийг үл харгалзан өөрийнхөө туршлага дээр үндэслэн онош тавьж эмчлэх
- E. Эмч аль болох их ярьж зааж зааварлах, олон шинжилгээнд илгээж олон эмчилгээ хийх

/12./ Таниулсан зөвшөөрөл ямар үндсэн гурван зарчимд тулгуурладаг вэ?

- A. Эмч/эмнэлгийн ажилтны хариуцлагыг дээшлүүлэх, үйлчлүүлэгчид ашиг тустай байх ба үйлчлүүлэгчийг хамгаалах
- B. Үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах, үйлчлүүлэгчид үнэнч хандах ба үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах
- C. Үйлчлүүлэгчийг санхүүгийн эрсдлээс хамгаалах, үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангах ба үйлчлүүлэгчийн халдашгүй байдлыг хангах
- D. Үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах, үйлчлүүлэгчид асуудлыг ухамсарлуулах ба үйлчлүүлэгчийг дарамт шахалтаас ангид байлгах

Е. Үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах, үйлчлүүлэгчид ашиг тустай байх ба үйлчлүүлэгчийн халдашгүй байдлыг хангах

/13./ НЭМ-ийн байдлын талаарх хүйсийн тэгш байдлын доорхи хамаарлуудын аль нь зөв бэ?

А. Эрэгтэйчүүд бусад өвчлөл дотроос осол гэмтлийн улмаас нас баралтанд эмэгтэйчүүдээс илүү өртдөг.

В. Насанд хүрээгүй хүмүүсийн нас баралтанд хүйсийн ялгаа ажиглагддаг, харин насанд хүрсэн хүмүүсийн нас баралтанд ийм ялгаа байдаггүй.

С. Нас барахад хүргэж буй шалтгаанаас хамаарч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд нас баралтын ялгаатай тал ажиглагддаг.

Д. Эрэгтэйчүүдийн нас баралт бүх насныханд, бүх шалтгаанаараа эмэгтэйчүүдийнхээс илүү байдаг

/14./ Энерги зарцуулалт суугаа ажлын үед хэдэн хувиар нэмэгддэг вэ?

А. 0-5%

В. 5-10%

С. 10-15%

Д. 15-20%

Е. 20-25%

/15./ Дэлхийн хэмжээнд ...

А. ХДХВ/ДОХ нь зүрх судасны өвчнөөс хоёр дахин их үхэлд хүргэдэг

В. зүрх судасны өвчин нь ХДХВ/ДОХ, сүрьеэ, хумхаа өвчин бүгдийг нийлүүлснээс илүү олон үхэлд хүргэдэг

С. хорт хавдар болон зүрх судасны өвчний үхлийн тоо бараг ойролцоо

Д. чихрийн шижин өвчин нь бусад халдварт бус өвчнүүдээс хамгийн их үхэлд хүргэдэг

Е. нийт үхлийн 50% халдварт өвчин, 40% нь халдварт бус өвчин, үлдсэн 10% гэмтлийн шалтгаантай байдаг.

/16./ Эрсдэлт хүчин зүйл бол:

А. Өвчтэй болох магадлалыг багасгадаг зүйл

В. Өвчтэй болох магадлалыг ихэсгэдэг зүйл

С. Өвчтэй болох магадлалд нөлөөлдөггүй зүйл

Д. Өвчинтэй хамаагүй зүйл

Е. Өвчнийг эмчлэхэд хэрэглэдэг зүйл

/17./ Чихрийн шижингийн аль ч хэлбэрийн үед хүндрэлээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ аль нь вэ?

А. Таргалалтыг эмчлэх

В. Цусны глюкозын байнгын хяналт

С. Инсулин эмчилгээ

Д. Цусны глюкозын үр дүнтэй хяналт

Е. Үзлэг шинжилгээг гүйцэт, бүрэн хийх

/18./ Халдварт бус өвчний эрсдэлт зан үйлд аль нь орохгүй вэ?

А. тамхи татах

В. архи хэрэглэх

С. өөх тос ихтэй хоол хэрэглэх

Д. удамшлын хүчин зүйлс

Е. давс ихтэй хоол хэрэглэх

/19./ Дэлхийд хамгийн хурдацтай тархаж буй нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг нэрлэнэ үү?

А. Хорт хавдар

В. АЦХаХ

С. Чихрийн шижин

Д. ХДХВ/ДОХ

Е. Ажлын байран дээрх осол гэмтэл

/20./ Дахин сэргэж буй халдварт өвчнийг заана уу?

А. АЦХаХ

В. ДОХ

С. Ханта вирусын халдвар

- D. Сүрьеэ
 - E. Эбола вирусын өвчин
- /21./ ДОХ-ын эх уурхайг заана уу?
- A. ХДХВ-тээгч
 - B. Бие үнэлэгч
 - C. Хар тамхичин
 - D. Эмнэлгийн ажилтан
 - E. Жирэмсэн эх
- /22./ Ховор өвчнийг судлахад судалгааны ямар арга хамгийн тохиромжтой вэ?
- A. Санамсаргүй түүвэрлэлттэй туршилт судалгаа
 - B. Тохиолдол-хяналтын судалгаа
 - C. Кохорт судалгаа
 - D. Нэг агшны судалгаа
 - E. Тохиолдлын тайлан судалгаа
- /23./ Дараах хүчин зүйлээс хүний эрүүл мэндийн байдлыг хамгийн ихээр тодорхойлдог нь нотлогдсон хүчин зүйлийг сонгоно уу?
- A. Нас
 - B. Орлого
 - C. Ажил эрхлэлт
 - D. Боловсрол
 - E. Яс үндэс
- /24./ Хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлдөг нийгмийн орчны хамгийн гол нэг хүчин зүйлийг нэрлэнэ үү.
- A. Нийгэм-эдийн засгийн байдал
 - B. Хүйсний тэгш байдал
 - C. Гэрлэлтийн байдал
 - D. Ажил мэргэжил
 - E. Боловсрол
- /25./ Эрүүл мэндийн сургалт сурталчилгаа ба өвчний урьдчилан сэргийлэлтийн зорилгод аль нь ХАМААРАХГҮЙ вэ?
- A. хүмүүсийг эрүүл байхад тусалж, өвчнөөс урьдчилан сэргийлэх
 - B. эрүүл амьдрах орчноор хангах
 - C. эрүүл мэндийн бодлого
 - D. эрүүл ажлын байр бий болгох
 - E. цэвэр эмчлэн анагаахын үйл ажиллагаа
- /26./ Бодисын солилцооны хам шинжийн үндсэн бүрэлдэхүүн нь
- A. Төвийн таргалалт
 - B. Өндөр АД
 - C. Глюкозын солилцооны алдагдал
 - D. Дислипидемия
 - E. Дээрх бүгд
- /27./ Вакцинд тавигдах хамгийн гол шинж юу вэ?
- A. Антиген шинж
 - B. Хоргүй
 - C. Дархлаа тогтоох
 - D. Ариун
 - E. Тогтвортой
- /28./ Үе тэнгийнхний боловсрол нь...
- A. Зөвхөн сургалт явуулах арга хэлбэрээр явагддаг
 - B. Зөвхөн нас ойролцоо хүмүүс хоорондоо мэдээлэл түгээх үйл ажиллагаа
 - C. Албан бус боловсролын нэг хэлбэр
 - D. Зөвхөн бусдад мэдлэг олгохын тулд явуулдаг үйл ажиллагаа
- /29./ АЦХаХ-ийн халдвар дамжих замуудыг нэрлэ?
- A. Ахуйн хавьталын зам
 - B. Агаар дуслын зам

- C. Дуслын зам
- D. Бэлгийн замаар
- E. Бүгд зөв

/30./ Аль нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн зарчим биш вэ?

- A. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг стандартчилах
- B. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, тэгш, хүртээмжтэй байдлыг хангах
- C. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь эрүүл мэндийн хувьд үр дүнтэй, нийгмийн хувьд үр нөлөөтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх
- D. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа нь нийтээр хүлээн зөвшөөрсөн дэвшилтэт технологи, уламжлалд тулгуурласан хямд, энгийн байх
- E. Хүн амын эмзэг хэсгийн хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх

/31./ Ажиллах чадвар ямар үед хамгийн өндөр байдаг вэ?

- A. Ажилд идэвхжиж орох үед
- B. Ажиллах чадвар буурах үед
- C. Тогтворжих үед
- D. Дасан зохицох үед
- E. Ажлын ачаалал бага үед

/32./ Хоол тэжээлийн хэдэн хувь нь өөх тос байвал эрүүл гэж үзэх вэ?

- A. < 5%
- B. < 10%
- C. < 20%
- D. < 30%
- E. < 40%

/33./ “Цагаан халадны даралт ихсэлт” гэж юу вэ?

- A. Цагаан халад өмсдөг мэргэжлийн хүмүүст тохиолддог даралт ихсэлт
- B. Эмнэлгийн нөхцөлд хэмжиж илрүүлсэн АГ нь гэрийн нөхцөлд хэмжихэд батлагдах
- C. Эмнэлгийн нөхцөлд хэмжиж илрүүлсэн АГ нь гэрийн нөхцөлд хэмжихэд батлагдахгүй байх
- D. АД-ыг эмнэлэгт хэмжихэд 160/100 мм МУБ, гэрт хэмжихэд 145/95 мм МУБ байх
- E. 24 цагийн АД-ын хяналтанд шөнийн АД буураагүй байх

/34./ Хавдраас урьдчилан сэргийлэхэд аль түвшингийн урьдчилан сэргийлэлт илүү чухал вэ?

- A. Анхдагч
- B. Хоёрдогч
- C. Гуравдагч
- D. Дөрөвдөгч
- E. Бүх түвшинд

/35./ Дараахын аль нь нийгмийн эрүүл мэндийг дэмжих аргачлал БИШ вэ?

- A. Төрийн бодлого, хууль
- B. Оношилгоо
- C. Эрүүл мэндийн боловсрол
- D. Нийгмийн маркетинг
- E. Нөлөөллийн ажил

/36./ Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд гол үүрэгтэй хүмүүсийг заана уу.

- A. Ажил олгогчид
- B. Ажилчид
- C. Менежерүүд
- D. Эрүүл мэндийн мэргэжилтэнүүд
- E. Дээрх бүх хүмүүс

/37./ Дараах мэдээллийн аль нь буруу вэ?

- A. Ихэнх халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой
- B. Халдварт бус өвчин баян ядуу хүнийг ялгахгүй

С. Халдварт өвчнийг дэлхий даяар устгасны дараа л халдварт бус өвчний эсрэг ажиллах ёстой

D. Чихрийн шижин бол халдварт бус өвчин

E. Зарим халдварт бус өвчнийг энгийн аргаар эмчилж болдог

/38./ Ийлдэсийн холестеролын хэмжээг хамгийн чухал тодорхойлогч хүчин зүйл нь ...

A. өдөрт идсэн өндөгний хэмжээ

B. давсны хэрэглээ

C. биеийн хөдөлгөөн

D. ханасан (амьтны) өөх тосны хэрэглээ

E. өдөрт хэрэглэсэн холестеролын хэмжээ

/39./ Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсаны дараа ямар эрүүл мэндийн үзлэгт ажилчид хамрагдах ёстой вэ?

A. Байнгын/хугацаат үзлэг

B. Ажилд орохын өмнөх үзлэг

C. Нийгмийн даатгалаас нөхөн олговор олгох үзлэг

D. Өрхийн эмчийн үзлэг

E. Сумын эмчийн үзлэг

/40./ Эндемик өвчин гэж юу вэ?

A. Гаднаас орж ирж тархсан

B. Тархалт ихтэй

C. Тухайн хүн амын дунд голомтлон тохиолддог

D. Дэгдэлт хэлбэртэй

E. Эндэгдэл, хүндрэл ихтэй

/41./ Өсвөр үеийнхний тамхины хэрэглээг бууруулахад хамгийн үр дүнтэй болох нь нотлогдсон аргыг тодорхойлно уу?

A. Тамхины хууль бус үйлдвэрлэл, худалдааг зогсоох

B. Татвар нэмэх

C. Никотин орлуулах эмчилгээ

D. Мэдээлэл, сургалт, сурталчилгаа

E. Тамхины сурталчилгааг бүрэн хориглох

/42./ НЭМ-ийн эрхэм зорилго юу вэ?

A. Эрүүл мэндийг дэмжих нөхцлөөр хангах нийгмийн сонирхлыг бий болгох.

B. Нийгмийн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн хүн амын эрүүл байх нөхцлийг хангах

C. Хүний эрүүл байх болон амьдралыг уртасгах нөхцлийг хангах

D. Хүний амьдралыг уртасгах нөхцлөөр хангах нийгмийн сонирхлыг хангах

E. Хүний амьдралыг уртасгах болон эрүүл мэндийг дэмжих нөхцлөөр хангах нийгмийн сонирхлыг хангах

/43./ Гэрлэлтийн байдал НЭМ-ийн асуудалд хэрхэн нөлөөлөх вэ?

A. Ганц бие хүмүүсийн өвчлөл гэр бүлтэй хүмүүсийнхээс бага байдаг

B. Ганц бие хүмүүсийн нас баралт гэр бүлтэй хүмүүсийнхээс бага байдаг

C. Ганц бие хүмүүсийн өвчлөл, нас баралт гэр бүлтэй хүмүүсийнхээс их байдаг

D. Ганц бие хүмүүсийн өвчлөл, нас баралт гэр бүлтэй хүмүүсийнхээс бага байдаг

/44./ Анхдагч урьдчилан сэргийлэлт нь...

A. өвчтөнг эмчлэхэд анхаардаг

B. өвчнөөс сэргийлэх зорилготой

C. эмчилгээг хурдан хүргэдэг гэсэн үг

D. архаг өвчнөөс үүдэлтэй хөгжлийн бэрхшээлээс сэргийлдэг

E. нөхөн сэргээх боломж олгодог

/45./ Халдвар дамжуулагч хүчин зүйлийн тодорхойлолтыг заана уу?

A. Өвчин үүсгэгч хувьсал хөгжлийн явцдаа олж авсан өөрийнхөө биологийн зүйлийг хадгалахын тул нэг бие махбодиос нөгөөд шилжих орон зайн солилцоо

B. Тухайн нөхцөлд өвчин үүсгэгчийг нэгээс нөгөөд зөөвөрлөхөд

оролцож байгаа гадаад орчны элементүүд

- С. Өвчин үүсгэгчийг нэгээс нөгөөд дамжуулж байгаа хүн болон амьтад
D. Өвчтэй хүн болон мал амьтад
E. Халдварт өвчтэй хүний цус цусан бүтээгдхүүн
- /46./ Өвчний эрт үед байгаа өвчтөнүүд урьдчилан сэргийлэлтийн ямар хөтөлбөрийн зорилтот хүн ам болдог вэ?
A. Анхдагч
B. Хоёрдогч
C. Гуравдагч
D. Бүгд
E. Аль нь ч биш
- /47./ Нөхөн дархлаажуулалт гэдэг нь
A. Хүн амын дархлалын ерөнхий түвшин буурахаас сэргийлж, урьд нь заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан эсэхийг үл харгалзан дархлаажуулах бэлдмэл хэрэглэхийг хэлнэ.
B. Заавал хийх дархлаажуулалтын анхны болон давтан тунгаас хоцорсон хүнд дархлаажуулах бэлдмэл хэрэглэхийг хэлнэ.
C. Иргэн өөрийн хүсэлтээр дархлаажуулах бэлдмэл нөхөн хийлгэхийг хэлнэ
D. Дархлаажуулах насны бүх хүмүүсийг хамарвал зохих дархлаажуулалтыг нөхөн хийхийг хэлнэ.
- /48./ Монгол улсын Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого ямар хугацаанд хэрэгжихээр батлагдсан бэ?
A. 5 жил
B. 5-10 жил
C. 10 жил
D. 10-15 жил
E. 15 жил
- /49./ Дараах аргуудаас аль нь АГ болон ЧШ хавсарсан өвчтөнг оношлоход хэрэггүй вэ?
A. ЭКГ
B. Спирометр
C. Цусны глюкоз
D. ЦЕШ
E. ШЕШ
- /50./ НЭМ-ийн мөн чанарт аль нь хамаарагдахгүй вэ?
A. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд чиглэнэ
B. Хамт олны нөөц бололцоонд тулгуурлана
C. Эмч, мэргэжилтний үүрэг
D. Үйл ажиллагааг зөв зохион байгуулах
- /51./ Эдгээрээс аль нь сайн дурын үйл хэргийн хэлбэрт ХАМААРАХГҮЙ вэ?
A. Нийгмийн төлөөх аливаа үйл хэрэгт оролцох
B. Бусдад энэрэн нийгүүлсэх үйлсийн үйлчилгээ үзүүлэх
C. Харилцан туслалцаа үзүүлэх буюу өөртөө туслах
D. Бусдын сайн сайхны төлөө эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх
E. Бусдыг өмгөөлж, хамгаалах үйл ажиллагаанд оролцох
- /52./ Дараахь эмгэгүүдийн аль нь АГ-ийн эмнэлзүйн хавсарсан эмгэгт багтдаггүй вэ?
A. Зүрхний булчингийн шигдээс
B. Бөөрний дутагдал
C. Багтраа
D. Тархинд цочмогоор түр цус хомсрох
E. Чихрийн шижингийн бөөрний эмгэг
- /53./ Дараахын аль нь нийгмийн эрүүл мэндийг дэмжих ойлголтын үндсэн бүрэлдэхүүн хэсэг БИШ вэ?
A. Эрх мэдэлжүүлэх
B. Чадавч бэхжүүлэх
C. Эрүүл мэндийг хүн бүрт

- D. Амьдралын нөхцөл
 - E. Эмнэлгийн эмчилгээ
- /54./ Ажилчдад хийгдэх ажилд орохын өмнөх үзлэгийн гол зорилго юу вэ
- A. Суурь өвчнийг илрүүлж, ажил мэргэжлийн тохироог үнэлэх
 - B. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эмчлэх
 - C. Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх
 - D. Хэт ядралтаас сэргийлэх
 - E. Хөдөлмөрийн нөхцлийг үнэлэх
- /55./ Дараах мэдээллийн аль нь халдварт бус өвчинд холбогдолгүй вэ?
- A. Урьдчилан сэргийлэх боломжтой бүлэг өвчин
 - B. Олон хүн өвчилж байгаа бүлэг өвчин
 - C. Түгээмэл болсоор байгаа бүлэг өвчин
 - D. Нэг хүнээс нөгөө хүнд дамждаг бүлэг өвчин
 - E. Монголд түгээмэл байдаг бүлэг өвчин
- /56./ Гуравдагч урьдчилан сэргийлэлтийн хөтөлбөрийн зорилтот хүн амыг тодорхойлно уу?
- A. Нийт хүн ам
 - B. Эрсдэлт бүлгийн хүн ам
 - C. Өвчний эрт үед байгаа өвчтөнүүд
 - D. Өвчний хожуу үед байгаа өвчтөнүүд
 - E. Эрүүл хүн ам
- /57./ Нэгэн цэцэрлэгт улаан бурхан өвчний шинэ тохиолдол гарчээ. Өвчтэй хүүхдийг тусгаарлан эмчилгээнд хамруулжээ. Энэ ямар түвшинд хийгдсэн урьдчилан сэргийлэлт вэ?
- A. Анхдагч
 - B. Хоёрдогч
 - C. Гуравдагч
 - D. Дөрөвдөгч
 - E. Бүх түвшинд
- /58./ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ажлын байраар дамжуулан хүн амд хүргэх нь ямар давуу талтай вэ?
- A. Олон хүн, тогтвортой хамрагдах
 - B. Богино хугацаанд үр дүнгээ өгдөг
 - C. Эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай хүргэх
 - D. Байгууллагад эдийн засгийн өндөр үр ашигтай
 - E. Дээрх бүгд
- /59./ Тарваган тахлын уушигны хэлбэр нь ямар замаар халдах вэ?
- A. Усаар
 - B. Агаар дуслаар
 - C. Трансмиссив
 - D. Цусаар
 - E. Бүх замаар
- /60./ Хоёр аймгийн нас баралтын түвшинг хооронд нь харьцуулах хамгийн тохиромжтой аргыг сонгоно уу?
- A. Насны бүлэг дэх нас баралтын түвшин
 - B. Нас баралтын ерөнхий түвшин
 - C. Тархалтын түвшин
 - D. Хүйсээр ялган тооцсон нас баралтын түвшин
 - E. Нас баралтын ерөнхий түвшингийн сүүлийн таван жилийн дундаж
- /61./ Чихрийн шижингийн хэвшинж 2-ын эрсдэлтэй насанд хүрсэн хүмүүст эрт ямар давтамжтай гүйцэтгэх вэ?
- A. Жилд 1 удаа
 - B. Эмнэлэгт ирэх бүрт
 - C. 10 жилд 1 удаа
 - D. 6 жилд 1 удаа
 - E. 3 жилд 1 удаа

/62./ Зонхилон тохиолдох халдварт бус өвчнүүдийн урьдчилан сэргийлэлтийн аль нь үнэн бэ?

А. халдварт бус өвчний хяналтын хамгийн үр ашигтай, тогтвортой арга нь хүнамд суурилсан урьчилан сэргийлэх үйл ажиллагаа юм.

В. халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх гол түлхүүр нь амьдралын хэв маягаа өөрчлөх

С. урьдчилан сэргийлэх маш олон үйл ажиллагааны үр дүн гайхалтай хурдан гардаг

Д. харьцангуй настай хүмүүс ч урьдчилан сэргийлэх боломжтой

Е. дээр дурдсан бүгд орно

/63./ АГ болон ЧШ хавсарсан өвчтөнийг үнэлэхдээ

А. өгүүлэмжийг бүрэн авах

В. зүрх судасны үзлэгийг бүрэн хийх

С. мэдрэлийн үзлэгийг бүрэн хийх

Д. нүдний үзлэгийг бүрэн хийх

Е. Дээрх бүгд

/64./ Чихрийн шижингийн 2-р хэлбэрт тохирох зөв хариултыг дугуйлна уу.

А. урьдчилан сэргийлэх боломжгүй

В. зөвхөн эмээр урьдчилан сэргийлэх боломжтой

С. амьдралын хэв маягийг бага зэрэг өөрчилснөөр урьдчилан сэргийлэх боломжтой

Д. эмийн эмчилгээ хийж, амьдралын хэв маягаа өөрчилснөөр урьдчилан сэргийлэх боломжтой. Эмийн эмчилгээ нь илүү үр дүнтэй

Е. дархлаажуулснаар урьдчилан сэргийлэх боломжтой

/65./ Халдварт өвчний эсрэг дархлаажуулалт гэж юу вэ?

А. Дархлаажуулах насны бүх хүмүүсийг хамрах дархлаажуулалтыг хэлнэ.

В. Халдварт өвчний эсрэг өвөрмөц дархлал бий болгохын тулд вакцин, анатоксин болон сэргийлэх бусад эмийн зүйлийг тархвар судлалын заалтаар хэрэглэхийг хэлнэ.

С. Халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулах бэлдмэл хэрэглэх арга хэмжээг

Д. Халдварт өвчний голомтод халдварт өвчнөөс сэргийлэх, тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зайлшгүй арга хэмжээ

/66./ Дараах хорт хавдрын алийг вакцинаар урьдчилан сэргийлж болох вэ?

А. Хөхний

В. Уушгины

С. Тархины

Д. Умайн хүзүүний

Е. Бөөрний

/67./ Монгол улсын Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого хэдэн онд батлагдсан бэ?

А. 2000

В. 2001

С. 2002

Д. 2003

Е. 2004

/68./ А аминдэмийг нөөцлөгч эрхтэнг нэрлэнэ үү.

А. Уушги

В. Бөөр

С. Элэг

Д. Зүрх

Е. Ясны чөмөг

/69./ Өвчний илрүүлэг урьдчилан сэргийлэлтийн ямар түвшинд хийгддэг вэ?

А. Анхдагч

В. Хоёрдогч

С. Гуравдагч

Д. Бүх түвшинд

Е. Анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн зааг дээр

/70./ Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд аль өвчин орохгүй байгаа вэ?

- A. Цусны эргэлтийн тогтолцооны эмгэг
- B. Шээс, бэлэгсийн өвчин
- C. Амьсгалын тогтолцооны эмгэг
- D. Хоол шингээх эрхтний эмгэг
- E. Хорт хавдар

/71./ АД-ын хамгийн тохиромжтой хэмжээ бол

- A. <120/80 мм МУБ
- B. <130/85 мм МУБ
- C. <140/90 мм МУБ
- D. <160/100 мм МУБ
- E. <140/70 мм МУБ

/72./ Өвдсөн үед цаг алдалгүй эмчлэх нь урьдчилан сэргийлэлтийн аль түвшинд хамаарах вэ?

- A. Анхдагч
- B. Хоёрдогч
- C. Гуравдагч
- D. Дөрөвдөгч
- E. Бүх түвшинд

/73./ Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих гэдэг нь _____ үйл ажиллагаа юм.

- A. Ажилчдын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах
- B. Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах
- C. Ажлын байраар дамжуулан ажиллагсадын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих
- D. Ажлын байранд ажиллагсадын сайн сайхан байдлыг хангах, эрүүл мэндийг дэмжих
- E. Ажилтай холбоотой өвчлөлийг бууруулах

/74./ Илрүүлэг гэж юу вэ?

- A. Өвчнийг оношлох
- B. Шалтгааныг тогтоох
- C. Эрүүл эмгэгийг ялгах
- D. Эмчлэх
- E. Үр дагаварыг судлах

/75./ Чихрийн шижингийн хэвшинж 2-ын эрсдэлгүй 45-75 насны хүмүүст эрт илрүүлэлтийг ямар давтамжтай гүйцэтгэх вэ?

- A. Жилд 1 удаа
- B. Эмнэлэгт ирэх бүрт
- C. 10 жилд 1 удаа
- D. 6 жилд 1 удаа
- E. 3 жилд 1 удаа

/76./ Хүрч очих ажил гэдэг нь...

- A. Зөвхөн гудамж, гэр, шөнийн цэнгээний газарт явагддаг үйл ажиллагаа
- B. Заавал мэргэжлийн хүн хийдэг ажиллагаа.
- C. Үйлчлүүлэгчидтэйгээ байгаа газар нь очиж холбоо тогтоох үйл ажиллагаа.
- D. Зөвхөн тодорхой нутаг дэвсгэрийн хүн амыг мэдээллээр хангах үйл ажиллагаа

/77./ Улаанбурханаар өвчлөгсөд өвчнийхөө аль үед илүү хамгийн их халдвартай байх вэ?

- A. Эдгэрсний дараахь үе
- B. Өвчний нууц үе
- C. Эдгэрэлтийн үе
- D. Ид үе

/78./ Дараахын аль нь сургуульд суурилсан эрүүл мэндийг дэмжихийн жишээ вэ?

- A. Тамхигүй сургууль

- B. Сургуулийн биеийн тамирын дасгалын хөтөлбөр
- C. Эрүүл хооллолтын боловсрол олгох
- D. Сурагч, багш нарын сэтгэл зүйн бүхэмдлыг бууруулах бодлого боловсруулах
- E. Дээрх бүгд

/79./ Дараахь хөтөлбөрүүдийн аль нь хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн хөтөлбөр вэ?

- A. Халдварт өвчний голомтод байсан хүмүүст хавьтал болсноос хойш 2 долоо хоногийн дотор иммуноглобулин тарих хөтөлбөр
- B. Тархинд цус харвасан хүмүүст зориулсан дасгал хөдөлгөөний хөтөлбөр
- C. Түргэн хоолны газруудад зохистой хооллолтын хөтөлбөр хэрэгжүүлэх
- D. Архинаас гарах АА хөтөлбөр
- E. Сэтгэцийн өвчтөнүүдэд зориулсан нийгэм-сэтгэлзүйн нөхөн сэргээх хөтөлбөр

/80./ Дараах дүгнэлтүүдийн аль нь төвийн хандлагыг хэмжсэн зөв дүгнэлт вэ?

- A. Ажиглалтын ихэнх алслагдсан цэг нь ажиглалтын бусад утгаасаа бага утгатай үед өгөгдлийн муруй баруун тал руу хазайсан байна.
- B. Ажиглалтын утгууд зүүн тал руугаа шилжсэн үед дундаж нь медианаасаа их байна.
- C. Өгөгдлүүд тэгш хэмтэй, дунд ба медиан нь адил, мода нь дундажаасаа бага байна.
- D. Ажиглалтын ихэнх алслагдсан цэг нь ажиглалтын бусад утгаасаа их үед медиан нь дундажаасаа бага байна.
- E. Медианы утга нь алслагдсан утгаас шалтгаалж дундажаас илүү амархан өөрчлөгддөг.

/81./ Эрүүл мэндийн судалгааны ёс зүйн зарчмуудыг албан ёсоор анх баталгаажуулсан баримт бичгийг нэрлэнэ үү?

- A. Бельмонтын тайлан
- B. Хельсинкийн деклараци
- C. Лалондын тайлан
- D. Нюрнбергийн код
- E. Алма-Атагийн тунхаг

/82./ АГ-ээс урьдчилан сэргийлэх гол арга хэмжээ бол

- A. АГ-тэй өвчтөний жинг тохиромжтой хэмжээнд хүргэх/барих
- B. АГ-тэй өвчтөний давсны хэрэглээг 6 гр/хоног болтол багасгах
- C. АГ-тэй өвчтөн долоо хоногийн 5-7 хоног, өдөрт 30 мин-аас доошгүй хугацаанд дасгал хөдөлгөөн хийх
- D. АГ-тэй өвчтөнд илчлэг багатай, ногоо ихтэй хоол санал болгох
- E. Хэвийн даралттай хүмүүст дээрх бүгд

/83./ Урьдчилан сэргийлэлтийн тодорхойлолтод аль хариулт тохирох вэ?

- A. Улсын болон бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулалтын оновчтой тогтвортой бүтэц бий болгох.
- B. Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ, мэргэжлийн хяналт, эм хамгамжийн , эрдэм шинжилгээ , сургалтын ажил эрхэлсэн төрийн болон холимог өмчийн, хувийн хэвшлийн байгууллагын бүрэлдэхүүн
- C. Хүн амд эрүүл мэндийн төрөлжсөн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа хийх эрүүл мэндийн лавлагаа тусламж үйлчилгээ эрхлэх оношлогоо эмчилгээний байгууллагын бүтэц.
- D. Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилго чиг үүрэг бүхий байгууллагын бүрэлдэхүүн.
- E. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах бэхжүүлэх, өвчин эмгэгээс сэргийлэх,эрүүл мэндийн боловсрол олгох , сургалт ,эрдэм шинжилгээний ажил явуулах, эрүүл мэндийн сөрөг нөлөөлөх хүчин зүйлыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагаа.

/84./ Баг үр дүнтэй ажиллахын тулд юунаас зайлсхийх вэ?

- A. Гишүүд өөр өөрийн үүрэгтэй байх
- B. Хоорондоо байнга харилцаж нягт уялдаатай байх
- C. Багийн бүх гишүүд ижил тэгш оролцоотой байх
- D. Багийн ахлагчийг онцгой хүндэлж зөвхөн түүгээр шийдвэр гаргуулдаг байх
- E. Багийн зорилго зорилт гишүүн бүрт тодорхой байх

/85./ Дараах өвчний аль халдварт бус өвчин БИШ вэ?

- A. Чихрийн шижин

- B. Зүрхний өвчин
- C. Хорт хавдар
- D. ХДХВ
- E. Элэгний хатуурал

/86./ Эрүүл мэндийн боловсролын одоогийн байдалд дараах нь орно...

- A. зөвхөн эрүүл мэндийн харилцаа холбооны үйл ажиллагаа
- B. зөвхөн хүрээлэн буй орчны хүчин зүйлс
- C. зөвхөн эрүүл мэндийн уулзалт зөвлөгөөн
- D. зөвхөн сургуулийн эрүүл мэндийн боловсрол
- E. эрүүл мэндийг хамарсан бүх төрлийн боловсролын арга

/87./ Хүүхдийн өсөлт хоцролт гэж юуг хэлэх вэ?

- A. Жин/насны үзүүлэлтийг хэлнэ
- B. Хүүхдийн өндөр тухайн насны хэвийн хэмжээнээс бага байх
- C. Ижил өндөртэй байгаа хүүхдүүдтэй харьцуулахад маш бага жинтэй байх
- D. Жин/өндрийн үзүүлэлтийг хэлнэ
- E. Хүүхэд насандаа тохирохгүй байга жинтэй байх

/88./ Амьдралын хэв маяг нь нас баралтын шалтгааны хэдэн хувийг эзэлдэг вэ?

- A. 60%
- B. 35%
- C. 45-50%
- D. 40%
- E. 70%

/89./ Дэлхийн бага орлоготой улс, орнуудын хүн амын өвчлөлийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Тураал
2. Усны чанар, аюулгүй байдал
3. Хамгаалалтгүй бэлгийн харьцаа
4. Дотоод орчны бохирдолт
5. Цусны даралт ихсэх

/90./ Агаарыг бохирдуулагч эх үүсвэрүүдээс хүний үйл ажиллагаатай холбоотой эх үүсвэрүүдийг заана уу?

1. Ойн түймрийн
2. Автомашины
3. Шуурга
4. Хөдөө аж ахуйн
5. Сансрын туяа

/91./ Эрүүл аж төрөх зан үйл гэдэгт юу хамаардаг вэ?

1. Байнгын дасгал хөдөлгөөн хийх
2. Ажил, амралтыг зохицуулах
3. Зохистой хооллох
4. Эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдах
5. Согтууруулах ундааг стандарт хэмжээгээр хэрэглэж хэвших

/92./ Эрүүл мэндийг тодорхойлогч хянах боломжтой хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Хоол хүнс
2. Тамхи татах
3. Дасгал хөдөлгөөн
4. Эмийн зохистой хэрэглээ
5. Стресс

/93./ Эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрхэн ангилдаг вэ?

1. Шууд
2. Албан
3. Шууд бус
4. Албан бус
5. Холимог

/94./ Гараа сайн угааснаар ямар өвчнөөс сэргийлж болох вэ?

1. Халдварт суулгалт
2. Менингит
3. Хепатит А
4. Хепатит В
5. Халдварт саа

/95./ Хоол тэжээлийн хямралын хам шинжүүдийг сонгоно уу.

1. Бага жинтэй төрөлт нэмэгдэх
2. Уураг энергийн дутагдалд орох
3. Биеийн жин өндрийн харьцаа зохисгүй байх
4. Халдварт өвчин нэмэгдэх
5. Хүүхдийн өвчлөл нэмэгдэх

/96./ Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл бичихдээ юу хийх вэ?

1. Судалгаа, үнэлгээ хийх
2. Тухайн чиглэлээр хийгдсэн байсан бусад төслүүдийн мэдээллийг авах
3. Өмнөх төслийн үнэлгээг унших
4. Төсөлд оролцож болох хүмүүстэй уулзаж санаа бодлыг нь сонсох
5. Статистикийн тоо баримтыг үзэх

/97./ Хоёрдогч урьдчилан сэргийлэлтэнд ямар үйл ажиллагаанууд хамаарагдах вэ?

1. Өвчний хүндрэл, тархалтаас сэргийлэх
2. Өвчний тохиолдлыг тусгаарлах
3. Эмчилгээг яаралтай эхлэх
4. Өвчний тохиолдолтой хавьтагсдыг хяналтанд авах
5. Хавьтагсдын дархлалыг сайжруулах

/98./ Мэдээлэл сургалт сурталчилгааны бүтээлч мэдээлэл харилцааны зарчмуудаас сонгоно уу?

1. Анхаарлыг нь татах
2. Мессежээ тодорхой болгох
3. Ашиг тусыг нь хэлж өгөх
4. Итгэлцэл бий болгох
5. Оролцоог дэмжих

/99./ Эпидемийн процессын илрэх хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Дэгдэлт
2. Тахал
3. Алаг цоог
4. Далд хэлбэр
5. Ил тод

/100./ Хөгжилтэй оронд дундаж наслалт нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Халдварт өвчний шалтгаантай эх, хүүхдийн эндэгдэл буурсан
2. Дархлаажуулалтын хамрагдалт сайжирсан
3. Орлого нэмэгдсэн
4. Хотжих явц эрчимтэй хөгжсөн
5. Амиа хорлолт багассан

/101./ НЭМ-ийн мөн чанар юу вэ?

1. Хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх
2. Эрүүл мэндийг дэмжих
3. Зохион байгуулалттай олон нийтийн хүч чармайлт
4. Олон нийтийн оролцоог дайчлах
5. Олон нийтийг чадваржуулах

/102./ Аминдэмийн физиологийн ач холбогдолыг дурдана уу.

1. Нөхөн төлжүүлэх
2. Бодисын солилцоог тохируулах
3. Энергийн үүрэгтэй
4. Бодисын солилцоог идэвхжүүлэх
5. Цус төлжүүлэх

/103./ Бохирлогдсон уснаас хүний бие махбодид хоол боловсруулах замаар орох эмгэг төрөгч нянгуудыг нэрлэнэ үү?

1. Салмонеллёзын үүсгэгч
2. Гепатит А-ын үүсгэгч
3. Шигеллын үүсгэгч
4. Жиардазисын үүсгэгч
5. Менингоэнцефалитын үүсгэгч

/104./ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг юугаар тодорхойлох вэ?

1. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хуваарилалт
2. Нэг их эмчид оногдох хүний тоо
3. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээний давтамж
4. Эмч, мэргэжилтний мэдлэг мэргэжил
5. Эмчилгээ, оношилгооны техник, технологи

/105./ Эрүүл мэндийг дэмжих зарчмуудыг нэрлэнэ үү.

1. Нийт хүн амын өдөр тутмын амьдралд чиглэсэн байдаг
2. Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлсэд чиглэсэн байдаг
3. Бусад салбар хоорондын хамтын ажиллагааг шаарддаг
4. Янз бүрийн боловсронгуй арга хандлагуудыг хэрэглэдэг
5. Олон нийтийн бодитой бөгөөд идэвхтэй оролцоог хангадаг

/106./ Хүнсний бүтээгдэхүүний чанарт ямар бүлэг үзүүлэлтээр үнэлгээ өгдөг вэ?

1. Мэдрэхүйн
2. Физик химийн
3. Нян судлалын
4. Хор судлалын
5. Шимэгч хорхойн

/107./ Эрүүл мэндийн боловсрол олгох түгээмэл зарчмуудаас нэрлэнэ үү?

1. Сонирхолд нийцсэн байх
2. Хийж суралцах, дадал хэвшил болгох
3. Оролцоог дээдлэх
4. Бүрэн цогц байх
5. Сэдэл өгөх

/108./ Илрүүлгийн ямар төрлүүд байдаг вэ?

1. Масс илрүүлэг
2. Өндөр эрсдэл, сонгомол илрүүлэг
3. Олон шатлалт илрүүлэг
4. Тохиолдол олох илрүүлэг
5. Эрүүл бүлгийг ялгах илрүүлэг

/109./ Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөл, хөтөлбөрийн сайтар бичигдсэн зорилт нь дараахь шинжээс алийг нь илэрхийлэх вэ?

1. Та юунд хүрэхийг хүсч байна (эцсийн үр дүн)
2. Та хэрхэн хүрэхийг хүсч байна (арга хэрэгсэл)
3. Хэн гол ашиг хүртэгчэд байх вэ?
4. Хүртээмжтэй үйл ажиллагаа байгаа эсэх
5. Төсөвийг хэрхэн төлөвлөсөн эсэх

/110./ НЭМ-ийн тулгамдсан асуудлыг эрэмбэлэх үндсэн шалгууруудыг нэрлэнэ үү.

1. Эрүүл мэндийн байдлын харьцангуй чухал байдал
2. Урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ хэрэгжих боломж
3. Урьдчилан сэргийлэлтийн хүлээгдэж буй үр дүн
4. Нийгэм, хамт олны сонирхол
5. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

/111./ Хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх стратегийн давуу талуудыг сонгоно уу?

1. Зөвлөгөөг хувь хүнд өгөх нь тохиромжтой байдаг
2. Олон хүнийг хамруулдаг
3. Үр дүн түргэн гардаг
4. Нөлөөлөл сайтай байдаг

5. Эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулдаг
- /112./ Эрүүл мэндийг тодорхойлох гол зүйлүүдэд аль нь хамаарах вэ?
1. Нийгмийн байр суурь
 2. Үйл ажиллагааны чадвар
 3. Эрүүл зан үйл
 4. Бие эрүүл байх
 5. Урт наслалт
- /113./ Хүүхдийн бичил тэжээлийн дутагдалтай тэмцэх нийгмийн эрүүл мэндийн шууд бус арга замуудыг сонгож нэрлэнэ үү.
1. Шинэ төрсөн нярайд А амин дэм уулгах
 2. Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах
 3. Наранд гаргах талаар сургалт явуулах
 4. Сүүг аминдэмжүүлэх
 5. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг зөв хэрэглэх талаар эхчүүдэд сургалт явуулах
- /114./ Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг сонгоно уу?
1. Таргалалт
 2. Жимс, хүнсний ногоо бага хэрэглэх
 3. Цусанд сахар ихсэх
 4. Артерийн даралт ихсэх
 5. Хөдөлгөөний хомсдол
- /115./ Хөгжингүй орнуудын хоол тэжээлийн тулгамдсан асуудлыг заана уу.
1. Хоол тэжээлийн илүүдэл нь сахар хэрэглэх
 2. Амьтны гаралтай өөх тос хэрэглэх
 3. Таргалалт нэмэгдэх
 4. Хүнсний гаралтай харшил нэмэгдэх
 5. Хүнсний нэмэлтүүдийг өргөн ашиглах
- /116./ Хоол тэжээлийн хямралын хам шинжүүдийг сонгоно уу?
1. Бага жинтэй төрөлт нэмэгдэх
 2. Уураг энергийн дутагдалд орох
 3. Биеийн жин өндрийн харьцаа зохисгүй байх
 4. Халдварт өвчин нэмэгдэх
 5. Хүүхдийн өвчлөл нэмэгдэх
- /117./ Хооллох дэглэмд аль нь хамаарах вэ?
1. Тодорхой хэмжээтэй ч нүүрс ус их байх
 2. Тодорхой хэмжээнд хуваагдсан байх
 3. Тодорхой хэмжээтэй ч уураг хангалттай байх
 4. Хооллох цагийг баримталсан байх
 5. Ажлын онцлог тусгагдсан байх
- /118./ Хог хаягдлын менежмент гэдэг ойлголтонд багтах элементүүдийг нэрлэнэ үү?
1. Хадгалах
 2. Халдваргүйжүүлэх
 3. Дахин ашиглах
 4. Зөөвөрлөх
 5. Цуглуулах
- /119./ Эрт илрүүлэгт тавигдах шаардлагыг заана уу.
1. Илрүүлж болохуйц байх
 2. Эрт үеийн эмчилгээ үр дүн сайтай байх
 3. Сорил нь мэдрэг чанар сайтай байх
 4. Сорил нь өвөрмөц чанар сайн байх
 5. Өртгийн хувьд үр дүнтэй байх
- /120./ Зүрх судасны тогтолцооны эмгэгт нөлөөлдөг хүчин зүйлсийг нэрлэнэ үү.
1. Тамхидалт
 2. Согтууруулах ундааны хэт хэрэглээ
 3. Буруу хоололт
 4. Хөдөлгөөний хомсдол

5. Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал
- /121./ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэж ямар ойлголтыг хэлэх вэ?
1. Хүнсний бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд аюул учруулахгүй, энэ нь найдвартай байх шинж чанар
 2. Хүнсний бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх чанар
 3. Хоол, хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж, хэрэглэхэд хүний эрүүл мэндэд хор хөнөөл учрахгүй байх баталгаа
 4. Хоол хүнстэй холбоотой өвчин эмгэг үүсэхгүй байх шинж
 5. Хүнсний хэрэглээтэй холбогдон хоол, хүнсний илүүдэл дутлын шалтгаанаар аюулгүй байдал алдагдах
- /122./ Хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлдөг нийгмийн хүчин зүйлсийг нэрлэнэ үү.
1. Ам бүлийн тоо
 2. Хүйсийн тэгш бусбайдал
 3. Гэрлэлтийн байдал
 4. Мэргэжил
 5. Боловсрол
- /123./ Эрүүл бус зан үйлд хамаарах үйлдлийг нэрлэнэ үү.
1. Хорт зуршлын хэрэглэх
 2. Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох
 3. Эмчийн зөвшөөрөлгүй дур мэдэн эм хэрэглэх
 4. Тоглоомонд донтох
 5. Чихэр, кофенд дурлах
- /124./ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулах зарчимуудыг дурдана уу?
1. Үр дүнтэй байх
 2. Тэгш байдлыг хангах
 3. Шударга байдалд нийцэх
 4. Олон хүнд ашигтай байх
 5. Хүртээмжтэй үйл ажиллагаа байх
- /125./ Хүүхдийн бичил тэжээлийн дутагдалтай тэмцэх нийгмийн эрүүл мэндийн шууд бус арга замуудыг сонгож нэрлэнэ үү?
1. Шинэ төрсөн нярайд А амин дэм уулгах
 2. Хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах
 3. Наранд гаргах талаар сургалт явуулах
 4. Сүүг аминдэмжүүлэх
 5. Сүү сүүн бүтээгдэхүүнийг зөв хэрэглэх талаар эхчүүдэд сургалт явуулах
- /126./ Зохистой хооллох үндсэн зарчмыг нэрлэнэ үү.
1. Өдөр бүр олон төрлийн хоол хүнс хэрэглэх
 2. Хоол хүнсээр авах илчлэгийн хэмжээг хянах
 3. Зохистой харьцаа, хэмжээтэй байх
 4. Гадуур хооллолтоос татгалзах
 5. Эрсдэлтэй хоол хүнснээс болгоомжлох
- /127./ Төслийн нэр оновчтой байх шалгуур нь юу вэ?
1. Төслийн гол утгыг богино хэллэг эсвэл өгүүлбэрээр илэрхийлсэн байна
 2. Төслийн түлхүүр үр дүн эсвэл гол үйл ажиллагааг харуулсан байна
 3. Ямар нэг этгээд үг хэллэг хэрэглэхээс зайлсхийсэн байна
 4. SMART зарчим агуулсан байна
 5. Өвөрмөц зорилтот бүлгийг оруулсан байна
- /128./ Амьдралын хэв маяг гэдэгт юуг хамруулан ойлгох вэ?
1. Дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх
 2. Эрүүл орчинд амьдрах
 3. Эрүүл мэндийн мэдээллийг авч, өөрийн амьдралдаа хэрэгжүүлэх
 4. Зөв зохистой хооллож хэвших
 5. Нарийн мэргэжлийн эмчид тогтмол хандах
- /129./ Халдварт өвчний дамжих замд чиглэсэн урьдчилан сэргийлэх аргыг нэрлэнэ үү?
1. Халдвартай өвчтөнг тусгаарлах

2. Нэг удаагийн бээлий хэрэглэх
 3. Бэлгэвч хэрэглэх
 4. Гарын ариун цэвэр сахих
 5. Дархлаажуулалтад хамруулах
- /130./ Эрүүл олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой сонгоно уу.
1. Эрүүл мэндийг дэмжих таатай орчин бүрдүүлэх
 2. Эрүүл мэндийн боловсрол олгох
 3. Өвчин эсэргүүцэх чадварыг нэмэгдүүлэх
 4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай авах боломжийг олгох
 5. Амьдралын зөв хэв маяг төлөвшүүлэхийг дэмжих
- /131./ Хүнсний бүтээгдэхүүний химийн бодисын бохирдлыг хэрхэн бүлгэлдэг вэ?
1. Хүрээлэн буй орчны гаралтай хүнсний бохирдол
 2. Хүний үйл ажиллагаатай холбоотойгоор экологийн нэгдлүүдээр бохирдох
 3. ХАА-ийн үйлдвэрлэлээс хүнс бохирдох
 4. Хүнсний үйлдвэрлэлийн процесст зорилготойгоор оруулсан химийн бодисоор бохирдох.
 5. Байгалийн гаралтай уг бүтээгдэхүүнд агуулагдах хорт бодис агуулагдсанаас үүсэх бохирдол
- /132./ Нийгмийн эрүүл мэндийн үндсэн үүргээс сонгоно уу?
1. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдүүлэх
 2. Халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг тандах, хянах
 3. Өртөмхий ба эрсдэлтэй ихтэй хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх
 4. Эрүүл мэндийг дэмжих, олон нийтийн оролцоог хангах
 5. Нийгмийн эрүүл мэндийн судалгаа, инновацийг дэмжих
- /133./ Эрүүл мэндийн боловсрол олгох мессеж боловсруулахад анхаарах зүйлийг сонгоно уу.
1. Бидний зорьж буй нийгмийн бүлэг
 2. Сэдэв, чиглэлийг тодорхой болгох
 3. Таны амлалт эсвэл санал болгож буй ашиг тус
 4. Тухайн амлалтад яагаад итгэх ёстой шалтгаан, эсвэл нэмэлт хүч оруулах зүйлс
 5. Ямар үйлдэл хийлгэх
- /134./ Хөгжиж буй орнуудын хоол тэжээлийн тулгамдсан асуудлыг заана уу.
1. Уламжлалт хоол, хүнсний зохисгүй харьцаа
 2. Микроэлементийн дутагдал
 3. Хүнсний аюулгүй ажиллагаа сул
 4. Тураал
 5. Илчлэг өндөртэй хоол хүнсний хэрэглээ
- /135./ Хоол хүнс ямар шаардлагыг хангах хэрэгтэй вэ?
1. Илчлэг, тэжээллэг
 2. Зохистой харьцаатай
 3. Тохиромжтой
 4. Зохистой хэмжээтэй
 5. Эрүүл, аюулгүй байдал хангах
- /136./ Дэлхийн нийтээр урьдчилан сэргийлэх шаардлагатай, тархалт өндөр халдварт өвчнийг нэрлэнэ үү?
1. ХДХВ, ДОХ
 2. Сүрьеэ
 3. Хумхаа
 4. Улаанбурхан
 5. Саа
- /137./ Эрүүл ажлын байр хөтөлбөрийн хувь хүний эрүүл мэндийн чадварыг дээшлүүлэхэд ямар үйл ажиллагаа багтах вэ?
1. Эрүүл хооллолт
 2. Эрүүл зан харилцаа
 3. Бэлгийн эрүүл зан үйл
 4. Эрүүл агаар

5. Эрүүл жорлон
- /138./ НЭМ-ийн үйл ажиллагаанд ямар арга хэмжээ хамаарах вэ? (Винслоу)
1. Гадаад орчны ариун цэвэр
 2. Халдварт өвчний хяналт
 3. Эрүүл мэндийн боловсрол олгох
 4. Өвчнийг эрт оношлох, урьдчилан сэргийлэх, эмчлэх
 5. Амьдралын баталгаа бий болгох
- /139./ Устай холбоотой өвчнөөс сэргийлэх аргуудыг тодорхойлно уу?
1. Найдвартай усан хангамжаар хүн амыг хангах
 2. Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хүн амыг хангах
 3. Хүн амын эрүүл ахуйн боловсролыг дээшлүүлэх
 4. Өвчнийг эрт оношлох
 5. Өвчнийг эрт эмчлэх
- /140./ Хоёрдогч урьдчилан сэргийлэлт гэж юу вэ?
1. Өвчнийг эрт үед нь оношлох зорилгоор хийгдэж буй хувь хүнд чиглэсэн арга хэмжээ
 2. Өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж байгаа бүх үйл ажиллагааг
 3. Өвчний тохиолдлыг тусгаарлаж эмчилгээ эхлэх, түүнчлэн тохиолдолтой хавьтагсдыг хяналтанд авч дархлалыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ
 4. Өвчин эмгэг болон түүний хүндрэлийн улмаас алдагдсан үйл ажиллагааг нөхөн сэргээх, эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг аль болох дээд зэргээр хадгалж үлдэх зорилгоор жинхэнэ эзэн, хүрээлэн буй орчин чиглэгдэн хийгдэж буй арга хэмжээ
 5. Өвчин эмгэг, осол гэмтлийн тохиолдлоос сэргийлэхэд чиглэгдсэн бүх арга хэмжээ
- /141./ Эрүүл зан үйлд хамаарах үйлдлийг нэрлэнэ үү.
1. Хөдөлгөөний идэвхтэй байх
 2. Зохистой хооллох
 3. Эмийг зөв хэрэглэх
 4. Хүүхдээ дархлаажуулалтад хамруулах
 5. Уур бухимдалгүй байх
- /142./ Антропонозын халдварт өвчний эх уурхайд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг сонгоно уу.
1. Эрт оношлох
 2. Тусгаарлах
 3. Эмчлэх
 4. Хязгаарлалтын дэглэм мөрдөх
 5. Эрүүлжүүлэх эсвэл тоо толгойг цөөлөх
- /143./ Химийн хордлого үүсэхэд дараахь хүчин зүйлсээс аль нь илүү нөлөөлөх вэ?
1. Хувийн ариун цэвэр
 2. Хорт бодисын өтгөрүүлэг
 3. Цаг уурын хүчин зүйл
 4. Хорт бодисын ширхэглэг
 5. Ажилчдын нас, хүйс
- /144./ Халдварт бус өвчний анхдагч эрсдлийг нэрлэнэ үү.
1. Тамхи
 2. Архи
 3. Буруу хооллолт
 4. Хөдөлгөөний хомсдол
 5. Таргалалт
- /145./ Илрүүлгийн ямар төрлүүд байдаг вэ?
1. Масс илрүүлэг
 2. Өндөр эрсдэл, сонгомол илрүүлэг
 3. Олон шатлалт илрүүлэг
 4. Тохиолдол олох илрүүлэг
 5. Эрүүл бүлгийг ялгах илрүүлэг
- /146./ НЭМ-ийн зарчмуудыг нэрлэнэ үү?
1. Оролцоо

2. Тэгш байдал
3. Хамтын ажиллагаа
4. Нөөцийн хэмнэлт
5. Тэнцвэрт байдал

/147./ Автомашины ослоос анхдагч урьдчилан сэргийлэлтийн хяналт тавих хэмжүүрийг сонгон уу?

1. Хурд хэтрэлтийг хянах
2. Цусан дах спиртийн хэмжээг хянах
3. Суудлын бүсний хэрэглээг хянах
4. Хүүхдийн аюулгүй суудлыг хянах
5. Ажлын байрны аюулгүй стандартыг хянах

/148./ Таргалалт ямар өвчний эрсдлийн хүчин зүйл болох нь нотлогдсон бэ?

1. Зүрх судасны өвчин
2. Хорт хавдар
3. II хэвшинжийн чихрийн шижин
4. Үргүйдэл
5. Багтраа

/149./ Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хамаарахыг сонгоно уу.

1. Ажлын байран дахь дасгал хөдөлгөөн хийх
2. Ажлын байранд эрүүл мэндийн дэмжих үйл ажиллагаанд ажилчдын оролцоог сайжруулах
3. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах
4. Ажлын байранд тамхидалттай тэмцэх
5. Эрүүл зан үйлийг хэвшүүлэх сургалт хийх

/150./ Зохистой хооллолт гэж юу вэ?

1. Шаардлагатай хоол тэжээлийн бодисууд агуулсан байх
2. Нас, хүйс, газар нутгийн онцлог харгалзсан байх
3. Ажил хөдөлмөр, эрүүл мэндэд тохирсон байх
4. Жин нэмэхгүй байх
5. Амтлаг байх

/151./ Эрүүл мэндийн боловсрол олгох түгээмэл зарчмуудаас нэрлэнэ үү.

1. Сонирхолд нийцсэн байх
2. Хийж суралцах, дадал хэвшил болгох
3. Оролцоог дээдлэх
4. Бүрэн цогц байх
5. Сэдэл өгөх

/152./ Вакцинаар сэргийлж болох өвчнүүдийг нэрлэнэ үү?

1. Сахуу
2. Улаанбурхан
3. Гахайн хавдар
4. Вируст гепатит
5. Томуу

/153./ Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг нэрлэнэ үү?

1. Насжилт
2. 5 хүртэлхи насны хүүхдийн эндэгдэл
3. Хөгжиж байгаа орон дах халдварт өвчнүүд
4. Осол гэмтэл
5. ДОХ

/154./ Ямар халдварт өвчнүүд бохирлогдсон усаар шууд үүсгэгддэг халдварт өвчний бүлэгт багтах вэ?

1. Гепатит А
2. Холер
3. Лептоспироз
4. Хамуу
5. Халуун хумхаа

/155./ Согтууруулах ундааны стандарт хэрэглээ (өдөрт 15-30 г) нь ямар өвчний эрсдлийг бууруулдаг вэ?

1. Тархинд цус харвах
2. Зөнөгрөл
3. Зүрхний дутмагшил
4. Хөхний өмөн
5. Биений юмны мөчлөгийн хямрал

/156./ Эрүүл олон нийтийг бүрдүүлэхийн тулд ямар үйл ажиллагаануудыг хийх ёстой вэ?

1. Өвчин ба осол гэмтлүүдийг тандах, бүртгэх
2. Аюулгүй, цэвэр ус, агаараар хангах
3. Эрүүл зан үйлийг бий болгох
4. Эрүүл мэндийн даатгалд хамруулах
5. Олон нийтийг нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд татан оролцуулах

/157./ Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замыг нэрлэнэ үү.

1. Халдварын эх уурхай / булагт чиглэсэн халдваргүйжүүлэх
2. Дамжих замыг таслан зогсоох
3. Хүн амыг өвчлүүлэхгүй байх чанарыг дээшлүүлэх
4. Эрсдэлт зан үйлийг бууруулах
5. Эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах

/158./ Хоол тэжээлийн бичил бодисын дутлаас урьдчилан сэргийлэх гол аргуудыг дурдана уу.

1. Тухайн аминдэм, эрдэс бодисоор баялаг хоол
2. Баяжуулсан хүнс
3. Эмийн бэлдмэлээр нэмэлтээр хэрэглэх
4. Зохистой хооллолт
5. Шимэгч хорхойн халдвараас сэргийлэх

/159./ Эрүүл мэндийг тодорхойлогч хянах боломжгүй хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

1. Генетик
2. Хүйс
3. Өвчинд өртөмхий байдал
4. Дасгал хөдөлгөөн
5. Илүүдэл жин

/160./ Эмнэлэгтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэрлэнэ үү?

1. Эмнэлгийн ажилчдын дунд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ тогтмол хийх
2. Халдваргүйтгэлийн чанарыг сайжруулах
3. Ажилд шинээр орогчдод үзлэг шинжилгээг тогтмол хийх
4. Эмчилгээнд антиботикийг оновчтой сонгон хэрэглэх
5. Өртөмхий бүлгийг сэргийлэх

/161./ Зан үйлийн өөрчлөлт хийхэд шаардлагатай нөхцлүүдийг сонгоно уу.

1. Өөрчлөлтийг өөрөө санаачлах
2. Ямар зан үйлээ өөрчлөх нь тодорхой байх
3. Шинэ зан үйлийг амьдралын хэвшил болгох
4. Зохицуулах стратеги хэрэглэх
5. Хэрэгжилт бодит байх

**Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын
“Эрүүл мэндийн хууль эрх зүй” –н чиглэлийн жишиг сорилууд**

Сорилын зөв хариулт

1-B, 2-C, 3-D, 4-D, 5-C, 6-D, 7-D, 8-D, 9-E, 10-D, 11-B, 12-C, 13-D, 14-D, 15-A, 16-E, 17-D, 18-A, 19-A, 20-A, 21-D, 22-D, 23-A, 24-D, 25-D, 26-C, 27-B, 28-C, 29-D, 30-B, 31-C, 32-A, 33-C, 34-D, 35-E, 36-B, 37-E, 38-C, 39-E, 40-A, 41-D, 42-C, 43-D, 44-D, 45-A, 46-A, 47-C, 48-E, 49-D, 50-A, 51-D, 52-A, 53-B, 54-C, 55-D, 56-E, 57-D, 58-D, 59-D, 60-C, 61-D, 62-E, 63-A, 64-B, 65-A, 66-A, 67-C, 68-D, 69-B, 70-E, 71-C, 72-E, 73-E, 74-E, 75-C, 76-A, 77-B, 78-E, 79-C, 80-E, 81-C, 82-D, 83-A, 84-E, 85-E, 86-A, 87-A, 88-B, 89-E, 90-E, 91-A, 92-C, 93-E, 94-C, 95-C, 96-E, 97-E, 98-E, 99-B, 100-A, 101-C, 102-A, 103-A, 104-D, 105-E, 106-D, 107-B, 108-B, 109-C, 110-D, 111-C, 112-A, 113-B, 114-E, 115-A, 116-E, 117-E, 118-B, 119-E, 120-E, 121-A, 122-A, 123-C, 124-C, 125-C, 126-E, 127-E, 128-C, 129-E,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлсний нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох бөгөөд тэдгээрийн төрөл, хэмжээ, олгох журмыг ямар субъект батлах вэ?

- A. Эрүүл мэнд, спортын яам
- B. Монгол Улсын Засгийн газар
- C. Эрүүл мэнд, спортын яамны сайд
- D. Тухайн эрүүл мэндийн байгуулага
- E. Батлах шаардлагагүй, эрүүл мэндийн ажилтаны ур чадвараас хамаарна.

/2./ "Эмчлэх" гэж

- A. Аливаа эмгэгийг оношлох, эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмчийн мэргэжлийн үйл ажиллагааг
- B. Өвчнийг оношлох, эдгэрүүлэх, үйлчлүүлэгчийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг
- C. Өвчнийг оношлох, эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг
- D. Өвчин эмгэгийг оношлох, эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмчийн үйл ажиллагааг
- E. Оношлох, эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

/3./ Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц гэж

- A. Даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх зорилготой эрүүл мэндийн яаралтай арга хэмжээ
- B. Даатгуулагчид үзүүлэх оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх гэх мэт үйл ажиллагаа, эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан тусламж
- C. Даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах сувилах, хөнгөвчлөх аргууд

D. Даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ

E. Даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй хөнгөвчлөх тусламж, эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн багц үйлчилгээ

/4./ Донорын хөдөлгөөнийг сурталчилах ажлыг аль байгууллага голчлон гүйцэтгэдэг вэ?

A. Монголын Улаан загалмайн нийгэмлэг

B. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

C. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

D. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, Монголын улаан загалмайн нийгэмлэг хамтран гүйцэтгэнэ

E. НҮБ-ийн хүн амын сан

/5./ Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч нь гадаад улсын эмийн үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай, экспортлогч нь худалдан авагч байгууллагатай ямар гэрээ хийдэг вэ?

A. Арилжааны гэрээ

B. Хөдөлмөрийн гэрээ

C. Худалдааны гэрээ

D. Лицензийн гэрээ

E. Дээрх бүгд зөв

/6./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчээс шийдвэрийг бичгээр авах вэ?

A. Тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч татгалзсан, мэс ажилбар, мэс засал, үр хөндөлт, донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх

B. Тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч татгалзсан, амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй үйлчилгээ үзүүлэх, мэс ажилбар, мэс засал, донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх

C. Тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч татгалзсан, амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй үйлчилгээ үзүүлэх, үр хөндөлт, донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх

D. Тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч татгалзсан, амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй үйлчилгээ үзүүлэх, мэс ажилбар, мэс засал, үр хөндөлт, донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх

E. Үйлчлүүлэгчид сэтгэцийн хувьд эрүүл бус байх

/7./ Донорын үйлчилгээнд доор дурдсан байгууллагаас аль нь хяналт тавих үүрэгтэй вэ?

A. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

B. Эрүүл мэндийн яамтай хамтарч Монголын Улаан Загалмайн нийгэмлэг

C. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

D. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага болон мэргэжлийн хяналтын алба нар

E. Эмнэлгийн чанарын хяналтын алба

/8./ Эмнэлгийн мэргэжилтэний хүлээх үүрэгт эдгээрийн аль нь хамаарахгүй вэ?

A. Мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх

B. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнлэг, энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх;

C. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх

D. Нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалж, өргөсөн тангарагтаа үнэнчээр, өөрийн үүргээ ёс төртэй сахин биелүүлэх

E. Гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюултай байдал бий болсон иргэн, төрөх гэж байгаа эхэд хууль заасан тохиолдолд эмнэлгийн тусламжийг ямар ч нөхцөлд үзүүлэх

/9./ "Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал" гэсэн ойлголтын тодорхойлолтыг нэрлэнэ үү

A. Нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг

В. Улс төр, эдийн засаг, нийгмийн шалтгааны улмаас хүний сэтгэл хөдлөл, сэтгэхүй түр хямрасан байдлыг;

С. Сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, зан үйл сэтгэл хөдлөл түр хямрасан байдлыг;

Д. Нийгэм, улс төр, эдийн засгийн хямралын улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл хямарсан байдлыг;

Е. Нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг;

/10./ Эрүүл мэндийн даатгалын сан гэж

А. Төр, иргэн,хуулийн этгээдээс төлсөн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг хуваалцах зорилгоор бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ

В. Даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн,хуулийн этгээдээс төлсөн хөрөнгийг хэлнэ

С. Даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор иргэнээс төлсөн шимтгэлийн мөнгөн хөрөнгийг хэлнэ

Д. Даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн,хуулийн этгээдээс төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ

Е. Санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн,хуулийн этгээдээс төлсөн шимтгэлийн орлого, мөнгөн хөрөнгийг хэлнэ

/11./ Мэргэжлийн хэвлэл болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж болох бүтээгдэхүүн нь аль нь вэ?

А. Жортой олгох эм

В. Жоргүй олгох эм

С. Мал, амьтанд зориулсан эм

Д. Хүүхдэд зориулсан эм бэлдмэл

Е. Сэтгэцэд нөлөөлөх эм

/12./ Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавигдвал зохих ҮНДСЭН шаардлагыг сонго

А. Үйлдвэрлэлийн дамжлагыг технологийн дагуу удирдан хөтлөх, хянах мэргэжлийн бус боловсон хүчнээр хангагдсан байх

В. Эмийн түүхий эд цэвэр байх

С. Эмийн үйлдвэр өөрийн бүтээгдэхүүний чанарыг хариуцна

Д. Хөдөлмөрийн гэрээ байгуулах

Е. Аюулгүй ажиллах баталгаа гаргаж өгөх

/13./ Хэрэв та ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь нотлогдвол хуулийн дагуу эмчлэх , сувилах эрхээ ямар хугацаагаар хасуулах вэ?

А. 1-3 жил

В. 5 жил хүртэл

С. 2 жил

Д. 6 сараас 1 жил хүртэл

Е. 1 жилээс 5 жил хүртэл

/14./ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль хэзээ шинэчлэгдсэн бэ?

А. 2014.1.30

В. 2015.1.30

С. 2014.1.29

Д. 2015.1.29

Е. 2015.1.28

/15./ “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл” гэж

А. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргахыг

В. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи зэрэгт чанарын үнэлгээ хийж, дүгнэлт гаргахыг

С. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт аудитийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргахыг

D. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт ижил мэргэжилтний хөндлөнгийн үзлэг хийж, дүгнэлт гаргахыг

E. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, магадлан итгэмжлэхийг

/16./ "Сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн үйлчилгээ" гэсэн тодорхойлолтыг нэрлэнэ үү.

A. Гэр оронгүй, тэжээн тэтгэх хүүхэд төрөл садантай ч бие даан амьдрах чадваргүй, ганц бие сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын туршид байрлуулан эмчлэх, сувилах, сэргээн засах үйлчилгээ явуулах эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг

B. Гэр оронтой ч тэжээн тэтгэх хүүхэд төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй, ганц бие сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын туршид байрлуулан эмчлэх, сэргээн засах үйлчилгээ явуулах эрүүл мэндийн үйлчилгээг

C. Гэр оронгүй, тэжээн тэтгэх хүүхэд төрөл садантай ч бие даан амьдрах чадваргүй, сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын туршид байрлуулан эмчлэх, сувилах, сэргээн засах үйлчилгээ явуулах эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг

D. Гэр оронтой ч тэжээн тэтгэх хүүхэд төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй, ганц бие сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын туршид байрлуулан сэргээн засах үйлчилгээ явуулах эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг

E. Гэр оронгүй, тэжээн тэтгэх хүүхэд төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй, ганц бие сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын туршид байрлуулан эмчлэх, сувилах, сэргээн засах үйлчилгээ явуулах эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг

/17./ Даатгалын гэрээ гэж

A. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон иргэн хооронд байгуулсан гэрээ

B. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон иргэн хооронд байгуулсан гэрээ

C. Төр болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээ

D. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээ

E. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон төр хооронд байгуулсан гэрээ

/18./ Цус, цусан бүтээгдэхүүн болон хүний эд, эрхтэний бэлдмэлийн савлалт дээр ямар бичээс байх вэ?

A. Хүний дархлалын хомсдлын вирусийн эсрэг бие агуулаагүй

B. Эд эрхтний бэлдмэл

C. Цус, цусан бүтээгдэхүүн болон хүний эд, эрхтэний бэлдмэл

D. Цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэл

E. Бичээс хийх шаардлагагүй

/19./ "Эмнэлгийн мэргэжилтэн" тодорхойлолтыг сонгоно уу

A. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг

B. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, уламжлалтын их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг

C. Хүний их, бага эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг

D. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг

E. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн эмнэлгийн бусад ажилтныг

/20./ Өвчнийг оношлох, эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг нэрлэнэ үү

A. Эмчлэх

B. Идэвхжсэн голомтыг цомхотгох

- C. Сувилах
- D. Асрах
- E. Бүгд зөв

/21./ Цахим карт гэж

A. Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл , авсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан , эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид олгох цахим гэрчилгээг хэлнэ

B. Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл , авсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан , эрүүл мэндийн даатгалын байгууллагаас даатгуулагчид олгох үнэмлэхийг хэлнэ

C. Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл , авсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан , төрөөс даатгуулагчид олгох цахим гэрчилгээг хэлнэ

D. Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл , авсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан , эрүүл мэндийн даатгалын байгууллагаас даатгуулагчид олгох цахим гэрчилгээг хэлнэ

E. Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл агуулсан , эрүүл мэндийн даатгалийн сангаас даатгуулагчид олгох цахим гэрчилгээг хэлнэ

/22./ Эрүүл мэндийн даатгалын шимтгэл гэж

A. Эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон түүний нэрийн өмнөөс хуулийн этгээд эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх төлбөрийг хэлнэ

B. Эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон түүний нэрийн өмнөөс төр эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх төлбөрийг хэлнэ

C. Эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэний өмнөөс хуулийн этгээд эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх төлбөрийг хэлнэ

D. Эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон түүний нэрийн өмнөөс төр ,хуулийн этгээд эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх төлбөрийг хэлнэ

E. Эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор хуулийн этгээд болон түүний нэрийн өмнөөс төр эрүүл мэндийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр төлөх

/23./ Эрүүл мэндийн тухай хуулийн зорилтод үл нийцэх ойлголт аль нь вэ?

A. Эрүүл мэндийн даатгал, сан, олголт, зохицуулалт

B. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлох

C. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг

D. Иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах

E. Эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаа

/24./ Эрүүл мэндийн даатгал гэж

A. Иргэдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх , эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явдал

B. Хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлж , эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах явдал юм

C. Төр, иргэн хуулийн этгээдэд хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх , эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ

D. Төр, иргэн хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх , эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хэлнэ

E. Төр, иргэн хуулийн этгээдээс эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж, эрүүл мэндийн даатгалын санг урьдчилан бүрдүүлэх , эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явдал юм

/25./ Цусны байнгын донор гэж хэнийг ойлгодог вэ?

A. Цусаа 5 удаа өгсөн иргэнийг

B. Цусаа нийт 3 удаа өгсөн иргэнийг

C. Жилд 3 ба түүнээс дээш удаа цусаа өгөгчийг

D. Жилд 2 ба түүнээс дээш удаа цусаа өгөгчийг

E. Цусаа нийт 2 удаа өгсөн иргэнийг

/26./ Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод дайчлагдан ажилласан иргэнд нөхөн төлбөр, цалин хөлсний зөрүүг эрүүл мэндийн ажилтантай харьцуулахад ямар байдлаар олгох вэ?

A. Олон улсын гэрээнд заасны дагуу олгоно

B. Гэрээ байгуулж ажилласан тохиолдолд олгоно

C. Нэгэн адилаар ялгаваргүй олгоно

D. Үүргээ биелүүлсэн тул олгохгүй

E. Хил дамнасан хөл хорио тул иргэдийг дайчлах боломжгүй

/27./ "Цуврал" гэж юуг хэлэх вэ?

A. технологийн олон удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг

B. үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг

C. үйлдвэрлэлийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцыг

D. үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний чанарыг

E. үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн тоо хэмжээг

/28./ Донороос цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, боловсруулах, тээвэрлэх үйл ажиллагаатай холбогдсон зардлыг хэн хариуцдаг вэ?

A. Донорын зайлшгүй тусламж авах гэж байгаа реципиент

B. Монголын Улаан Загалмайн нийгэмлэг

C. Төр

D. Төрийн бус байгууллагууд

E. Донорын зайлшгүй тусламж авах гэж байгаа реципиентын ар гэрийнхэн

/29./ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөлд дараах хариултуудаас аль нь хамаарахгүй вэ?

A. Сум, тосгоны эрүүл мэндийн төв

B. Амаржих газар

C. Түргэн тусламжийн төв

D. Эм, эмнэлэгийн хэрэгсэл худалдан борлуулах газар

E. Төв эмнэлэг

/30./ Жороор олгох болон эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эмийн мэдээллийг хэнд өгөх вэ?

A. Иргэдэд

B. Эмнэлгийн мэргэжилтэнд

C. Салбар хариуцсан даргад

D. Телевизийн ажилтанд

E. Сонины сурвалжлагчид

/31./ Эмийн сангийн байршил болон үйлчлэх хүрээг тохируулан тогтоох, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохицуулах үүргийг ямар байгууллага хүлээх вэ?

A. Засгийн газар

B. Засаг даргын тамгын газар

C. Нутгийн захиргааны байгууллага

D. УИХ

E. Эмийн байгууллага

/32./ "Эрүүл мэндийн байгууллага" гэсэн тодорхойлолтыг сонгоно уу

A. Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

B. Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг

С. Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий аж ахуйн нэгжийг;

D. Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хувьцаат компанийг;

Е. Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий нөхөрлөлийг;

/33./ Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг ямар хуулиар зохицуулах вэ?

A. Эмийн тухай хууль

B. Хил хамгаалах тухай хууль

C. Гаалийн тухай хууль

D. Ямар нэг хуулиар зохицуулахгүй

E. Эрүүл мэндийн тухай хууль

/34./ "Сэтгэцийн эмч" гэж хэнийг хэлэх бэ?

A. Анагаах ухааны их, дээд сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан эмчийг;

B. Анагаах ухааны боловсрол олгох их сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан хүний их эмчийг;

C. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан хүний их эмчийг;

D. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан хүний их эмчийг;

E. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн хүний их эмчийг;

/35./ "Эм барих" гэж

A. Эм судлалын шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох үйл ажиллагааг

B. Эрүүл мэндийн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох үйл ажиллагааг

C. Анагаах ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох үйл ажиллагааг

D. Эм зүйн стандартын дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох үйл ажиллагааг

E. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох үйл ажиллагааг

/36./ "Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах" гэсэн тодорхойлолтын зөвийг сонгоно уу

A. Иргэд, хамт олны дунд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн цогц арга хэмжээг

B. Хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, сэтгэл зүй, эдийн засгийн цогц арга хэмжээг

C. Хүн өөрөө болон бусадтай хамтран сэтгэцийн эрүүл мэндээ хянах, сайжруулах боломж олгоход чиглэсэн эрүүл зан үйлийг дэмжих арга хэмжээ

D. Өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төвд сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх, лавлагаа, тусламжид илгээх, хяналт тавих арга хэмжээ

E. Сэтгэцийн тулгамдсан асуудал, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгтэй хүнийг орон нутаг, гэр оронд нь ойр байлгаж эмчлэх, сэргээн засах, асрамжийн үйлчилгээ үзүүлэхийг

/37./ "Эрүүл мэндийн ажилтан" тодорхойлолтыг заана уу

A. Хүний их, бага эмч, нүүр-амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг

B. Их эмч, сувилагч, эх баригч, эм найруулагч болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг

C. Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа бусад ажилтныг

D. Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад мэргэжилтнийг

E. Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг

/38./ Тамхины хяналтын хуульд “Дам тамхидалт” гэсэн нэр томъёог хэрхэн тайлбарласан бэ?

A. Бусдын татсан тамхины утаагаар амьсгалах

B. Өөрийн хүсэл зорилгоос үл хамааран татсан тамхины утаагаар амьсгалах

C. Өөрийн хүсэл зорилгоос үл хамааран бусдын татсан тамхины утаагаар амьсгалах

D. Өөрийн болон бусдын татсан тамхины утаагаар амьсгалах

E. Өөрийн татсан тамхины утаагаар амьсгалах

/39./ Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйлд хамаарахгүйг сонго

A. Эм барих зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд оролцуулах

B. Хуурамч эм үйлдвэрлэх, импортлох, худалдах

C. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага иргэдэд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах

D. Ашиг, орлогоо нэмэгдүүлэх зохирилгоор эмчийг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, үр дүнгээр нь урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулах

E. Эм, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эм хангамжийн байгууллагаас авах

/40./ Аль тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болох вэ?

A. Үйлчлүүлэгч сэтгэцийн хувьд чадамжгүй бол

B. Хамтран ажилладаг эмчийн зөвлөснөөр

C. Хамаатан садных нь хүсэлтээр

D. Эмнэлгийн удирдлагуудын шаардлагаар

E. Хууль хяналтын ажилтнуудын шаардлагаар

/41./ Даатгуулагч гэж

A. Эрүүл мэндийн даатгалын санд мөнгө төлж , эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ

B. Эрүүл мэндийн даатгалд шимтгэл тогтмол урьдчилан төлж , эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас нөхөн авах хүн бүрийг хэлнэ

C. Эрүүл мэндийн байгууллагад цалингийн тодорхой хувийг тогтмол төлж , санхүүгийн эрсдэлээ даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ

D. Эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж , эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ

E. Эрүүл мэндийн даатгалын санд шимтгэл тогтмол урьдчилан төлж , санхүүгийн эрсдэлээ уг даатгалын сангаас хуваалцах эрх бүхий иргэнийг хэлнэ

/42./ “Эм” гэж юуг хэлэх вэ?

A. Хүний болон малын өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, амьтан, ургамал, эрдсийн гаралтай, тодорхой тун хэмжээгээр хэрэглэгддэг бодисыг

B. Хүний болон малын өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг, тодорхой тун хэмжээгээр хэрэглэгддэг бодисыг

C. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг

D. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг

E. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зориулалттай, үйлчлэл нь эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, амьтан, ургамал,

эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг

/43./ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэж

A. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан хуулийн этгээд, төрийн байгууллагууд мөн эрүүл мэндийн байгууллага болон эмийн санг

B. Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага болон эмийн санг

C. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагыг

D. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага болон эмийн санг

E. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмийн санг

/44./ Эрүүл мэндийн байгууллагыг ямар хуульд заасан журмын дагуу бүртгэх вэ?

A. Аж ахуйн үйл ажиллганы тусгай зөвшөөрлийн тухай хууль

B. Харьяаллын тухай хууль

C. Эрүүл мэндийн байгууллагын тусгай бүртгэлийн тухай хууль

D. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

E. Аль нь биш

/45./ Гамшгийн үед цус, цусан бүтээгдэхүүн, тэдгээрийг орлох бэлдмэлээр найдвартай хангах, нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах асуудлыг

A. Засгийн газар хариуцна

B. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна

C. Монголын Улаан Загалмайн нийгэмлэг хариуцна

D. Монголын Улаан Загалмайн нийгэмлэгтэй хамтарч, Засгийн газар, Эрүүл мэндийн яам хариуцна

E. УИХ

/46./ Эмнэлгийн мэргэжилтэнд урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах субъектэд хамаарахгүйг ол.

A. Эрүүл мэнд, спортын яам

B. Нутгийн өөрөө удирдах байгууллага

C. Аж ахуйн нэгж, байгууллага

D. Бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал

E. Нутгийн захиргааны байгууллага

/47./ Монгол Улсад хэрэглэгдэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн жагсаалт, тэдгээрийн үйлдвэрлэл, импорт, хадгалалт, худалдааг зохицуулах журмыг хэн батлах вэ?

A. Эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран

B. Эрүүл мэнд спортын яамны төрийн нарийн бичгийн дарга

C. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

D. Монгол улсын ерөнхий сайд

E. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал

/48./ Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлоход дараахь зүйлийг хориглоно гэсэн заалтад үл хамаарахыг ол

A. Монгол Улсад үйлдвэрлэв” гэсэн шошго, стандартын дугаартай эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох

B. Тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд, иргэн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох

C. Эм, эмнэлгийн хэрэгсэл нэвтрүүлэхээр тогтоосон хилийн боомтоос өөр боомтоор эм, эмнэлгийн хэрэгсэл нэвтрүүлэх

D. Импортын болон экспортын лицензийн бичигт заасан нэр, хэлбэр, тун, тоо хэмжээнээс илүү буюу өөр нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх

E. Бүгд зөв

/49./ Эрүүл мэндийн тухай хуульд “эх барих” гэдгийг аль утгаар ойлгох вэ?

A. Төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

В. Төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

С. Төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

Д. Жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

Е. Жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

/50./ "Сэтгэцийн эмгэгтэй хүний нийгэмд аюултай үйлдэл" гэж юуг ойлгох бэ?

А. Сэтгэцийн эмгэгийн улмаас хүн өөрийгөө хянах чадваргүй болж, өөрийн буюу бусдын амь нас, нийгэмд хор хохирол учруулахыг;

В. Сэтгэцийн өөрчлөлтийн улмаас хүн өөрийгөө хянах чадваргүй болж, өөрийн амь нас, нийгэмд хор хохирол учруулахыг;

С. Сэтгэцийн өвчний улмаас хүн өөрийн буюу бусдын амь нас, нийгэмд хор хохирол учруулахыг;

Д. Гэнэтийн цочирлын улмаас хүн өөрийгөө хянаж чадахгүй болж өөрийн амь нас, нийгэмд хор хохирол учруулахыг;

Е. Сэтгэцэд гэнэтийн өөрчлөлт орж бусдын амь насанд хохирол учруулахыг;

/51./ "Эх барих" гэж

А. Харьяалах нутаг дэвсгэрт жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

В. Монгол улсад жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

С. Жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эмнэлгийн мэргэжилтний цогц үйл ажиллагааг

Д. Жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

Е. Жирэмсний, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайн өвчин эмгэгийг оношлох, хянах, төрөлтийг удирдах, эмчлэх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

/52./ Заавал хийх дархлаажуулалтад ямар тарилга орох талаар дархлаажуулалтын тухай хуулинд дурьдсан бэ?

А. Сүрьеэ, халдварт саа (полимиелит), В вируст гепатит, сахаруу, хөхүүл ханиад, татран, улаан бурханы эсрэг сэргийлэх тарилгууд

В. Сүрьеэ, халдварт саа (полимиелит), сахаруу, хөхүүл ханиад, татран, улаан бурханы эсрэг сэргийлэх тарилгууд

С. Сүрьеэ, халдварт саа (полимиелит), В вируст гепатит, сахаруу, хөхүүл ханиад, татран, галзуу, улаан бурханы эсрэг сэргийлэх тарилгууд

Д. Сүрьеэ, халдварт саа (полимиелит), В вируст гепатит, сахаруу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгууд

Е. Сүрьеэ, халдварт саа (полимиелит), А вируст гепатит, сахаруу, хөхүүл ханиад, татран, улаан бурханы эсрэг сэргийлэх тарилгууд

/53./ Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг хаанаас тогтоох вэ?

А. УИХ

В. Засгийн газар

С. Эрүүл мэнд спортын яам

Д. Хил хариуцсан газар

Е. Хотын дарга

/54./ Заавал хийх дархлаажуулалтанд аль нь хамрагдах вэ?

А. Халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулах бэлдмэл

В. Хүн амд халдварт өвчний эсрэг өвөрмөц дархлалыг бий болгохын тулд хэрэглэж буй дархлаажуулах бэлдмэл

С. Сүрьеэ, халдварт саа /полиомиелит/, В вируст гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаанбурхан, В хэв шинжийн хемофиллюс инфлюэнза нянгийн халдвар, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга

Д. Хүн амын дархлалын ерөнхий түвшин буурахаас сэргийлж, урьд нь заавал хийх дархлаажуулалтад хамрагдсан эсэхийг үл харгалзан дархлаажуулах бэлдмэл

Е. Сэргийлэх тарилгын үндэсний товллолд орсон болон тархвар судлалын заалтаар хийх сэргийлэх тарилга

/55./ Нарийн төвөгтэй оношлогооны арга хэрэглэх, мэс засал хийх хугацааг хойшлуулах нь ямар тохиолдолд тухайн асуудлыг эмч, эмнэлгийн байгууллага шууд шийдвэрлэж болох вэ?

А. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд

В. Дээд шатны байгууллагаас бүрэн эрх олгосон тохиолдолд

С. Тусгай субъектийн хувьд учирсан

Д. Өвчтөний амь насанд аюул учруулж болзошгүй тохиолдолд

Е. Дээрх бүгд зөв

/56./ Донорын тухай хууль тогтоомж зөрчигчид ямар субъект хариуцлага хүлээлгэх вэ?

А. Эмнэлгийн чанарын хяналтын албаны дарга

В. Эмнэлгийн захирал

С. Прокурор

Д. Мэргэжлийн хяналтын албад

Е. Улсын байцаагч болон шүүгч

/57./ Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна хориглох зүйлсд үл хамаарахыг ол.

А. хүүхдэд хандсан эмийн сурталчилгаа явуулах

В. эмийг импортлох, худалдах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах

С. жороор олгох эмийг сурталчлах

Д. Эмийн гаж нөлөөг анхааруулах

Е. Эмийг ховор, чухал, цорын ганц, маш идэвхтэй, үр дүн нь бусад эмээс илүү, аюулгүй, гаж нөлөөгүй, шинэ эм, патентлагдсан гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх

/58./ Эрүүл мэндийн даатгалын байгууллага гэж

А. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж , эрүүл мэндийн тусламж , үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд

В. Эрүүл мэндийн тусламж , үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд

С. Эрүүл мэндийн даатгалыг бүрдүүлж , даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж , үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд

Д. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж , даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж , үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд

Е. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж , даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж , үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд

/59./ “Мансууруулах эм” гэж юуг хэлэх вэ?

А. “Мансууруулах эмийн тухай” 1962оны Нэгдсэн Конвенцийн жагсаалтад орсон эм бэлдмэлийг

В. Хүний тархины бор гадаргууд үйлчилж, төв мэдрэлийн тогтолцоог алдагдуулагч бүхий эм бэлдмэл

С. " Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт"-д орсон эм бэлдмэл

Д. Донтуулах нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Нэгдсэн Конвенцийн жагсаалтад орсон эм бэлдмэлийг;

Е. Хүний бие махбодийн үйл ажиллагааг дэмждэг зайлшгүй шаардлагатай эрдэс бодисоор баялаг эм бэлдмэлийг

/60./ "Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих" гэсэн тодорхойлолтыг нэрлэнэ үү.

А. Хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, сэтгэл зүй, эдийн засгийн цогц арга хэмжэ

В. Нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг

С. Хүн өөрөө болон бусадтай хамтран сэтгэцийн эрүүл мэндээ хянах, сайжруулах боломж олгоход чиглэсэн эрүүл зан үйлийг дэмжих арга хэмжээг

Д. Иргэд, хамт олны дунд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн цогц арга хэмжээг

Е. Итгэлтэй хэн нэгэн хүнд өөрийнхөө бүхий л мэдрэмжээ нээн хэлж байгаа үйл явц /61./ Төлбөрийн арга гэж

А. Эрүүл мэндийн тусламж ,үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалаас төлөх тооцооны хэлбэрийг хэлнэ

В. Эрүүл мэндийн тусламж ,үйлчилгээний зардлын төлбөрийг төрөөс төлөх тооцооны хэлбэрийг хэлнэ

С. Эрүүл мэндийн зардлын төлбөрийг иргэн хуулийн этгээдээс өөрийн болон эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх тооцооны хэлбэрийг хэлнэ

Д. Эрүүл мэндийн тусламж ,үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх тооцооны хэлбэрийг хэлнэ

Е. Эрүүл мэндийн тусламж ,үйлчилгээний зардлын төлбөрийг хуулийн этгээдээр төлүүлэх хэлбэрийг хэлнэ

/62./ Эмнэлгийн мэргэжилтэн иргэнд нарийн төвөгтэй оношлогоо, мэс засал хийх, анагаах ухааны судалгаа, туршилтад оруулахдаа зөвшөөрлийн бичгийг хэнээс авах вэ?

А. Эцэг, эхээс

В. Асран хамгаалагчаас

С. Харгалзан дэмжигчээс

Д. Ерөнхий эмчээс

Е. Иргэнээс

/63./ Эрүүл мэндийн ажилтныг жилд хэдэн удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд төлбөргүй хамруулах вэ?

А. Нэг удаа

В. Хоёр удаа

С. Улиралд нэг удаа

Д. Зохиох хөнгөлөлттэйгээр нэг удаа

Е. Аль нь биш

/64./ Эрүүл мэндийн удирдлагын тогтолцоо нь

А. Монгол Улсын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

В. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

С. Монгол Улсын Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

Д. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

Е. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

/65./ Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журмыг хэн батлах вэ?

А. Эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

В. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал

- C. Эрүүл мэнд спортын яамны төрийн нарийн бичгийн дарга
- D. Тухайн харилцагч талууд
- E. УИХ

/66./ Эрүүл мэндийн хуульд “эрүүл мэнд” хэмээх нэр томъёог ямар утгаар тайлбарласан байдаг вэ ?

A. Хүн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг

B. Хүн өвчин эмгэггүй төдийгүй нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх

C. Хүн өвчин эмгэггүй төдийгүй оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх

D. Хүн өвчин эмгэггүй төдийгүй бие бялдар, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх

E. Хүн өвчин эмгэггүй , оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байх

/67./ Эм найруулах стандартын шаардлага хангасан эмийн санд эм зүйн технологийн дагуу эм найруулах үйл ажиллагааг хэн гүйцэтгэх вэ?

- A. Боловсон хүчин
- B. Эмийн санч
- C. Эм барих эрх бүхий мэргэжилтэн
- D. Эмнэлгийн эм зүйн албаны мэргэжилтэн
- E. Эмийн сангийн захирал

/68./ “Зан үйлийн эмгэг” гэж юуг нэрлэх вэ?

A. Нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээ, эрх зүй, ёс заншил, харилцаа, амьдралын эрүүл хэв маягийн хэм хэмжээг баримталдаггүй байдлыг

B. Ёс заншилд тулгуурласан нийгмийн хэм хэмжээ, дүрэм журмыг сахин хамгаалдаг хамт олоны дунд дасан зохицох чадваргүй байдлыг

C. Нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрүүл амьдралын хэв маягийн хэм хэмжээг баримталдаггүй, нийгэм, хамт олны дунд дасан зохицох чадваргүй байдлыг

D. Нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүй, ёс заншил, харилцаа, сахилга бат, амьдралын эрүүл хэв маягийн хэм хэмжээг баримталдаггүй, нийгэм, хамт олны дунд дасан зохицох чадваргүй байдлыг

E. Нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүй, ёс заншил, харилцаа, сахилга бат, амьдралын эрүүл хэв маягийн хэм хэмжээг баримталдаг, нийгэм, хамт олны дунд дасан зохицох чадвартай байдлыг

/69./ “Сувилах” гэж

A. Өвчнийг эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засахад чиглэсэн сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

B. Өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засахад чиглэсэн сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

C. Өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эдгэрүүлэх, эмчлүүлэгчийг сэргээн засахад чиглэсэн сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

D. Өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эдгэрүүлэх, сэргээн засахад чиглэсэн сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

E. Өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, өвчнийг эдгэрүүлэх, өвчтөнийг сэргээн засахад чиглэсэн сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг

/70./ Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй асуудал гарвал эцсийн шийдвэрийг хэн гаргах вэ ?

- A. Эмч нарын зөвлөлгөөний шийдвэр
- B. Зөвлөх эмч

- C. Үйлчлүүлэгч
- D. Тасгийн эрхлэгч
- E. Эмчлэгч эмч

/71./ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дараах төрөлтэй байна:

1. Чанар, нөөц нь тогтоогдсон рашаан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг ашиглаж сэргээн засах тусламж, үйлчилгээ
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;
3. Хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн үйлчилгээ;
4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
5. Эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;

/72./ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эх үүсвэр аль нь вэ?

1. Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл
2. Ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл
3. Эрсдэлийн нөөцийг хадгалуулсны хүү
4. Сангийн чөлөөт үлдэгдлийн хүү
5. Төр даатгалыг хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл

/73./ Төлбөрийг нь төр хариуцахаар зохицуулсан иргэний эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамаарах нь аль нь вэ?

1. Төрсний дараах 45 хоногт эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг
2. Сэтгэцийн эмгэгийн зарим эмчилгээ
3. Гамшигийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
4. Удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал
5. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ.

/74./ Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээ;
2. Амбулаторийн;
3. Нийгэм, хамт олонд түшиглэсэн;
4. Хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн;
5. Сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн;

/75./ Эрүүл мэндийн албан журмын даатгалын зарчим

1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг иргэн ,төр хуулийн этгээд зөвхөн эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулна
2. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг иргэн , төр, хуулийн этгээд энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэл , журмын дагуу хариуцна.
3. Эрүүл мэндийн чанартай , аюулгүй , тэгш хүртээмжтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх
4. Даатгуулагчийн төлсөн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах эв санааны нэгдлийн зарчимд тулгуурлана
5. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь ирсэн өргөдөл мэдээллийг хүлээж авж хариу өгнө

/76./ Төлбөрийг нь төрөөс санхүүжүүлэх тусламж үйлчилгээнүүдийг сонгоно уу

1. Хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал
2. Сэтгэцийн эмгэгийн эмчилгээ/ оношийн бүлгээр/
3. Бэлгийн хүчирхийллийн улмаас хохирогчдын сэтгэцийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ
4. Нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн эмчилгээ
5. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас оюутнуудад үзүүлэх тусламж үйлчилгээ

/77./ Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар "эмнэлгийн мэргэжилтэн" гэдэгт дараахь этгээдүүдээс аль нь багтах вэ?

1. Гуравдугаар эмнэлэгийн сувилагч Дулам
2. Сум дундын эмнэлэгийн хүний их эмч
3. Монгол эм импексийн эм зүйч

4. Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн ажилтан

5. Анагаахын их, дээд сургуулийн оюутан

/78./ Аймаг, нийслэлийн Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Төрийн албаны тухай хуулийн дагуу томилох, чөлөөлөх;

2. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

3. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад нэмэлт санхүүжилт олгох;

4. Тухайн шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлаар эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөх;

5. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

/79./ Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамаарахыг заана уу

1. Нийгмийн халамжийн дэмжлэг хүссэн хүн бүрт тусламж үйлчилгээ үзүүлэх

2. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ

3. Орон гэргүй хүмүүст үзүүлэх тусламж үйлчилгээ

4. Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ

5. Зөвхөн ялтнуудад үзүүлэх тусламж үйлчилгээ

/80./ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаануудаас аль нь хамаарах вэ?

1. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлогоо, эмчилгээний үйлдэл, ажилбар хийх, мэргэжлийн дүгнэлт гаргах, хянах, сэргээн засах, сэхээн амьдруулах тусламж үзүүлэх цогц үйл ажиллагаа

2. Цочмог өвчин, эмгэг, осол, гэмтэл, хордлого, төрөх үед эмнэлгийн яаралтай анхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлэн, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ

3. Гэнэтийн өвчин, осол, гэмтэл, хордлого болон төрөх үед хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ

4. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг эрүүл мэндийн байгууллагад зориулалтын унаагаар тээвэрлэн хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ

5. Өвчин, эмгэг, гэмтэл бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ

/81./ Эрүүл мэндийн даатгалын төрөл аль нь вэ

1. Гэнтийн ослын даатгал

2. Албан журмын даатгал

3. Бие эд эрхтэний хэсэгчилсэн даатгал

4. Сайн дурын нэмэлт даатгал

5. Давхар даатгал

/82./ “Эм” гэдэг нэр томъёог хуулинд хэрхэн заасан бэ

1. Хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар амьд бие, бие махбодь, түүний эд, эсээс болон лабораторийн аргаар гаргаж авсан бүтээгдэхүүн

2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор тодорхой тун, хэмжээгээр хэрэглэдэг, уламжлалт анагаах ухааны жорын дагуу ургамал, амьтан, эрдсийн гаралтай бодис болон үнэт эрдэнэс оруулан уламжлалт болон үйлдвэрийн аргаар бэлдсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүн

3. Эмийн тухай хууль болон олон улсын нэгдсэн конвенцийн жагсаалтад орсон эм бэлдмэл

4. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэл

5. Хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, сувилах болон бие махбодийн бүтэц, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг туслах зориулалттай бүтээгдэхүүн

/83./ Шинээр бүтээсэн эх орны эмийг хэрхэн хэрэглээнд гаргах вэ?

1. Эмнэлзүйн өмнөх судалгаанд хамруулах
2. Эмийн бүртгэлд бүртгэх
3. Эмнэлзүйн туршилтад хамруулах
4. Эмнэлзүйн дараах судалгаанд хамруулах
5. Эмийн сантай гэрээ байгуулах

/84./ Өрхийн эрүүл мэндийн төв нь

1. Хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.

2. Өрхийн эрүүл мэндийн нэг төвд ногдох иргэний тоог Засгийн газар тогтооно.

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батална.

4. Өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхэд төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг төлбөргүйгээр ашиглах журмыг хуулиар тогтооно.

5. Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, зохион байгуулалтын асуудлыг Иргэний хууль[4] болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна

/85./ Монгол Улсын Их Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох;

2. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

3. Онц байдлын үед хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалах асуудлаар эрүүл мэндийн байгууллага, иргэн, бусад байгууллагын үүргийг тодорхойлох;

4. Эрүүл мэндийн асуудлаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, цуцлах асуудлыг шийдвэрлэх

5. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

/86./ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх, үүрэг

1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах

2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, зардал болон бусад мэдээллийг бүртгэх, хадгалах, эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдээлэх

3. Даатгуулагчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай, түргэн, шуурхай үзүүлэх, даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах

4. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах

5. Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагааг тайлагнах

/87./ 2013 онд шинэчлэн найруулсан "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" хуулийн 3-р зүйлд ямар нэгэн нэр томъёог нэмэн оруулсан бэ?

1. "Албан ажлын сэтгэлзүйн хэм хэмжээ"

2. "Эмнэлзүйн сэтгэлзүйч"

3. "Сэтгэл засалч"

4. "Сэтгэцийн эмгэгтэй хүнийн нийгэмд аюултай үйлдэл"

5. "Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих"

/88./ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн эрх аль нь вэ ?

1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, дүрмийг батлах

2. Эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол зөвлөмж гаргах

3. Эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шинжээч даатгуулагч, хамтрагч талуудыг оролцуулан байнгын болон түр ажиллагаатай ажлын хэсэг байгуулах, ажлын үр дүнг хэлэлцэх

4. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагаас ирсэн асуудлыг шийдвэрлэх

5. Үндэсний зөвлөлийн гишүүдийн цалин, нэмэгдэл цалин олголтийг тогтоох
/89./ Даатгуулагч ямар тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг өөрөө хариуцах вэ?

1. Гоо сайхны үйлчилгээ
2. Өөрийн хүсэлтээр хийлгэсэн нэмэлт тусламж үйлчилгээ
3. Гадаад улсын засгийн газрын тэтгэлгээр суралцахад эрүүл мэндийн дүгнэлт гаргуулахад шаардагдах шинжилгээ, үйлчилгээ
4. Аялал жуулчлал, хувийн болон албаны ажлаар гадаад улсад зорчих иргэдэд хийх урьдчилан сэргийлэх тарилга
5. Даатгуулагчийн хүсэлтээр нийслэл хот болон аймгийн төвийн онгоц, галт тэрэгний буудал, ар гэрт нь хүргэх эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ

/90./ Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн дор дурдсан үүрэг хүлээнэ:

1. Сэтгэцийн эмгэгтэй хүн, түүний хууль ёсны төлөөлөгч нь эмчилгээ, шинжилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд эмчилгээ, шинжилгээг хийлгээгүй буюу тэдгээрийг зогсоосноос гарч болзошгүй үр дагаварыг танилцуулах;
2. Сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоонд тухайн үед баримталж байгаа өвчний олон улсын ангилалд заасан шалгуурыг хэрэглэх;
3. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг сэтгэцэд нөлөөт эмээр эмчлэхдээ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон Монгол Улсын эмийн бүртгэлийг мөрдөх;
4. Иргэний эрх зүйн чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүнээс, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчөөс эмчилгээ, үйлчилгээний чанарын талаар үнэлгээ авч байх;
5. Эмнэлэгт эмчлэгдээд гарсан сэтгэцийн эмгэгтэй хүнд үзүүлэх сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээг түүний хууль ёсны төлөөлөгч болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

/91./ Эрүүл мэндийн байгууллагын дүрэмд дараах зүйлсээс алийг нь тусгах ёстой байдаг вэ?

1. Хөрөнгийн зарцуулалт
2. Удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ
3. Санхүүжилтийн эх үүсвэр
4. Эмч, ажилчидийн ур чадварыг үнэлэх, урамшуулах арга зүй
5. Ажилчдын баримтлавал зохих ёс зүйн хэм хэмжээ

/92./ Эрүүл мэнд спортын сайд нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1. Эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох
2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх
3. Хүн амд тусламж үйлчилгээ үзүүлэх
4. Эмийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулж, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх
5. Үндэсний хөтөлбөр баталж, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

/93./ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар аль бүрэн эрхийг хэрэгжүүлэх вэ?

1. Эрүүл мэндийн ажилтныг төгсөлтийн дараах сургалтад хамруулах, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах
2. Эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх
3. Иргэний эрүүл мэндээ хамгаалах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах
4. Аймгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах
5. Эрүүл мэндийн асуудлаар төрийн бус байгууллагатай харилцах

/94./ Сэтгэцийн эмгэгтэй хүнийг дараах тохиолдолд албадан эмчилнэ:

1. Өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийж байгаа өвчтөнийг хамгаалах зорилгоор;
2. Өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийхийг завдаж байгаа тохиолдолд урьдчилан сэргийлэх зорилгоор;
3. Эмчилгээ, шинжилгээ нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэцийн байдалтай тохирч байгааг эмнэлгийн эрх бүхий мэргэжилтэн нотолж байгаа үед

4. Өөрөө болон түүний хууль ёсны төлөөлөгч нь эмчилгээ, шинжилгээний талаар зөвшөөрөл өгөх боломжгүй бөгөөд эмчилгээ, шинжилгээ нь тухайн хүний эрүүл мэнд, сэтгэцийн байдалтай тохирч байгааг эмнэлгийн эрх бүхий мэргэжилтэн нотолж байгаа үед

5. Өөрөө болон түүний хууль ёсны төлөөлөгч нь эмчилгээ, шинжилгээний талаар зөвшөөрөл өгөх боломжгүй үед

/95./ Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

1. Өөрийн болон бусдын сэтгэцийн эрүүл мэндийг эрхэмлэн үзэж, ажиллаж, суралцаж, амьдарч байгаа орчиндоо зөв харилцаа, таатай нөхцөлийг бүрдүүлэх

2. Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчид дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах

3. Сэтгэцийн эмгэгтэй хүний бие даан амьдрах, нийгмийн амьдралд оролцоход нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх

4. Албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод дүрэм, журам, хамтын гэрээнд тусган мөрдөж ажиллах, хамт олныхоо сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, тайван ажиллах орчныг бүрдүүлэх, энэ чиглэлээр бусад байгууллагаас зохион байгуулж байгаа нийтийг хамарсан

5. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг цээрлэх

/96./ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

2. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэн дүгнэлт өгөх;

3. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хөтөлбөр, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;

4. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний хамтын оролцоог хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

5. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

/97./ Сэтгэцийн эмгэгтэй хүний хувийн мэдээллийг ямар тохиолдолд зөвшөөрөлгүйгээр өгч болох бэ?

1. Сэтгэцийн эмгэгтэй хүний амь насанд нь аюул тулгарсан үед яаралтай мэдээлэл хэрэгтэй болсон;

2. Тухайн этгээдэд өөрт нь болон бусдад хор уршиг учрах магадлалтай тохиолдолд;

3. Нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах;

4. Эрүүл мэндийн болон хуулийн байгууллагын албан хэрэгцээнд;

5. Эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор

/98./ Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

2. Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах;

3. Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах;

4. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих

5. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх

/99./ Даатгуулагчийн эрх, үүрэг

1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас сонгож үйлчлүүлэх

2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд өөрөө шууд төлсөн төлбөрийн баримтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагаас гаргуулах

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, зардлын төлбөр, төлбөрийн хөнгөлөлтөд хяналт тавих

4. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, улсын байцаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх

5. Хугацаат цэргийн албан хаагчид үнэгүй даатгалд хамрагдах
/100./ Эм хангамжийн байгууллагад дараахь байгууллага хамаарна

1. Эмийн сан

2. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага

3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр

4. ХАА-н эм борлуулалтын байгууллага

5. Эрүүл мэнд спортын яам

/101./ Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн эрх, үүрэг

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн хэмжээгээр даатгуулагчийн төлөх төлбөрөөс хасч тооцох

2. Эрүүл мэндийн даатгалын хяналт шалгалтад шаардагдах баримт бичгийн хуулбарыг холбогдох байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулах

3. Даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, тариа, материалын зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөр, үр дүнд хяналт тавих, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх

5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтны буруугаас даатгуулагчид учирсан хохиролыг хууль тогтоомжийн дагуу нөхөн төлөх

/102./ Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт аль нь вэ?

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд иргэн, хуулийн этгээд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлж болно

2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд төрийн болон хөндлөнгийн аудитын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина

3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дотоод хяналтын нэгжтэй байх ба дотоод хяналтын нэгжийн дүрмийг эрүүл мэндийн даатгалын байгууллага баталж мөрдөнө

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмж, боловсруулж, хэрэгжүүлэх

5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн талаар даатгуулагчийн гаргасан өргөдөл, мэдээлэл, гомдол, саналыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэх

/103./ Амьд донор нь ямар шалгуурыг бүрэн хангасан байх ёстой вэ?

1. Сэтгэцийн хувьд эрүүл

2. 18 насанд хүрсэн байх

3. Шаардлагатай шинжилгээ хийлгэсэн, эд, эрхтэнээ өгөх зөвшөөрлөө бичгээр өгсөн байх

4. Ар гэрийнхнээсээ бичгээр зөвшөөрөл авсан байх

5. 16 насанд хүрсэн байх

/104./ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна:

1. Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

2. Хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна

3. Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

4. Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

5. Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хамаарна.

/105./ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг, чөлөөлөх үндэслэл

1. Үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн, үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон
2. Хурлыг гурван удаа дараалан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан
3. Бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө чөлөөлгөх хүсэлтээ гаргасан
4. Гэмт хэрэгт холбогдож гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон
5. Төлөөлж байгаа тал нь эгүүлэн татсан

/106./ Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар "эрүүл мэнд" гэх нэр томъёог ойлгох зөв утга аль нь вэ?

1. Хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа , нийгмийн амьдралын хувьд сайн сайхан, сэтгэл ханамжтай байхыг
2. Өвчин, эмгэггүй, оюун санаа , нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг
3. Өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа , нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг
4. Хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа , нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг
5. Бүх утга буруу

/107./ Аль нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогод багтах вэ?

1. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн зарим төрлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах
2. Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх
3. Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрүүл мэндийн байгууллагад адил тэгш хандах
4. Хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах;
5. Хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

/108./ Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтанд аль нь хамаарах вэ?

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар , үр дүнг харгалзан даатгалын гэрээтэй эрүүл мэндийн тусламж ,үйлчилгээ үзүүлэгч байгууллагад олгох урамшууллын зардал
2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал
3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний зардал
4. Эрүүл мэндийн даатгалд хамруулахтай холбоотой мэдээлэл сурталчилгааны зардал
5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал

/109./ Эрүүл мэндийн байгууллагын тусгай эрх гэдэгт аль нь хамаарах вэ?

1. Иргэн болон байгууллагын буруутай үйлдлээс болсон осол гэмтэл, хордлого зэргээс үүдэн эрүүл мэндийн байгууллагаас гарсан гэнэтийн зардлыг Иргэний хуульд нийцүүлэн буруутай этгээдээр нөхөн төлүүлэх
2. Эхийн хэвлий дэх ураг удамшлын болон бие эрхтний гаж хөгжилтэй болох нь тогтоогдсон үед жирэмсэн эх, шаардлагатай гэж үзвэл түүний нөхөр буюу гэр бүлийн гишүүнээс бичгээр зөвшөөрөл авч , жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалж болно.
3. Мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих
4. Жирэмслэлт нь эх, ургийн амь насанд ноцтой аюул учруулж болох онцгой нөхцөлд жирэмсэн эх, шаардлагатай гэж үзвэл түүний нөхөр буюу гэр бүлийн гишүүнээс бичгээр зөвшөөрөл авч , жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалж болно
5. Хүн амын эрүүл мэндтэй холбогдсон асуудлыг мэргэжлийн дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

/110./ Эрүүл мэндийн байгууллагын үүрэгт аль нь багтахгүй вэ?

1. Үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах
2. Хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах

3. Эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4. Иргэн болон байгууллагын буруутай үйлдлээс болсон осол гэмтэл, хордлого зэргээс үүдэн эрүүл мэндийн байгууллагаас гарсан гэнэтийн зардлыг Иргэний хуульд нийцүүлэн буруутай этгээдээр нөхөн төлүүлж, төсөвт заавал төвлөрүүлэх

5. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, мэргэжлийн дээд шатны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх

/111./ Утаат тамхийг хаана татахыг хориглох вэ?

1. Стандартаар тогтоосон газарт
2. Олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар
3. Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт
4. Бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэлд
5. Цэцэрлэгт хүлээнгийн хажууд

/112./ Эмч, эмнэлгийн байгууллага магадлагаа гаргах асуудалд аль нь хамаарах вэ?

1. Хүн өвчлөх, осол, гэмтэлд өртөх, нас барах, төрөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувилуулах, хөл хоригдох, өвчтөн асрах

2. Цогцост задлан шинжилгээ хийсэн тухай дүгнэлт гаргах
3. Хөдөлмөрийн чадвараа хагас болон бүрэн алдах
4. Эмнэлэгийн байгууллага өөрийн эмч, ажилтанд цалин, урамшуулалын талаар
5. Бүгд хамаарна

/113./ Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар төрийн бүх шатны байгууллага тус тусын эрх хэмжээний хүрээнд ямар үүрэг хүлээх бэ?

1. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эмгэгээс сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг зохион байгуулах

2. Архидан согтуурах, мансуурах, донтох зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс сэргийлэх, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, хэм хэмжээ, хууль тогтоомжийг мөрдөх арга хэмжээг зохион байгуулах

3. Хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сэтгэцийн эмнэлэг, аймаг, дүүргийн эмнэлэгт бий болгох, сургууль, хамт олны түвшинд сэтгэл зүйч, нийгмийн ажилтны баг бүрдүүлж ажиллуулах

4. Сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, чадамжийг харгалзан мэргэжлийн сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, гэр бүл, орон нутагт нь ойр байлгаж, амьдрах ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээнд шаардлагатай төхөөрөмж, хэрэгслээр хангах, ний

5. Албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод дүрэм, журам, хамтын гэрээнд тусган мөрдөж ажиллах, хамт олныхоо сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, тайван ажиллах орчныг бүрдүүлэх, энэ чиглэлээр бусад байгууллагаас зохион байгуулж байгаа нийтийг хамарсан

/114./ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах;

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

3. Эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх;

4. Эрүүл мэндийн салбарын хөгжил, эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, судалгаа хийх;

5. Иргэний эрүүл мэндээ хамгаалах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах;

/115./ Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай мэргэжлийн төв ямар үүрэг хүлээх бэ?

1. Улсын хэмжээнд сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хяналтад авах, сэтгэл засал хийх, хөдөлмөрийн чадвар түр алдалтыг тогтоох,

сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, мэргэжил,

2. Сэтгэцийн эмгэгийн талаар улсын хэмжээний нэгдсэн тайлан мэдээ гаргах, мэдээллийн лавлагааны сан ажиллуулах

3. Шүүхийн тогтоолоор шүүх, сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

4. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг эмчлэхдээ эрхийг нь танилцуулж, эмчилгээ, шинжилгээний зорилго, арга, хугацаа, ач холбогдол, гарч болзошгүй гаж нөлөөний талаар урьдчилан мэдэгдэж, өөрөөс нь, тухайн этгээд иргэний эрх зүйн чадамжгүй тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг бичгээр авах

5. Сэтгэцийн эмгэгтэй хүн, түүний хууль ёсны төлөөлөгч нь эмчилгээ, шинжилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд эмчилгээ, шинжилгээг хийлгээгүй буюу тэдгээрийг зогсоосноос гарч болзошгүй үр дагаварыг танилцуулах

/116./ Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

2. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;

3. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

4. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжүүлэх;

5. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

/117./ Хүн амыг эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх байдлаас нь хамааруулан ангилдаг аль нь зөв вэ?

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн

2. Малчин

3. 0-18 насны хүүхэд

4. Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн

5. Ял эдэлж байгаа ялтан

/118./ Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар төрийн бүх шатны байгууллага тус тусын эрх хэмжээний хүрээнд дараах үүрэг хүлээнэ:

1. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эмгэгээс сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлыг зохион байгуулах;

2. Хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сэтгэцийн эмнэлэг, аймаг, дүүргийн эмнэлэгт бий болгох, сургууль, хамт олны түвшинд сэтгэл зүйч, нийгмийн ажилтны баг бүрдүүлж ажиллуулах;

3. Хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ нь тогтоогдоогүй, иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүнийг асран халамжлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэх;

4. Иргэний эрх зүйн чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүнд түүний эдлэх эрхийн талаар танилцуулах, түүний хууль ёсны төлөөлөгчийг сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хууль тогтоомж боловсруулах, төлөвлөх, хянах үйл ажиллагаанд оролцох бололцоог бүрдүүлэх;

5. Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчид дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах

/119./ Эрүүл мэндийн даатгалын байгууллагын чиг үүрэг аль нь вэ?

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавих

2. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт, технологиийг нэвтрүүлэх

3. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах

4. Эрүүл мэндийн даатгалын сангаас жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журмыг батлах

5. Эрүүл мэндийн даатгалын асуудлаар журам, аргачлал, заавар гаргах /120./ Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна:

1. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлогоо, эмчилгээний үйлдэл, ажилбар хийх, мэргэжлийн дүгнэлт гаргах, хянах, сэргээн засах, сэхээн амьдруулах тусламж үзүүлэх цогц үйл ажиллагаа;

2. Цочмог өвчин, эмгэг, осол, гэмтэл, хордлого, төрөх үед эмнэлгийн яаралтай анхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлэн, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

3. Гэнэтийн өвчин, осол, гэмтэл, хордлого болон төрөх үед хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ;

4. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг эрүүл мэндийн байгууллагад зориулалтын унаагаар тээвэрлэн хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;

5. өвчин, эмгэг, гэмтэл бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ;

/121./ Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нь орох вэ?

1. Засгийн газрыг төлөөлж санхүү, төсвийн, нийгмийн даатгалын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн

2. Даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн гурван хүн

3. Ажил олгогчийн олонхын эрх, ашиг сонирхолыг төлөөлсөн байгууллагыг төлөөлж гурван хүн

4. Сум дүүргийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс

5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага

/122./ "Хуурамч эм" гэх нэр томъёонд багтах зүйлийг сонго

1. Хууль бусаар ашиг олох зорилготой

2. Хуурамч шошго хэрэглэх

3. Дууриалган үйлдвэрлэсэн

4. Орц найрлага буруу бичигдсэн

5. Хадгалах нөхцөл буруу бичигдсэн

/123./ Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж нь ... болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1. Үндсэн хууль

2. Монгол Улсын Үндсэн хууль

3. Эрүүл мэндийн тухай хууль

4. Энэ хууль

5. Монгол Улсын олон улсын гэрээ

/124./ Эмнэлгийн мэргэжилтэн дараах нийгмийн баталгаагаар хангагдана

1. Гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюултай байдалд ажилласан үедээ нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авна

2. Өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 10 болон түүнээс дээш жил ажиллан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авна

3. Өрх, сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа мэргэжилтэн 5 жил тутамд нэг удаа үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг авна

4. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 25 түүнээс дээш жил ажиллан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг авна

5. Нийгэмд учирсан онцгой байдлын үед ажиллан нэг удаагийн тэтгэмжийг авна

/125./ Эрүүл мэндийн байгууллагын эрхэд аль нь багтахгүй вэ?

1. Аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга өгөх

2. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг нийтэд сурталчлах

3. Байгууллагын зорилго, эрх, үүрэгт харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээг үзүүлэхээс татгалзах

4. Эрүүл мэндийн байгууллага хүн амын эрүүл мэндтэй холбогдсон асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх

5. Мэргэжлийн онцлог асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих

/126./ Үндэсний зөвлөлийн үүрэг аль нь вэ

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл , төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулан батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих

2. Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх үйл ажиллагааны болон удирдалгын зардалыг хянах , үнэлэлт , дүгнэлт өгөх

3. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл үнийн дээд хязгаар хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох

4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах

5. Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл , гомдлыг шийдвэрлэх

/127./ Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран явуулах ямар үйл ажиллагаанууд хамаарах вэ?

1. Хүн амын эрүүл мэндийн байдлыг тандах, хянах, хамгаалах

2. Өвчин эмгэгээс сэргийлэх

3. Эрүүл мэндийн боловсрол олгох

4. Анагаах ухааны сургалт, эрдэм шинжилгээний ажил явуулах

5. Эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг судлах, арилгах

/128./ "Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ" гэсэн тодорхойлолтыг нэрлэнэ үү.

1. Сэтгэцийн тулгамдсан асуудал, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгтэй хүнийг орон нутаг, гэр оронд нь ойр байлгаж, эмчлэх, сэргээн засах, асрамжийн үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ

2. Сэтгэцийн эмгэгтэй хүний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ

3. Хүн өөрөө болон бусадтай хамтран сэтгэцийн эрүүл мэндээ хянах, сайжруулах боломж олоход чиглэсэн эрүүл зан үйлийг дэмжих арга хэмжээ

4. Сэтгэцийн эмгэгийн улмаас хүний амьдрах ухаан, харилцаа, хөдөлмөрийн болон оюуны алдагдсан чадварыг нөхөн сэргээх

5. Сэтгэцийн эрүүл мэндээ хянаж, сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг хийж буй хүнийг

/129./ Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

3. Эрүүл мэндийн талаар үндэсний хөтөлбөр баталж, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

4. Эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх;

5. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журмыг батлах;

**Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын
“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ болон биоанагаахын ёс зүй” –н
чиглэлийн жишиг сорилууд**

Сорилын зөв хариулт

1-A, 2-C, 3-D, 4-B, 5-E, 6-D, 7-C, 8-D, 9-A, 10-C, 11-C, 12-D, 13-C, 14-C, 15-D, 16-B, 17-E, 18-B, 19-A, 20-C, 21-C, 22-C, 23-C, 24-C, 25-D, 26-D, 27-A, 28-E, 29-A, 30-D, 31-C, 32-A, 33-B, 34-A, 35-C, 36-C, 37-E, 38-C, 39-B, 40-C, 41-B, 42-B, 43-C, 44-C, 45-C, 46-A, 47-E, 48-D, 49-A, 50-A, 51-C, 52-A, 53-A, 54-A, 55-A, 56-C, 57-C, 58-C, 59-B, 60-B, 61-A, 62-A, 63-C, 64-C, 65-A, 66-A, 67-E, 68-C, 69-A, 70-A, 71-B, 72-D, 73-A, 74-D, 75-D, 76-E, 77-D, 78-A, 79-D, 80-D, 81-D, 82-D, 83-D, 84-B, 85-D, 86-A, 87-B, 88-D, 89-D, 90-E, 91-C, 92-B, 93-D, 94-E, 95-A, 96-E, 97-A, 98-B, 99-A, 100-B, 101-B, 102-C, 103-B, 104-A, 105-B, 106-E, 107-A, 108-B, 109-E, 110-E, 111-E, 112-C, 113-C, 114-E, 115-C, 116-E, 117-E, 118-C, 119-E, 120-B, 121-E, 122-C, 123-D, 124-A, 125-C, 126-C, 127-E, 128-D, 129-A, 130-C, 131-A, 132-A, 133-D, 134-A, 135-A, 136-D, 137-A, 138-C, 139-B, 140-C, 141-A, 142-E, 143-A, 144-A, 145-B, 146-A, 147-A, 148-D, 149-A, 150-A, 151-D, 152-A, 153-A, 154-A, 155-A, 156-B, 157-B, 158-A, 159-C, 160-A, 161-C, 162-C, 163-E, 164-A, 165-C, 166-B, 167-C, 168-E, 169-A, 170-D, 171-A, 172-E, 173-C, 174-A, 175-E, 176-A, 177-C, 178-A, 179-C, 180-A, 181-B, 182-B, 183-D, 184-E, 185-A, 186-E, 187-E, 188-A, 189-A, 190-A, 191-D, 192-B, 193-B, 194-A, 195-E, 196-E, 197-A, 198-E, 199-E, 200-B, 201-E, 202-C, 203-D, 204-A, 205-A,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)

/1./ Эмнэлгийн мэргэжилтэнд үйлчлүүлэгчтэй холбоотой бичиг баримтын хөтлөлтөнд аль үйлдлүүдийг хориглодог вэ?

- A. Устгах
- B. Таталган бичих
- C. Сурагчийн дэвтэрт бичих
- D. Компьютрээр бичих
- E. Хураангуйлан бичих

/2./ Ямар тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс ёс зүйн хувьд татгалзах эрхтэй вэ?

- A. Өөрийн нарийн мэргэжил тохирохгүй тохиолдолд
- B. Эм ,багаж хэрэгсэл дутмаг тохиолдолд
- C. Үйлчлүүлэгч ёс бусаар харилцсан тохиолдолд
- D. Үйлчлүүлэгч согтуу байгаа тохиолдолд
- E. Эмчилгээ үйлчилгээ үзүүлэх тохиромжгүй нөхцөлд

/3./ Хэрэв та ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь нотлогдвол хуулийн дагуу эмчлэх , сувилах , эм барих, эх барих эрхээ ямар хугацаагаар хасуулах бэ?

- A. Хугацаагүй
- B. Салбар ёс зүйн хорооны шийдвэрээр заасан хугацаанд
- C. 5 жил хүртэл
- D. 6 сараас 1 жил хүртэл
- E. 1 жилээс 5 жил хүртэл

/4./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчидийн өвчин эмгэгийн мөн чанар, шалтгаан, оношлогоо, эмчилгээний аргууд, тэдгээрийн үр дүн, эрсдэл хүндрэлийн талаар үйлчлүүлэгчид болон тэдний хууль ёсны төлөөлөгчидэд дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь ёс зүйд нийцэх үү ?

- A. Энэ бол эмч, эмнэлгийн нууцад хамаарах учраас болохгүй
- B. Өгөх нь зөв
- C. Ёс зүйн хэмжээний дагуу зөвшөөрөгдсөн асуудал
- D. Энэ бол ёс зүйн үүднээс хориотой
- E. Сайн мэдэхгүй байна.

/5./ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаанд “ үйлчлүүлэгч” гэж хэнийг нэрлэх бэ?

- A. Эрүүл мэндийн бүх байгууллагуудад хандагсадыг,
- B. Амбулатороор үзүүлэгсэдийг
- C. Нийт өвчтнүүдийг
- D. Харьяа нутаг дэвсгэрийн иргэдийг
- E. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахтай холбоотой харилцаанд оролцогч иргэнийг

/6./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар тохиолдолд үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээлэлийн нууцыг задлаж болох бэ?

- A. Үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу
- B. Ямар ч тохиолдолд задруулж болохгүй
- C. Эрүүл мэндийн хуулийн холбогдох заалтын дагуу
- D. Хувь хүний нууцын тухай хуулийн холбогдох заалтын дагуу
- E. Байгууллагын эрх баригчдын шаардсанаар

/7./ Хэрэв үйлчлүүлэгч насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй бол ёс зүйн хэм хэмжээнд заасан заавал бичгээр зөвшөөрөлийг хэнээс авах бэ ?

- A. Эмч өөрөө шийднэ
- B. Харьяа засаг захиргааны байгууллагаас нь
- C. Эцэг эх , асран хамгаалагчдаас нь
- D. Хуулийнхны зөвшөөрөлөөр
- E. Зөвшөөрөл авах шаардлагагүй

/8./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар үндэслэлээр бусад эмч , эмнэлгийн мэргэжилтний туслалцаа авч болох бэ ?

- A. Зөвлөх эмчийн заавараар
- B. Бусадын зөвлөсөнөөр
- C. Удирдлагын шаардлагаар
- D. Өөрийн санаачлагаар
- E. Хяналт шалгалтынханы зөвлөсөнөөр

/9./ Биоанагаахын судалгаанд оролцоход тухайн хүний зөвшөөрөл заавал авдагын учир юу вэ ?

- A. Хүний эрхийг хүндэтгэх
- B. Олон улсын жишгийг хүндэтгэн
- C. Хариуцлага хүлээхийн үүднээс
- D. Тогтсон хэм хэмжээний дагуу
- E. Энэ бол илүүц үйл ажиллагаа

/10./ Эмнэлгийн мэргэжилтэн тухайн хүний амьдралын төгсгөл сөрөг талруу нэгэнт тодорхой болсон тохиолдолд баримтлах ёс зүйн хандлагыг тодорхойлно уу.

- A. Оношын үнэнийг хэлэх нь буруу
- B. Өрхийн эмчид нь даалгана
- C. Өвдөлт , зовиур шаналгааг нь багасгах бололцоотой бүх арга хэмжээг авна
- D. Ар гэрийнхэнд нь асарч сувилах талаар зөвлөлгөө өгнө
- E. Эрүүл мэндийн сайн дурын итэвхтүүдийн асрамжинд шилжүүлнэ

/11./ Та “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” баримт бичигт “Эмнэлгийн мэргэжилтэн био-анагаахын ёс зүйн талаар олон улс болон өөрийн орны холбогдох байгууллагуудаас батласан хууль тогтоомж, дүрэм журам, зөвлөмжүүдийг мөрдөнө” гэж заасанд ямар асуудлыг хамруулан ойлгож байна вэ ?

- A. Эмчийн ёс суртахууны асуудлыг

- В. . Эмнэлгийн мэргэжилтүүдийн ёс зүйн асуудлыг
- С. Эмнэлэг- биологийн судалгаа шинжилгээний асуудлыг
- Д. Эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлэхийг
- Е. Мэдэхгүй

/12./ Хэрэв та олон улсын төслөөр санхүүжиж байгаа анагаах ухааны судалгааны багт оролцож байгаа бол судалгаа явуулах ёс зүйн зөвшөөрлөө хаанаас авах бэ ?

- А. Тухайн судалгааны багийн ахлагчаас
- В. Байгууллагын удирдлагаас
- С. Тухайн хувь хүн болон хамт олноос нь
- Д. ЭМЯ –ны анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооноос
- Е. Байгууллагын салбар ёс зүйн хорооноос

/13./ Ямар тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчийн шаардсан тусламж үйлчилгээнээс татгалзаж болох бэ ?

- А. Зөвлөх эмч татгалзсан бол
- В. Эм , хэрэгслэл дутмаг бол
- С. Нотолгоо , үндэслэл үгүй гэж үзвэл
- Д. Яаруу давчуу үед
- Е. Төсөв мөнгөны дутагдалтай үед

/14./ Эмнэлгийн мэргэжилтэн сэжигтэн , яллагдагч , шүүгдэгч , ялантай харилцахдаа ёс зүйн үүднээс хэрхэн хандах вэ?

- А. Эмнэлгийн мэргэжилтэн миний хувьд зөвхөн эмнэлгийн тусламж үзүүлнэ
- В. Өлсгөлөн зарлахыг хориглоно.
- С. Доромжлохыг эсэргүүцэнэ
- Д. Хууль ёсны цээрлэл үзэж байгаа учир миний тангарагт харшлахгүй
- Е. Хуулийн ажилтнуудыг дэмжинэ

/15./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийг анагаах ухааны болон шинжлэх ухааны туршилтанд оруулж болох уу?

- А. Эмчлэж илааршуулж байгаа учраас болно
- В. Шинжлэх ухааны тусын тулд болно
- С. Энэ бол олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн асуудал
- Д. Хэрэв өөрөө зөвшөөрвөл болно
- Е. Хүн “туршлагын туулай” бус

/16./ Хуулиар “Хүний их эмчийн тангараг” -т ёс зүйн ямар заалт тусгагдсан байдгыг заа.

- А. Эмч төрийн хуулийг ёсчлох
- В. Энэрэх сэтгэлээ харамгүй зохиулах
- С. Амь насаа золиослох
- Д. Эрдэм чадлаа харамлах
- Е. Олон улсын жишгийг дагах

/17./ Эмнэлгийн мэргэжилтэн өөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилахдаа ёс зүйн үүднээс ямар асуудлуудыг тусгах вэ?

- А. Үйлчилгээний төлбөрийн хэмжээ
- В. Өөрийн нас
- С. Хүртсэн шагнал урамшуулал
- Д. Удирдах байгууллагын нэр
- Е. Цагийн хуваарь

/18./ Эмнэлгийн мэргэжилтэн ёс зүйн үүднээс үйлчлүүлэгчид өөрийн мэдлэг, чадвар, туршлагыг зориулан ажиллахдаа тулгуурлах гол зарчмыг нэрлэ

- А. Хувийн хичээл зүтгэл
- В. Шударга ёс
- С. Олон нийтийн дэмжлэг
- Д. Хувийн үнэлэмж

/19./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар зорилгын үүднээс үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээний тодорхой хувилбарыг тулгаж болохгүй вэ?

- А. Ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд
- В. Цаг хугацаа хожихын тулд

- C. Үйлчлүүлэгчид туслах зорилгоор
- D. Байгууллагдаа туслахын тулд
- E. Нөхөдын тусын төлөө

/20./ Яаралтай тусламж шаардсан үед үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч нар нэгэн зэрэг хэд хэдэн эмч дуудсан тохиолдолд эмч нарын хэн нь тусламж үйлчилгээ үзүүлэх бэ?

- A. Илүү нэр хүндтэй эмч нь
- B. Бүгд хамтран
- C. Түрүүлж ирсэн эмч дараагийн мэргэжилтэнд шилжүүлэх хүртэл
- D. Яаралтай тусламжийн эмч
- E. Хэн нарийн мэргэжилтэй нь

/21./ “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим” гэсэн ойлголтыг зөв тодорхойл

A. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмуудыг

B. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, хамт олон, мэргэжилтүүдтэй харилцахад баримтлах зарчмуудыг

C. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмуудыг

D. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэн болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмуудыг

E. Эмнэлгийн мэргэжилтэн нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмуудыг

/22./ Хэрэв та өөрийн судалгаандаа амьтан ашиглах бол ямар нэг зөвшөөрөл авах шаардлагатай юу?

- A. Мэдэхгүй
- B. Энэ талаар олон улсын хэмжээний эрх зүйн зохицуулалт байхгүй
- C. Холбогдох ёс зүйн хорооноос зөвшөөрөл авна
- D. Хүн амьтан ялгаатай шүү дээ
- E. Энэ асуудлын талаар дуулаач үгүй

/23./ Эмнэлгийн мэргэжилтэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялантай харилцахдаа ёс зүйн үүднээс хэрхэн хандах вэ?

- A. Өлсгөлөн зарлахыг хориглоно
- B. Хуулийн ажилтнуудыг дэмжинэ
- C. Басамжлахыг эсэргүүцэнэ
- D. Эмнэлгийн мэргэжилтэн миний хувьд зөвхөн эмнэлгийн тусламж үзүүлнэ
- E. Хууль ёсны цээрлэл үзэж байгаа учир миний тангарагт харшлахгүй

/24./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн талаархи өөрт байгаа бүх мэдээллийг доорхи хүмүүсийн алинд нь өөрийн нь болон хууль ёсны төлөөлөгчийн нь зөвшөөрөлгүйгээр өгч болох вэ?

- A. Өөрийн багш эмчид зөвлөлгөө авахаар
- B. Бусад эмч нарт
- C. Хуулиар олгогдсон эрх бүхий хүмүүст
- D. Сургалтанд ашиглах зорилгоор оюутнуудад
- E. Архивын ажилтанд

/25./ Хэрэв та ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь нотлогдвол хуулийн дагуу эмчлэх, сувилах эрхээ ямар хугацаагаар хасуулах бэ?

- A. Хугацаагүй
- B. 5 жил хүртэл
- C. 2 жил
- D. 6 сараас 1 жил хүртэл
- E. 1 жилээс 5 жил хүртэл

/26./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар үндэслэлээр бусад эмч, эмнэлгийн мэргэжилтний туслалцаа авч болох бэ?

- A. Зөвлөх эмчийн заавараар
- B. Бусадын зөвлөсөнөөр
- C. Удирдлагын шаардлагаар

- D. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр
E. Хяналт шалгалтынханы зөвлөсөнөөр
- /27./ Хэрэв эмнэлгийн мэргэжилтэн өөрийн хувийн эмнэлэгтэй, эсвэл хувийн эмнэлэгт хавсран ажилладаг бол ёс зүйн үүдээс ямар зарчим баримтлах вэ?
A. Зайлшгүй илгээх тохиолдолд үйлчлүүлэгчид үнэнийг хэлнэ
B. Зах зээлийн нийгэм юм чинь өөрийн болон ажилладаг эмнэлэгтэй илгээхэд буруудахгүй, учир нь хүний эрүүл мэнд чухал
C. Уг асуудал хүний эрх / хувь эмнэлгийн мэргэжилтний / асуудал
D. Одоо цагт хувийн эмнэлэг төрийн эмнэлгээс илүү үйлчлэж байгаа учир бололцоотой асуудал
E. Би төрийн өмчийн эмнэлэгт ажилладаг учир надад хамаагүй
- /28./ Эмнэлгийн мэргэжилтэн ялтанд ямар зарчмыг баримтлан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ёстой вэ?
A. Хуулийн ажилтны заавраар
B. Өөрийн үзэмжээр
C. Хуульд заасны дагуу
D. Асуудалд орооцолдохгүй гэсэн хүслээрээ
E. Батлагдсан онош , стандартын дагуу
- /29./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй холбоотой баримт бичгийг хэрэв өөрөө зөвшөөрвөл бусдад дамжуулж болох уу?
A. Хэрэв өөрөө зөвшөөрвөл болно
B. Зөвшөөрөх эрх зүйн үндэслэл байхгүй
C. Эмчийн эрх ашигт харшлах учраас болохгүй
D. Эмнэлгийн нэр хүндэд харшлах учраас болохгүй
E. Хууль хязгаарлагдсан
- /30./ Эмнэлгийн мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэж байхдаа бие авч явах соёлын талаархи журмыг хаанаас батлаж мөрдүүлэх бэ?
A. Нэгдсэн журам байх эрх зүйн үндэслэл байхгүй
B. Холбогдох мэргэжлийн нийгэмлэгүүдээс
C. Аймаг , хотын эрүүл мэндийн газраас
D. Тухайн эрүүл мэндийн байгууллагаас
E. Байгууллагын хуулийн зөвлөхын боловсруулсан журмаар
- /31./ Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг сайжруулахад чиглэсэн эмнэлгийн мэргэжилтний эмнэлгийн тусламж үйлчилгээ ёс зүйн үүднээс ямар шаардлага хангасан байх ёстой бэ?
A. Чирэгдэлгүй
B. Зардал мөнгө хэмнэсэн
C. Нэмэлт шаналгаа зовиур шаналгаа үүсгэхээргүй
D. Очер дугаар үгүй
E. Маргаан хэл ам үгүй
- /32./ Эмнэлгийн мэргэжилтэн яагаад үйлчлүүлэгчийг өөрийн нь зөвшөөрөл үгүйгээр анагаах ухааны болон шинжлэх ухааны туршилтанд оруулж болохгүй бэ?
A. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэхийн үүднээс
B. Эрүүл мэндэд нь харш учраас
C. Хуулиар хориглодог учраас
D. Ашиг сонирхолын зөрчлийн үүднээс
E. Шинжлэх ухааны хөгжлийн үүднээс болно
- /33./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар зорилгын үүднээс үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээний тодорхой хувилбарыг тулгаж болохгүй вэ?
A. Ажлын ачааллаа хөнгөлөхийн тулд
B. Хувийн ашиг сонирхолын үүднээс
C. Нэр төрөө хамгаалахын тулд
D. Байгууллагдаа туслахын тулд
E. Нөхөдын тусын төлөө
- /34./ Эмнэлгийн мэргэжилтэнд үйлчлүүлэгчтэй холбоотой бичиг баримтын хөтлөлтөнд аль үйлдлүүдийг хориглодог вэ

- A. Хуудас солих
- B. Таталган бичих
- C. Сурагчийн дэвтэрт бичих
- D. Компьютрээр бичих
- E. Хураангуйлан бичих

/35./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн харилцааны тулгуур үндэс аль нь вэ?

- A. Харилцан тохиролцол
- B. Эмчийн шийдвэр
- C. Харилцан хүндэтгэлцэл
- D. Үйлчлүүлэгчийн хүсэл
- E. Аль нь ч биш

/36./ Олон улсын болон үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн үндэслээр хэрэв хүн , түүнтэй холбоотой мэдээллийг судалгаанд ашиглах бол хамгийн гол баримтлах тулгуур зарчим аль нь вэ?

- A. Энэ бол эмнэлгийн мэргэжилтний эрх
- B. Тодорхой эрх зүйн зохицуулалт байхгүй учраас чөлөөтэй
- C. Тухайн хүний өөрийн нь зөвшөөрөл
- D. Байгууллагын зөвшөөрөл
- E. Хуулийн байгууллагын зөвшөөрөл

/37./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар тохиолдолд даган мөрдөж буй хууль, тогтоол , дүрэм журмыг өөрчлүүлэх саналаа эрх бүхий албан байгууллага , тушаалтанд тавих эрхтэй бэ ?

- A. Ажилд төвөгтэй бол
- B. Үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцэхгүй тохиолдолд
- C. Цаг үеийн шаардлагаас хоцрогдож байна гэж бодогдож байгаа бол
- D. Улс төржиж байгаа бол
- E. Өөрийн эрх ашигт нийцэхгүй бол

/38./ Эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэгүүд мэргэжлийн онцлогыг тусгасан тусгай ёс зүйн хэмжээг хаанаас баталгаажуулан мөрдүүлэх бэ ?

- A. Нийгэмлэгүүдийн их хурлаас
- B. Нийгэмлэгүүдийн дарга нар
- C. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас
- D. Олон нийтийн зүгээс
- E. Баталгаажуулах шаардлагагүй

/39./ Доорхи тодорхойлолтуудын аль нь “Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн хэм хэмжээ ” гэсэн ойлголтыг зөв илэрхийлж байна бэ ?

A. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаягын тухай цогц ойлголт ,

B. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг

C. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих дүрэм журмыг

D. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих итгэл үнэмшил, хандлагыг

E. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих зан суртахууны мөрдлөгийг

/40./ Хэрэв үйлчлүүлэгч насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй бол ёс зүйн хэм хэмжээнд заасан заавал бичгээр зөвшөөрөлийг хэнээс авах бэ?

- A. Эмч өөрөө шийднэ
- B. . Хуулийнханы зөвшөөрлөөр
- C. Хууль ёсны төлөөлөгчидөөс нь
- D. Зөвшөөрөл авах шаардлагагүй
- E. Холбогдох албан тушаалтанаас

/41./ Хэрэв та хүүхдийг өөрийн судалгаанд хамруулах бол хэний зөвшөөрөл авах шаардлагатай бэ?

- A. Өөрийн нь
- B. Хууль ёсны асран хамгаалагчдын нь

- C. Цэцэрлэг , сургуулийн эрх баригчдаас нь
D. Хэнээс ч зөвшөөрөл авах шаардлагагүй
E. Энэ бол зөвхөн хэлбэрдлийн асуудал
- /42./ Олон улсын болон, буяны байгууллага, сайн санаат иргэдээс эмнэлгийн тусламж үйлчилгээнд зориулаж өгсөн тусламжийг хэрхэн зарцуулах ёстой вэ?
A. Үйлчлүүлэгчдын саналаар
B. Зориулалтаар нь
C. Хамт олны хурлын шийдвэрээр
D. Байгууллагын удирдлагын шийдвэрээр
E. Цаг үеийн байдлаар
- /43./ Ямар тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн ёс зүйн хариуцлага хүлээх бэ?
A. Хууль эрх зүйн мэдлэг дутмагаас
B. Ажил үүрэгтээ салан хандсан
C. Ёс зүйн ноцтой алдаа гаргасан
D. Удирдлагын үүрэг ,даалгаварыг биелүүлээгүй
E. Мэргэжлийн алдаа гаргасан
- /44./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн талаархи өөрт байгаа бүх мэдээлээлийг дорхи хүмүүсийн алинд нь өөрийн нь болон хууль ёсны төлөөлөгчийн нь зөвшөөрөлгүйгээр өгч болох вэ?
A. Өөрийн багш эмчид зөвлөлгөө авахаар
B. Бусад эмч нарт
C. Зөвлөх мэргэжилтэнд
D. Сургалтанд ашиглах зорилгоор оюутнуудад
E. Архивын ажилтанд
- /45./ Эмчүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудах, нас барах тохиолдолд эмч, сувилагч, асрагч, бусад хүмүүсийн хэн нь түүний хууль ёсны төлөөлөгчид мэдээлэх үүрэгтэй бэ ?
A. Хэн бололцоотой нь
B. Хэн ч болно
C. Эмч
D. Шарил хадгалах газрын ажилтан
E. Асрагч
- /46./ Эмнэлгийн мэргэжилтэн аливаа тодорхойлолт гаргах, бичиг баримтад гарын үсэг зурахдаа ёс зүйн хувьд цээрлэх ёс юу вэ?
A. Хуурамч баримтанд гарын үсэг зурах
B. Удирдлагуудын тушаал заавраар
C. Санамсаргүй тохиолдлоор
D. Бусдын гуйсанаар
E. Урамшуулал хүсэж
- /47./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар учраас үйлчлүүлэгчтэй холбоотой баримт бичгийг бусдад дамжуулж болохгүй вэ?
A. Эмчийн үйл ажиллагаатай холбоотой учраас
B. Байгууллагын эрх ашгийн үүднээс
C. Эмнэлгийн нууцад хамаарагдах учраас
D. Хөрөнгө зардалтай холбоотой учир
E. Үйлчлүүлэгчийн эрхтэй холбоотой учраас
- /48./ Эмнэлгийн мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэж байхдаа бие авч явах соёлын талаархи журмыг хаанаас батлаж мөрдүүлэх бэ?
A. Эрүүл мэндийн яамнаас
B. Холбогдох мэргэжлийн нийгэмлэгүүдээс
C. Аймаг , хотын эрүүл мэндийн газраас
D. Тухайн эрүүл мэндийн байгууллагаас
E. Нэгдсэн журам байх эрх зүйн үндэслэл байхгүй
- /49./ Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хоорондын харилцааны тулгуур зарчмуудаас нэрлэнэ үү?
A. Нэг нэгнийгээ дэмжих
B. Найз нөхөрийн харилцаа

- C. Дотно элэгсэг харилцаа
- D. Нэр төрөө харилцан хамгаалсан харилцаа
- E. Харилцан туслалцах харилцаа

/50./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийг сонголт хийх боломж олгохын тулд ямар хэлбэрээр зөвлөлгөө өгөх, санал болгох үүргийг ёс зүйн үүднээс хүлээх вэ?

- A. Байгууллагын чадавхийг бодиттой үнэлэн
- B. Хүнлэг ёсны үүднээс
- C. Цаг хугацааны хамаарлаас
- D. Байгууллагын эрх ашгийн үүднээс
- E. Бусад мэргэжилтнүүдийн тусын тулд

/51./ Хэрэв үйлчлүүлэгчийн буруу харилцааны улмаас мэргэжлийн үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй тохиол үүслээ гэж эмнэлгийн мэргэжилтэн ямар тохиолдолд үзэж болохгүй вэ?

- A. Сэтгэл санааны тааламжгүй үед
- B. Ажлын ачаалал хөнгөн байгаа үед
- C. Яаралтай тусламж шаардлагатай үед
- D. Өөрөө зохицуулж чадахгүй үед
- E. Хариуцлагаас зайлсхийхийн тулд

/52./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн харилцааны тулгуур үндэс аль нь вэ?

- A. Харилцан итгэлцлэл
- B. Харилцан ярилцал
- C. Харилцан зөвшилцөл
- D. Эмчийн шийдвэр
- E. Үйлчлүүлэгчийн хүсэл

/53./ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт тэгш хүртээмжтэй үзүүлэхдээ Монгол улсын үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна ямар ялгаварлал эмнэлгийн мэргэжилтэнд байж болохгүй бэ?

- A. Эрүүл мэндийн байдлаар нь
- B. Яс үндэсээр нь
- C. Нас хүйсээр нь
- D. Боловсролоор нь
- E. Хөрөнгө чинээгээр нь

/54./ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд эмнэлгийн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчидэд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ “ давхар харилцаа ”-нд орохыг хориглодог. Тэгвэл эдгээрэс аль нь хориглосон “ давхар харилцаа ” вэ?

- A. Өөрийн эрхшээлд оруулах
- B. Дотно яриа өрнүүлэх
- C. Чихэр жимсээр дайлуулах
- D. Эмчилгээний талаар зөвлөлдөх
- E. Оношийг нууцлах

/55./ Аль тохиолдлуудад эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн зөвшөөрөл үгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болох бэ?

- A. Эрс шийдвэр гаргаагүйгээс үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой эрсдэл учирч болзошгүй
- B. Эмч өөрөө шийдсэн тохиолдолд
- C. Ойр дотныхоны нь хүсэлтээр
- D. Эмнэлгийн удирдлагуудын шаардлагаар
- E. Хууль хяналтын ажилтнуудын шаардлагаар

/56./ “ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ” –н тухай зөв ойлголтыг ол

- A. “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, ёс суртахуун, үйл ажиллагаа, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “ хэлнэ.

В. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, мэргэжлийн чадвар, харилцааны эв дүй, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “ хэлнэ.

С. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “ хэлнэ.

Д. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаягын тухай цогц ойлголтыг “ хэлнэ.

Е. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “ хэлнэ.

/57./ Доор дурьдан буй баримт бичгүүд практикийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн үйл ажиллагаанд хамааралтай юу ?

А. Орчин цагт дэлхийн нийтийн жишгийн дагуу зайлшгүй шаардалгатай

В. Практикийн эмч, сувилагчдад төдийлэн учир холбогдолгүй

С. Тархвар зүйн судалгааны ёс зүйн хяналтын удирдамж

Д. Иргэний хуулийн заалтууд

Е. Эрүүгийн хуулийн заалтууд

/58./ Олон улсын болон, буяны байгууллага, сайн санаат иргэдээс эмнэлгийн тусламж үйлчилгээнд зориулаж өгсөн тусламжийг хэрхэн зарцуулах ёстой вэ?

А. Хамт олны хурлын шийдвэрээр

В. Байгууллагын удирдлагын шийдвэрээр

С. Зориулалтаар нь

Д. Цаг үеийн байдлаар

Е. Өөрсөдийн үзэмжээр

/59./ Ямар тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн ёс зүйн хариуцлага хүлээх бэ?

А. Мэрэгжлийн алдаа гаргасан

В. Ёс зүйн ноцтой алдаа гаргасан

С. Ажил үүрэгтээ салан хандсан

Д. Удирдлагын үүрэг, даалгаварыг биелүүлээгүй

Е. Хүний амь насыг хөнөөсөн

/60./ Эмчүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудах, нас барах тохиолдолд эмч, сувилагч, асрагч, бусад хүмүүсийн хэн нь түүний хууль ёсны төлөөлөгчид мэдээлэх үүрэгтэй бэ ?

А. Хэн ч болно

В. Эмч

С. Сувилагч

Д. Шарил хадгалах газрын ажилтан

Е. Асрагч

/61./ Үйлчлүүлэгчийн өөрийн нь зөвшөөрөл үгүйгээр үзлэг, эмчилгээ, шинжилгээ хийж байгаа үйлдэлээ нийтийн сурталчилгаанд ашиглаж болох уу ?

А. Хүний эрх, нэр төртэй холбоотой учир болохгүй

В. Бид үйл ажиллагаагаа олонд хүргэхийн тулд байж болох үзэгдэл хэмээн үзэж байна

С. Тухайн үйлчлүүлэгчид бид тус болж байгаа учраас болох болов уу

Д. Энэ бол төдийлэн анхаарал татах асуудал бус

Е. Энэ бол байж л байдаг үзэгдэл

/62./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар тохиолдолд үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг задлаж болох бэ?

А. Хувь хүний нууцын тухай хуулийн холбогдох заалтын дагуу

В. Байгууллагын эрх баригчдын шаардсанаар

С. Үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу

Д. Ямар ч тохиолдолд задруулж болохгүй

Е. Эрүүл мэндийн хуулийн холбогдох заалтын дагуу

/63./ Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй асуудал гарвал эцсийн шийдвэрийг хэн гаргах вэ ?

А. Тасгийн эрхлэгч

В. Ерөнхий эмч

- C. Эмчлэгч эмч
- D. Зөвлөх эмч
- E. Үйлчлүүлэгч

/64./ Эмнэлгийн мэргэжилтний хувьд шинжлэх ухаанч бус ямар үйлдэл ёс зүйн үүднээс хориотой вэ ?

- A. Төвд эм барих
- B. Хануур төөнүүр хийх
- C. Шинжлэх ухааны үндэслэлгүй эмчилгээ хийх , түүнийг дэмжих, тийм үйлдэлд оролцох
- D. Нэр төрөө дээшлүүлэхийн тулд
- E. Эмчилгээний үр дүнг сайжруулахын тулд

/65./ Хэрэв үйлчлүүлэгчийн буруу харилцааны улмаас мэргэжлийн үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй тохиол үүсвэл эмнэлгийн мэргэжилтэн хэнд хандах учиртай бэ?

- A. Өөрийн байгууллагын удирдлагад
- B. Хууль хяналтын байгууллагад
- C. Өөрөө зохицуулна
- D. Иргэдэд хандана
- E. Ийм асуудал ерөөс үүсдэггүй

/66./ Та “ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” баримт бичигт “Эинэлгийн мэргэжилтэн био-анагаахын ёс зүйн талаар олон улс болон өөрийн орны холбогдох байгууллагуудаас батласан хууль тогтоомж, дүрэм журам , зөвлөмжүүдийг мөрдөнө” гэж заасанд ямар асуудлыг хамруулан ойлгож байна вэ ?

- A. Эмнэлэг- биологийн судалгаа шинжилгээний асуудлыг
- B. Өвөрмөц оношлогоо эмчилгээний асуудлыг
- C. Эмчийн ёс суртахууны асуудлыг
- D. Эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлэхийг
- E. Мэдэхгүй

/67./ Ямар тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчийн шаардсан тусламж үйлчилгээнээс татгалзаж болох бэ ?

- A. Төсөв мөнгөны дутагдалтай үед
- B. Өөрт эс таалагдвал
- C. Зөвлөх эмч татгалзсан бол
- D. Эм , хэрэгсэл дутмаг бол
- E. Нотолгоо , үндэслэл үгүй гэж үзвэл

/68./ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт тэгш хүртээмжтэй үзүүлэхдээ Монгол улсын үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна ямар ялгаварлал эмнэлгийн мэргэжилтэнд байж болохгүй бэ ?

- A. Яс үндэсээр нь
- B. Нас хүйсээр нь
- C. Бэлгийн чиг хандлагаар нь
- D. Боловсролоор нь
- E. Хөрөнгө чинээгээр нь

/69./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийг сонголт хийх боломж олгохын тулд ямар хэлбэрээр зөвлөлгөө өгөх, санал болгох үүргийг ёс зүйн үүднээс хүлээх вэ?

- A. Өөрийн байгууллагын чадавхийг бодиттой үнэлсэний үндсэн дээр
- B. Хүнлэг ёсны үүднээс
- C. Цаг хугацааны хамааралаас
- D. Байгууллагын эрх ашгийн үүднээс
- E. Бусад мэргэжилтнүүдийн тусын тулд

/70./ Аль тохиолдлуудад эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн зөвшөөрөл үгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болох бэ?

- A. Үйлчлүүлэгч сэтгэцийн хувьд чадамжгүй бол
- B. Эмч өөрөө шийдсэн тохиолдолд
- C. Ойр дотныхоны нь хүсэлтээр
- D. Эмнэлгийн удирдлагуудын шаардлагаар

- Е. Хууль хяналтын ажилтнуудын шаардлагаар
- /71./ Хуулиар “Хүний их эмчийн тангараг” -т ёс зүйн ямар заалт тусгагдсан байдгыг заа.
- А. Эрдэм чадлаа харамлах
 - В. Эмчийн ёс зүйг чандлан сахих
 - С. Хууль ёсонд захирагдах
 - Д. Олон улсын жишгийг дагах
 - Е. Мэргэжлийн эрхээ эдлэх
- /72./ Таниулах зөвшөөрөл өгөх чадвартай хүүхдийн насыг хэдэн насаар тооцдог вэ?
- А. 10-11 нас
 - В. 14-16 нас
 - С. 16-18 нас
 - Д. 12-13 нас
 - Е. 8-9 нас
- /73./ Хувь хүнийг хүндэтгэж үзэх зарчим нь ёс зүйн хоёр үндсэн ухагдахууныг өөртөө агуулна эдгээрийг нэрлэнэ үү.
- А. Хувь хүний бие даасан байдлыг хүндэтгэх мөн Хувь хүний бие даасан байдал нь хязгаарлагдсан эсвэл хямарсан хүнийг хамгаалах;
 - В. Үр ашигтай байх, Үнэнч байх;
 - С. Хувь хүнийг хамгаалах, үзэл бодлыг нь хүндэтгэх;
 - Д. Өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх, бусдын үзэл бодлыг сонсох;
 - Е. Хувь хүний эрх чөлөөг хамгаалах, Хувь хүний бие даасан байдал нь хязгаарлагдсан эсвэл хямарсан хүнийг хамгаалах;
- /74./ Эрдэм шинжилгээний баримтын нууцын аюулгүй байдлыг хангах нөхцлийг ямар субъект бүрдүүлсэн байх ёстой бэ?
- А. Ёс зүйн хяналтын хороо
 - В. Эмч
 - С. Аюулгүй байдлын хороо
 - Д. Судлаач
 - Е. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
- /75./ Био-анагаахын судалгаанд таниулсан зөвшөөрлийг үл харгалзах шийдвэр гаргах ховор тохиолдолд ямар байгуулагаас зөвшөөрөл авах вэ?
- А. Эрүүл мэнд,спортын яам
 - В. Эрдмийн зөвлөл
 - С. Төрийн захиргааны төв байгуулага
 - Д. Ёс зүйн хяналтын хороо
 - Е. Таниулсан зөвшөөрлийг үл харгалзах тохиолдол байхгүй
- /76./ Хүнийг хамруулсан судалгаанд ажиглалт хийхэд ямар арга хэрэглэх бэ?
- А. Физиологи, биохими, хими, сэтгэл зүйн нөлөөллийн арга
 - В. Эмгэг үйл ажиллагааны болон физик, хими, сэтгэл зүйн нөлөөллийн арга
 - С. Биохими, эмгэг үйл ажиллагааны болон физик, химийн арга
 - Д. Физиологи, биохими, эмгэг үйл ажиллагааны болон физик, хими, сэтгэл зүйн нөлөөллийн арга
 - Е. Физик, хими, сэтгэл зүйн нөлөө үзүүлэх арга
- /77./ Таниулсан зөвшөөрөл гэдэг нь
- А. Шаардлагатай мэдээллийг авч түүнийг бүрэн ойлгож ухамсарласан, эцэст албадах, зоригжуулах шийдвэр гаргах чадвар бүхий хувь хүнээс авсан зөвшөөрлийг хэлнэ.
 - В. Шаардлагатай мэдээллийг авч түүнийг бүрэн ойлгож ухамсарласан, сайтар тунгаан бодсоны эцэст албадах, зоригжуулах буюу сүрдүүлэх зохисгүй нөлөөнд үл автагдсан шийдвэр гаргасан хүний болзолыг ёс зүйн хүлээж авж зөвшөөрөл өгөхийг хэлнэ.
 - С. Өөрөө чин сэтгэлээсээ хүссэн сайтар тунгаан бодсоны эцэст албадах, зоригжуулах буюу сүрдүүлэх зохисгүй нөлөөнд үл автагдсан шийдвэр гаргасан хүний болзолыг ёс зүйн хүлээж авж зөвшөөрөл өгөхийг хэлнэ.

D. Шаардлагатай мэдээллийг авч түүнийг бүрэн ойлгож ухамсарласан, сайтар тунгаан бодсоны эцэст албадах, зоригжуулах буюу сүрдүүлэх зохисгүй нөлөөнд үл автагдсан шийдвэр гаргах чадвар бүхий хувь хүнээс авсан зөвшөөрлийг хэлнэ.

E. Шаардлагыг хангаж ямарч албадлагад, сүрдүүлгэнд зохисгүй нөлөөнд үл автагдсан шийдвэр гаргасан хүний болзолыг ёс зүйн үүднээс хүлээж авж зөвшөөрөл өгөхийг хэлнэ.

/78./ Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороог ямар байгууллага байгуулах вэ?

A. Төрийн захиргааны төв байгууллагаас байгуулна

B. Эрүүл мэндийн сайд байгуулна

C. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна.

D. Эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн байгуулна.

E. Эмнэлэгийн удирдлагын асуудал хариуцсан УИХ-ын гишүүн байгуулна.

/79./ Гэмтэл авсан оролцогч эмчлүүлэх, нөхөн олговор авах эрх гэж

A. Судалгаанд оролцогч нь судалгаанд хамрагдсаны дараа биеийн гэмтэл авсан бол түр болон удаан хугацааны турш сэтгэл санааны дэмжлэг авах эрхтэй

B. Судалгаанд оролцогч нь судалгаанд хамрагдсаны дараа биеийн гэмтэл авсан бол удаан хугацааны турш хөдөлмөрийн тусламж дэмжлэг авах эрхтэй

C. Судалгаанд оролцогч нь судалгаанд хамрагдсаны дараа биеийн гэмтэл авсан бол түр хугацааны турш хөдөлмөрийн тусламж дэмжлэг авах эрхтэй

D. Судалгаанд оролцогч нь судалгаанд хамрагдсаны улмаас биеийн гэмтэл авсан бол түр болон удаан хугацааны турш хөдөлмөрийн тусламж дэмжлэг авах эрхтэй

E. Судалгаанд оролцогч нь судалгаанд хамрагдсаны улмаас биеийн гэмтэл авсан бол ганц л удаа тусламж дэмжлэг авах эрхтэй

/80./ Хельсинкийн тунхаглалын 11-р бүлэгт зааснаас үзвэл Хүнийг оролцуулсан эмнэлэг, биологийн судалгаа нь ямар мэдлэгт тулгуурласан байх ёстой вэ?

A. Нийтээр баримталдаг зарчмыг дагаж сайтар бэлдсэн лабораторийн болон амьтанд туршсан туршилтын дүнд, эрдэм шинжилгээний хэвлэлийг судалсан байх ёстой.

B. Олон улсын зарчмыг дагаж бэлдсэн лабораторийн шинжилгээний хэвлэлийг нэвт судалсан мэдлэгт тулгуурласан байх ёстой

C. Шинжлэх ухааны зарчмыг дагаж сайтар бэлдсэн туршилтын дүнд, эрдэм шинжилгээний хэвлэлийг нэвт судалсан мэдлэгт тулгуурласан байх ёстой

D. Нийтээр баримталдаг шинжлэх ухааны зарчмыг дагаж сайтар бэлдсэн лабораторийн болон амьтанд туршсан туршилтын дүнд, эрдэм шинжилгээний хэвлэлийг нэвт судалсан мэдлэгт тулгуурласан байх ёстой.

E. Улс даяар баримталдаг шинжлэх ухааны зарчмыг дагаж лабораторийн болон амьтанд туршсан туршилтын дүнд, эрдэм шинжилгээний хэвлэлийг судалсан мэдлэгт тулгуурласан байх ёстой

/81./ Хүнийг хамруулах судалгааны бүх төслийг магадлуулан батлуулахаар ямар байгууллагаар хэлэлцүүлэхээр оруулдаг вэ?

A. Хүний эрхийн комисс

B. Эрдмийн зөвлөл

C. Эрүүл мэндийн ямаас байгуулсан ажлын хэсэг

D. Ёс зүйн хороо

E. Тусгай комисс

/82./ Био-анагаахын судалгааны ёс зүйн үр ашигтай байх зарчимд хамаарахыг олно уу

A. Хор үл хүргэх зарчмыг шаардлагатай тохиолдолд үр ашигтай байхаар ашиглах явдал

B. Тэнцүү үнэнч шударгын зарчмыг баримталж 2талд ашигтай байх үүднээс судалгааг дуусгах

C. Судалгааны үед гэнтийн осолын улмаас хүн бэртэх тохиолдолд үр ашигтай байх зарчмыг баримталж судалгааг дуусгах

D. Ашиг тусыг дээд зэргээр үзүүлэх, хор хөнөөл, алдааг дээд зэргээр багасгах ёс зүйн үүргийг хэлнэ

E. Үр ашгийг шударга тэнцүү хуваарилах явдал

/83./ Судлаач болон хандивлагчийн хүлээх үүрэгт аль нь хамаарахгүй вэ?

A. Шударга бус ов заль гаргах, зохисгүй нөлөө, сүрдүүлэх байдал үл гаргах

В. Нөхцөл болон ажиллабар, судалгааны арга зүй, таниулсан зөвшөөрөлд өөрчлөлт орсон бол ёс зүйн хяналтын хороогоор дахин хэлэлцүүлэх

С. Оролцогч судалгаатай холбоотой баримт, үр дагаврын талаар зохих ойлголт авсан, хамрагдах эсэхээ шийдэх боломжоор бүрэн хангагдсаны дараа зөвшөрөл хүсэх

Д. Судалгаанд оролцогчийн хүсэлтийг харгалзан, судалгааны арга зүйн талаар санал бодлыг нь сонсож, судалгааны арга зүйд тусгах

Е. Хэдийгээр судалгааны аргачлал, зорилтод өөрчлөлт ороогүй байсан ч удаан хугацаагаар хийгдэх судалгаанд оролцогчдын таниулсан зөвшөөрлийг тухайн нөхцөл байдалд нь тохируулан тодорхой хугацаанд шинэчилж, хянуулах

/84./ Био-анагаахын судалгаанд хүнийг хамруулах ёс зүйн удирдамжийн хүрээнд “Эмзэг бүлэг” гэдэг ойлголтыг нэрлэнэ үү

А. Таниулсан зөвшөөрөл өгөх чадвартай ч эмнэлгийн тусламж, бусад үнэ ихтэй үйлчилгээ авах боломжгүй, өөрийн ашиг сонирхлоо хамгаалах чадвартай бүлгийг хэлнэ.

В. Таниулсан зөвшөөрөл өгөх чадваргүй, эмнэлгийн тусламж, бусад үнэ ихтэй үйлчилгээ авах боломжгүй, өөрийн ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бүлгийг хэлнэ.

С. Бие даан амьдрах чадваргүй, эмнэлгийн тусламж авах боломжтой ч үнэ ихтэй үйлчилгээ авах боломжгүй, өөрийн ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бүлгийг хэлнэ.

Д. Өрхийн наад захын амьжиргаагаа залгуулах чадваргүй, эмнэлэгийн тусламж авах, үнэ ихтэй үйлчилгээ авах боломжгүй, ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бүлгийг хэлнэ.

Е. Бие даан амьдрах чадваргүй, эмнэлгийн тусламж авах боломжтой ч үнэ ихтэй үйлчилгээ авах боломжгүй, өөрийн ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бүлэг этгээдүүдийг хэлнэ.

/85./ Өвчтний нууцлал гэж

А. Эмчилгээ хийлгэж байгаа өвчтнүүдийн мэдээллийг хариуцан эмчилж байгаа эмч маш сайн мэдэж нууцалж бусдад тараахгүй байхыг хэлнэ

В. Эмчилгээ хийлгэж байгаа өвчтнүүдийн мэдээллийг мэдээлэл хэрэгтэй ,эрхтэй этгээдэд үзүүлдэг

С. Эмчилгээ хийлгэж байгаа өвчтнүүдийн мэдээллийг эмч маш сайн нууцалж, мэдээлийг зөвхөн тэднийг эмчлэх үүрэгтэй сувилагч ажилтан мэдэх

Д. Эмчилгээ хийлгэж байгаа өвчтнүүдийн мэдээллийг эмч маш сайн нууцалж, мэдээлэл хэрэгтэй хүнд эсвэл тэднийг эмчлэх үүрэгтэй сувилагч ажилтан зэрэг хуулийн эрхтэй этгээдэд мэдээлэхийг хэлнэ

Е. Эмчилгээ хийлгэж байгаа өвчтнүүдийн мэдээллийг ойр дотны хүмүүс мэдэх эрхтэй

/86./ Гаднаас ивээн тэтгэх судалгаа гэж юуг ойлгох вэ

А. Монгол улсад хийгдэх боловч олон улсын болон Монгол улсын зохих эрх мэдэл бүхий байгууллага, хүрээлэн хүмүүстэй хамтран зөвшилцөж судалгааг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь ивээн тэтгэж санхүүжилт явуулахыг хэлнэ.

В. Олон улсын болон Монгол улсын зохих эрх мэдэл бүхий байгууллага, хүрээлэн хүмүүстэй хамтран зөвшилцөж судалгааг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь ивээн тэтгэж санхүүжилт явуулахыг хэлнэ.

С. Монгол улсад хийгдэх боловч олон улсын болон Монгол улсын зохих эрх мэдэл бүхий байгууллага, хүрээлэн хүмүүстэй хамтран зөвшилцөж судалгааны зөвхөн зарим хэсгийг нь ивээн тэтгэхийг хэлнэ.

Д. Монгол улсад хийгдэх боломжгүй олон улсын зохих эрх мэдэл бүхий байгууллага, хүмүүстэй хамтран зөвшилцөж судалгааг бүхэлд нь ивээн тэтгэж санхүүжилт явуулахыг хэлнэ.

Е. Монгол улсад л хийгдэх боломжтой Монгол улсын зохих эрх мэдэл бүхий хүрээлэн хүмүүстэй хамтран судалгааны зарим хэсгийг нь ивээн тэтгэж санхүүжилт явуулахыг хэлнэ.

/87./ Таниулсан зөвшөөрөл өгөх чадваргүй оролцогчийг судалгаанд хамруулах тохиолдолд түүнд учирч болох эрсдэл нь түүний энгийн, өргөн хэрэглэгддэг судалгаа шинжилгээнд хамрагдах үед гарч болох эрсдлийн зэрэгтэй харьцах харьцаа ямар байх вэ?

А. Илүү гарч болно.

В. Илүү гарч болохгүй боловч судалгааны өндөр ач холбогдолтой, ёс зүйн хороогоор зөвшөөрөгдсөн тохиолдолд маш бага илүү гарч болно.

С. Бага зэрэг доогуур байж болно

D. Тэнцүү харьцаатай байна

E. Байгалийн голомтот болон гоц халдварт өвчний дэгдэлтийн үед нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдалд заналхийлэхүйц нөхцөл байдлын үед илүү байна.

/88./ Био-анагаахын судалгаанд таниулсан зөвшөөрөл өгөх чадваргүй, эмнэлгийн тусламж бусад үнэ ихтэй үйлчилгээ авах боломжгүй, өөрийн ашиг сонирхолоо хамгаалах чадваргүй бүлгийг ямар бүлэг гэдэг вэ?

A. Халамжит бүлэг

B. Тэтгэмжит бүлэг

C. Тусгай бүлэг

D. Эмзэг бүлэг

E. Чадамжгүй бүлэг

/89./ Ёс зүйн хяналтын хороо нь ямар үүрэгтэй вэ?

A. Ёс зүйн хяналтын хороо нь судалгааны явцад оролцогчийн аюулгүй байдалыг хангахад л хариуцлага хүлээнэ.

B. Ёс зүйн хяналтын хороо нь судалгаанд оролцогчийн эрүүл мэндэд л хариуцлага хүлээнэ

C. Ёс зүйн хяналтын хороо нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эрхийг хамгаалах хариуцлага хүлээнэ.

D. Ёс зүйн хяналтын хороо нь судалгаанд оролцогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эрхийг хамгаалах хариуцлага хүлээнэ.

E. Ёс зүйн хяналтын хороо нь судалгаанд оролцогчийн эрхийг хамгаалах асуудалд хариуцлага хүлээнэ.

/90./ Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөлийн зорилгыг тодорхойлно уу.

A. Ёс зүйн хяналтыг хангах зорилготой.

B. Эрдмийн зөвлөл болон ёс зүйн хяналтыг хангах зорилготой.

C. Судалгаанд оролцогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эрхийг хамгаалах зорилготой.

D. Судалгаанд оролцогчийн аюулгүй байдал, эрхийг хамгаалах зорилготой.

E. Хүний эрүүл мэндэд ашиг тустай эмчилгээний шинэ арга зам нээж илрүүлэх зорилготой.

/91./ Бүлэг хүмүүс болон олон нийтийг судалгаанд хамруулахаар урихдаа судлагааны эрсдэл, ашиг тус хоёрын алийг нь илүү харгалзан үзэж сонговол зохих вэ?

A. Эрсдэлийг

B. Ашиг тусыг

C. Тэнцвэртэй авч үзэх

D. Зөвхөн шинжлэх ухаанч чанарыг

E. Зөв хариулт байхгүй

/92./ Гадны хандивлагчтай хамтарсан судалгаанд ивээн тэтгэгч болон судлаач нарын дэвшүүлж буй биоангаахын судалгааны төсөл нь ёс зүйн ямар үүрэг хүлээх бэ?

A. Бие даасан, чадварлаг ёс зүйн хяналтын хороог байгуулах судалгааны чадавхийг бэхжүүлэх ёс зүйн үүрэг хүлээнэ.

B. Төсөл боловсруулах, гүйцэтгэх болон судалгааны явцад хяналт тавих чадавхийг буй болгож сайжруулахад үр ашигтай оролцох ёс зүйн үүрэг хүлээнэ.

C. Гүйцэтгэх, ёс зүйн болон судалгааны явцад хяналт тавих чадавхийг буй болгож сайжруулахад үр ашигтай оролцох ёс зүйн үүрэг хүлээнэ.

D. Эрүүл мэндийн тусламж болон биоангаахын судалгаанд зохистой технологи нэвтрүүлж хөгжүүлэх ёс зүйн үүрэг хүлээнэ.

E. Эмч, мэргэжилтэн, судлаач шаардлагатай хүний нөөцийг бэлтгэж сургах ёс зүйн үүрэг хүлээнэ.

/93./ Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөлийн зорилго юу вэ

A. Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөл нь хүний генд ашиг тустай шинэ арга зам нээж илрүүлэх зорилготой

B. Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөл нь хүний удамшлын тухай мэдээллийг илрүүлэх зорилготой

С. Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөл нь амьд биетэнд ашиг тустай шинэ арга нээх зорилготой

D. Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөл нь хүний эрүүл мэндэд ашиг тустай шинэ арга зам нээж илрүүлэх зорилготой

E. Хүнийг хамруулсан биоанагаахын судалгааны ёс зүйн зөвтгөл нь эрүүл мэндэд тустай шинэ арга илрүүлэх зорилготой

/94./ Чадавхийг тодорхойлоход ямар үйл ажиллагаа ордог вэ?

1. Бие даасан, чадварлаг ёс зүйн хяналтын хороог буй болгож бэхжүүлэх
2. Судалгааны чадавхийг бэхжүүлэх
3. Эрүүл мэдийн тусламж болон биоанагаахын судалгаанд зохистой технологи нэвтрүүлж хөгжүүлэх
4. Эмч, мэргэжилтэн, судлаач, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэж сургах
5. Судалгаанд оролцогч болон олон нийтэд мэдлэг олгох

/95./ Плацебо буюу хоосон эмчилгээ хэрэглэж болох тохиолдлууд

1. Тухайн судалгааг гүйцэтгэхэд батлагдсан үр дүнтэй ажилбар байхгүй байх
2. Судалгаанд оролцогчод батлагдсан үр дүнтэй ажиллабарыг хийлгүүлэхэд тур зуурын таагүй байдал, зовиур үүсгэвэл
3. Судалгаанд батлагдсан үр дүнтэй ажилбар хэрэглэсэн ч үр дүн өгөхгүй бол плацебо буюу хоосон эмчилгээ хэрэглэх нь оролцогчдод илүү эрсдэл үүсгэхгүй
4. Үр дүнтэй өөр сонголт байх
5. Илүү их эрсдэл үүсгэх

/96./ Эмэг бүлгийн хүмүүсийг судалгаанд хамруулахын тулд судлаач ямар шаардлагыг бүелүүлсэнээ ёс зүйн хяналтын хороонд танилцуулах зарчмыг баримтлах ёстой вэ?

1. Судалгаа эмзэг бус хүмүүст ижил түвшинд явагдах боломжгүй байх;
2. Судалгаа эмзэг бүлгийн хүн амаас сонгогдон оролцож байгаа эсвэл энэ бүлэгт хамаардаг хүмүүст онцлон тохиолддог өвчин эсвэл эрүүл мэндийн бусад асуудлын оношилгоо, эмчилгээ, сэргийлэлтийг сайжруулах арга замыг олж авахыг зорьсон байх;
3. Судалгаанаас гарах эмчилгээ, оношилгоо, урьдчилан сэргийлэлтийн ашиг тус нь оролцогчдод хүртээмжтэй, нээлттэй байх;
4. Судалгаанд хамрагдсанаар гарч болох эрсдэл нь тэдний хийлгүүлдэг энгийн ажиллабар, шинжилгээний эрсдэлээс илүүгүй байх, хэрвээ бага зэрэг илүү гарсан бол тэр нь ёс зүйн хяналтын хороогоор хүлээн зөвшөөрөгдсөн байх;
5. Судалгаанд хамрагдагчийн таниулсан зөвшөөрөл өгөх чадвар хангалтгүй үед түүний албан ёсны халамжлагч, хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг давхар авах

/97./ Туршилтын эмчилгээг зовлонг нь нимгэлэх яаралтай тусламжийн зорилгоор зохих зөвшөөрөл авахаас өмнө хэрэглэх шалгуурт аль нь багтах вэ?

1. Эмчилгээний үр дүн тааламжтай байж болох зарим нэг нотолгоо байх
2. Өвчтөнд яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай байх
3. Тухайн эмчилгээтэй тэнцэх эсвэл түүнээс илүү үр дүнтэй ямар нэг эмчилгээ байхгүй
4. Өвчтөний ар гэрийнхний зөвшөөрлийг авсан байх
5. Тохирох хариулт байхгүй

/98./ Био-анагаахын судалгаанд судалгааны арга зүйн баталгааг хангах арга замыг нарийвчлан тусгасан байх ёстой. Эдгээрээс аль нь хамаарах вэ?

1. Зорилго, хүнийг хамруулах шаардлага;
2. Мэдэгдэж буй эрсдэл түүнээс зайлсхийх;
3. Хүнийг хамгаалах;
4. Хамрагдагсад зохистой мэдээлэл авч, сайн дураараа урьдчилан зөвшөөрөл өгөх баталгааг хангах;
5. Шинжлэх ухааны ба ёс зүйн талаас нь судлаачаас хараат бус, зохих хууль ёсны нэг буюу хэд хэдэн этгээдээр заавал үнэлгээ өгүүлсэн байх;

/99./ Судалгааны хандивлагч нь ёс зүйн хувьд ямар нөхцөлийг хангаж өгөх үүрэгтэй вэ?

1. Судалгааг аюулгүй явуулахад шаардагдах эрүүл мэндийн тусламж үзүүлэх
2. Судалгааны ажилбарын улмаас гэмтсэн үед зохих хохирлыг нөхөх
3. Судалгааны дүнд бүтээсэн ашиг тустай ажилбар, шинэ бүтээгдэхүүнийг хүн амд хүртээмжтэй болгох үйлчилгээ үзүүлэх

4. Судалгаанд хамрагдсан иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөөг цаг тухайд нь өгөх

5. Судалгаанд хамрагдагчдыг сонгож авах

/100./ Ёс зүйн болон эрдэм шинжилгээний хяналт, биоанагаахын судалгааны чадавхийг тодорхойлох үндсэн үйл ажиллагаанд аль нь багтах вэ?

1. Эмч, мэргэжилтэн, судлаач, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэж сургах

2. Судалгааны чадавхийг бэхжүүлэх

3. Эрүүл мэндийн тусламж болон биоанагаахын судалгаанд зохистой технологи нэвтрүүлж хөгжүүлэх

4. Судалгаанд оролцогч болон олон нийтэд мэдлэг олго

5. Олон улсын сайн дурын нийгэмлэг, хандивын сангуудтай харилцах харилцааг бэхжүүлж, санхүүжилт олох

/101./ Судалгааны багийн гишүүд эх зөвшөөрлийг боловсруулахдаа судалгаанд оролцогчтой юуг зөвшилцөх вэ?

1. Судалгаанд сорьцыг дахин ашиглах эсэх, хэрэв дахин ашиглах бол уг сорьцонд хийх судалгааны төрөл нь анхныхтай ижил төстэй байх эсэх;

2. Дахин ашиглах бол чухам ямар нөхцөлд судлаач нэмэлт зөвшөөрөл авах шаардлагатайг тогтоох;

3. Судлаачид өвчний түүхийн тэмдэглэл болон сорьцоос өвчтөнийг таньж болох мэдээллийг арилгах төлөвлөгөө бий эсэх;

4. Оролцогч өөрийн өвчний түүхийн тэмдэглэл болон сорьц дахь гэрэл зураг, видео болон аудио хуурцаг зэрэг эмзэг материалыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн арилгах, нэр хаяггүй болгох хүсэлт гаргаж болох эсэх;

5. Судалгаанд оролцогчийн сэтгэл зүйн байдал хэвийн эсэх

/102./ Эмч ба өвчтөн хоёрын хоорондын нууцлалд юуг ойлгох вэ?

1. Хоорондоо харилцах харилцаанд ямар нэгэн нууц зүйлсийг ярилцахгүй байх;

2. Эмчлэгч эмч, өвчтөний зөвшөөрөлгүй түүний нэр, хаяг, бусад мэдээллийг судлаачдад дэлгэн үзүүлж болохгүй.

3. Эмчлэгч эмч нь тухайн өвчтөний хувийн асуудлыг нэр бүрчлэн асууж тодруулах, тэдгээрийг шаардлагатай хүмүүст мэдээллэхийг ойлгоно.

4. Эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнүүдийн мэдээллийг эмч маш сайн нууцалдаг, мэдээлэл хэрэгтэй хүнд эсвэл тэднийг эмчлэх үүрэгтэй сувилагч ажилтан зэрэг хуулийн эрхтэй этгээдэд үзүүлдэг гэдэгт итгэлтэй байх эрхтэй

5. Эмчлэгч эмч өөрийн хувийн амьдарлыг ярьж өвчтөнөөс зөвөлгөө авч болно. Өвчтөн түүний ярьсан зүйлийг бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй.

/103./ Судалгааны багийн гишүүд эх зөвшөөрлийг боловсруулахдаа судалгаанд оролцогчтой ямар зүйлсийг зөвшилцөх вэ?

1. Судалгаанд сорьцыг дахин ашиглах эсэх, хэрэв дахин ашиглах бол уг сорьцонд хийх судалгааны төрөл нь анхныхтай ижил төстэй байх эсэх;

2. Дахин ашиглах бол чухам ямар нөхцөлд судлаач нэмэлт зөвшөөрөл авах шаардлагатайг тогтоох;

3. Судлаачид өвчний түүхийн тэмдэглэл болон сорьцоос өвчтөнийг таньж болох мэдээллийг арилгах төлөвлөгөө бий эсэх;

4. Оролцогч өөрийн өвчний түүхийн тэмдэглэл болон сорьц дахь гэрэл зураг, видео болон аудио хуурцаг зэрэг эмзэг материалыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн арилгах, нэр хаяггүй болгох хүсэлт гаргаж болох эсэх;

5. Оролцогчдоос шаардагдах хугацаа (судалгааны төвд ирэх тоо, зарцуулах цаг, нийт хугацаа) болон түрүүлж дуусгах боломжтой эсэхийг;

/104./ Хүнийг оролцуулсан бүх судалгааны ёс зүйн үндсэн зарчимд хамаарах нь аль нь вэ?

1. Үнэнч байх зарчим

2. Үр ашигтай байх зарчим

3. Хувь хүнийг хүндэтгэх зарчим

4. Энэрэнгүй байх зарчим

5. Зан суртахуунд нийцэх зарчим

/105./ Хүнийг хамруулсан судалгаа гэж юуг ойлгох вэ?

1. Эрүүл ба өвчтэй хүний биеийн физиологи, биохими, эмгэг үйл ажиллагааны болон физик, хими, сэтгэл зүйн нөлөөллийн хариуд үүсэх урвалын судалгаа;

2. Хувь хүний биологийн онцлогоос үл хамаарч нийт хүмүүст өвөрмөц нөлөө үзүүлж байгааг нотлох зорилготой олон хүнийг хамруулсан оношлогоо, сэргийлэлт, эмчилгээний аргын хяналттай туршилт;

3. Өвөрмөц сэргийлэлт эсвэл эмчилгээний аргыг хувь хүн болон олон нийтэд хэрэглэсний дараах үр дагаварыг тодорхойлох судалгаа;

4. Харилцан адилгүй орчинд амьдарч буй хүмүүсийн эрүүл мэндийн зан үйлтэй холбоотой судалгаа;

5. Судалгаанд ажиглалт хийх, физик, хими, сэтгэл зүйн нөлөө үзүүлэх зэрэг олон аргыг ашиглах;

/106./ Судалгаанд оролцогчоос зөвшөөрөл хүсэхийн өмнө судлаач ямар мэдээллийг тайлбарлан танилцуулж, оролцогчид ойлгуулсан байх ёстой вэ?

1. Судалгаанд урилгаар болон сайн дураар оролцох учиртайг;

2. Ямар нэгэн төлбөр, торгуульгүйгээр, хүртэх байсан ашиг тусаа алдахгүйгээр хүссэн үедээ судалгааг орхих, оролцохоос татгалзах эрхтэйг

3. Судалгааны зорилгыг оролцогчид тайлбарлаж, үйл ажиллагаа нь өдөр тутмын эмнэлгийн үйл ажиллагаанаас ямар ялгаатай болохыг

4. Хяналттай туршилт судалгааны төрөл арга зүйг тайлбарлаж, сул далдлалтын журам алдагдах тул оролцогчдод судалгаа дуусаагүй байхад туршиж буй эмчилгээний тухай хэлэх боломжгүйг

5. Оролцогчдоос шаардагдах хугацаа (судалгааны төвд ирэх тоо, зарцуулах цаг, нийт хугацаа) болон түрүүлж дуусгах боломжтой эсэхийг;

/107./ Хүнийг оролцуулсан бүх судалгаа ёс зүйн үндсэн зарчимд нийцэж хийгдэх ёстой. Үүнд:

1. Хувь хүнийг хүндэтгэж үзэх зарчим

2. Үр ашигтай байх зарчим

3. Үнэнч байх зарчим

4. Хувь хүний бие даасан байдлыг хүндэтгэх зарчим

5. Хувь хүний бие даасан байдал нь хязгаарлагдсан эсвэл хямарсан хүнийг хамгаалах зарчим

/108./ Хүнийг хамруулсан судалгаанд ямар судалгаа ордог вэ?

1. Эрүүл ба өвчтэй хүний биеийн физиологи, биохими, эмгэг үйл ажиллагааны болон физик, хими, сэтгэл зүйн нөлөөллийн хариуд үүсэх урвалын судалгаа;

2. Хувь хүний биологийн онцлогоос үл хамаарч нийт хүмүүст өвөрмөц нөлөө үзүүлж байгааг нотлох зорилготой олон хүнийг хамруулсан оношлогоо, сэргийлэлт, эмчилгээний аргын хяналттай туршилт

3. Өвөрмөц сэргийлэлт эсвэл эмчилгээний аргыг хувь хүн болон олон нийтэд хэрэглэсний дараах үр дагаварыг тодорхойлох судалгаа

4. Харилцан адилгүй орчинд амьдарч буй хүмүүсийн эрүүл мэндийн зан үйлтэй холбоотой судалгаа

5. Эмзэг бүлгийн хүмүүсийн эрүүл мэндийн хэрэгцээтэй холбоотой судалгаа

/109./ Хүүхдийг хамруулсан судалгаа хийхийн өмнө судлаач нь ямар шаардлагыг хангасан байх ёстой бэ?

1. Насанд хүрэгсдийг оруулах бүрэн бололцоотой судалгааг хүүхэд дээр хийхгүй байх;

2. Судалгааны зорилго нь хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг олж авахад чиглэгдсэн байх;

3. Хүүхэд бүрийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авах;

4. Таниулсан зөвшөөрөл нь хүүхэд бүрийн чадварын хир хэмжээнд тохирсон байх;

5. Хүүхэд судалгаанд хамрагдах, үргэлжлүүлэхээс татгалзвал түүний саналыг хүндэтгэн үзэх;

/110./ Био-анагаахын судалгааны ёс зүйн хяналтын хорооны үндсэн хариуцлага дараах зүйлд оршино. Үүнд:

1. Төслийг хэрэгжүүлэх явцад гарах ёс зүйн асуудлууд нь онол болон практикийн хувьд бүрэн шийдвэрлэгдэх боломжтойг батлах;

2. Судлах гэж буй бүхий л ажиллабар, ялангуяа эм, вакцин, шинээр бүтээсэн буюу сайжруулж буй эмнэлгийн хэрэгслийг ашиглах нь хүнд харьцангуй аюулгүй гэдгийг тогтоох, өмнө нь мэргэжлийн шинжээч шалгаж тогтоосон болохыг батламжилж өгөх;

3. Судалгааны төсөл нь шинжлэх ухааны үндэслэлтэй эсэхийг тогтоох эсвэл мэргэжлийн эксперт өмнө нь тогтоосныг батламжилж өгөх;

4. Судлаачийн боловсрол, туршлага, болон судалгааг аюулгүй нөхцөлд явуулах чадварыг авч үзэх

5. Гаргасан шийдвэрийг хадгалах, хийж буй судалгааны явцад дүгнэлт өгөх /111./ Био-анагаахын судалгаанд таниулсан зөвшөөрөл гэсэн ойлголтонд хамааралтай тодорхойлолтуудыг сонгоно уу.

1. Шаардлагатай мэдээллийг авч түүнийг бүрэн ойлгож ухамсарласан, сайтар тунгаан бодсоны эцэст албадах, зоригжуулах буюу сүрдүүлэх, зохисгүй нөлөөнд үл автагдсан шийдвэр гаргах чадвар бүхий хувь хүнээс авсан зөвшөөрлийг хэлнэ.

2. Таниулсан зөвшөөрөл нь өөрийгөө жолоодох чадвар бүхий хувь хүн судалгаанд хамрагдах эсэхээ чөлөөтэй сонгох зарчимд тулгуурлана

3. Таниулсан зөвшөөрөл нь хувь хүний сонгох эрхийг хамгаалж бие даасан байдлыг нь хүндэтгэнэ

4. Таниулсан зөвшөөрөл авах үйл явц судалгаанд хамрагдагчтай анх уулзсан мөчөөс эхлэн судалгааны явцад ч үргэлжилнэ.

5. Хүмүүст мэдээлж, уйгагүй тайлбарлаж, тавьсан асуултад нь хариулж судалгааны ажиллабар бүрийн тухай ойлгуулснаар, судлаач тэднээс таниулсан зөвшөөрөл авах нөхцлийг бүрдүүлдэг ба тэдний нэр хүнд, бие даасан байдлыг хүндэтгэж буйгаа нотлон харуулдаг.

/112./ Хязгаарлагдмал орлоготой бүлэг хүн амд судалгаа явуулахын өмнө судлаач болон ивээн тэтгэгч ямар зүйлийг баталгаажуулсан байх ёстой вэ?

1. Хүн амд тухайн өвчин тархсан байх үүнийг цаашдаа судлах шаардлагатай байх

2. Судалгаанд оролцож байгаа хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, тулгамдсан зорилтод нийцсэн бай

3. Тухайн судалгаа нийт хүн амд хэрэгцээтэй эсэх

4. Судалгааны дунд боловсруулсан аливаа ажиллабар, бүтээгдэхүүн шинэ мэдлэг нь тухайн хүн ам, олон нийтийн эрх ашигт хүртээмжтэй байх

5. Орлого багатай бүх иргэдэд хүрч чадах эсэх

/113./ Ёс зүйн хяналтын хороо Хүнийг хамруулах судалгааны бүх төслийг хаана магадлуулан батлуулахаар оруулах ёстой вэ

1. Санхүүжилт авч буй байгууллага

2. Ёс зүйн хяналтын хороо

3. Эрүүл мэндийн яам

4. Эрдмийн зөвлөл

5. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо

/114./ Хүүхдийг хамруулсан судалгаа хийхийн өмнө судлаач ямар шаардлага хангасан байх ёстой вэ?

1. Насанд хүрэгсэдийг оролцуулах бүрэн боломжтой судалгааг хүүхэд дээр хийхгүй бай

2. Судалгааны зорилго нь хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой мэдлэгийг олж авахад чиглэсэн байх

3. Хүүхэд бүрийн эцэг, эх хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авах

4. Хүүхэд судалгаанд хамрагдах, үргэлжлүүлэхээс татгалзвал түүний саналыг хүндэтгэн үзэх

5. Таниулсан зөвшөөрөл нь хүүхэд бүрийн чадварын хир хэмжээнд тохирсон байх

/115./ Судлаач эмч нь шинжлэх ухааны зорилгоор хүний биед туршилт явуулах бол ямар үүрэг хүлээх бэ?

1. Судалгаанд хамрагдагчийг эмчлэхдээ ар гэрийн амьдарлыг хянах үүрэг хүлээнэ.

2. Судалгаанд хамрагдагчийн эрүүл мэндийг хамгаалах үүрэг хүлээнэ.

3. Судалгаанд хамрагдагчийн хувийн нууцыг хамгаалах үүрэг хүлээнэ.

4. Судалгаанд хамрагдагчийн амь насыг бүрэн хамгаалах үүрэг хүлээнэ.

5. Судалгаанд хамрагдагчийн хүсэл сонирхолыг хамгаалах үүрэг хүлээнэ.

/116./ Судалгааны багийн гишүүд эх зөвшөөрлийг боловсруулахдаа судалгаанд оролцогчтой юуг зөвшилцөх вэ?

1. Ххийгдэх бүх сорилын жагсаалт
2. Давтамж тун хэмжээ
3. Хоцорсон оролцогчдыг судалгаанд үргэлжлүүлэн оруулах эсэх
4. Туршилтын зүйл оролцогчдод ямар хэлбэрээр, хэрхэн олгох, бүртгэх, хянах
5. Туршилтын хугацаа

/117./ Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо нь судалгааны төслийн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд уг бүрэлдэхүүнд дараах этгээдүүд багтана.

1. Эмч, сувилагч
2. Эрдэм шинжилгээний ажилтан
3. Хуульч, ёс зүйч
4. Шашны төлөөлөгч
5. Нутгийн соёл, ёс заншлыг сайн мэддэг жирийн иргэд

/118./ Хязгаарлагдмал орлогтой бүлэг хүн амд судалгаа явуулахын өмнө судлаач болон ивээн тэтгэгч ямар зүйлсийг баталгаажуулах ёстой бэ?

1. Судалгаанд оролцогч хүмүүсийн амьжиргааны түвшинд нийцсэн байх;
2. Судалгаанд оролцож буй хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, тулгамдсан зорилтод нийцсэн байх;
3. Олон нийтийн эрх ашигт хүртээмжтэй байх;
4. Судалгааны дүнд боловсруулсан аливаа ажиллбар, бүтээгдэхүүн, шинэ мэдлэг нь тухайн хүн ам, олон нийтийн эрх ашигт хүртээмжтэй байх;
5. Нийт хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, тулгамдсан зорилтод нийцсэн байх;

/119./ Таниулсан зөвшөөрөл авахад судлаач болон ивээн тэтгэгчийн үүрэг

1. Шударга бус ов заль гаргах, зохисгүй нөлөө, сүрдүүлэх байдал үл гаргах;
2. Оролцогч судалгаатай холбоотой баримт, үр дагаврын талаар зохих ойлголт авсан, хамрагдах эсэхээ шийдэх боломжоор бүрэн хангагдсаны дараа зөвшөөрөл хүсэх;
3. Ерөнхий журмын дагуу судалгаанд хамрагдагч бүрээс гарын үсэг зурсан таниулсан зөвшөөрөл авах, үүнээс гажих онцгой тохиолдлын үед судлаач ёс зүйн хяналтын хорооны баталгаа авах
4. Нөхцөл болон ажилбар, судалгааны арга зүй, таниулсан зөвшөөрөлд өөрчлөлт орсон бол ёс зүйн хяналтын хороогоор дахин хэлэлцүүлэх
5. Хэдийгээр судалгааны аргачлал, зорилтод өөрчлөлт ороогүй байсан ч удаан хугацаагаар хийгдэх судалгаанд оролцогчдын таниулсан зөвшөөрлийг тухайн нөхцөл байдалд нь тохируулан тодорхой хугацаанд шинэчилж, хянуулах;

/120./ Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн улмаас таниулсан зөвшөөрөл өгөх чадваргүй хүний судалгаанд хамруулахын өмнө судлаач ямар шаардлагыг хангасан байх ёстой бэ?

1. Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгтэй хүнийг эрүүл (таниулсан зөвшөөрөл өгөх чадвартай) хүнийг оролцуулан хийх судалгаанд хамруулахгүй байх;
2. Зайлшгүй хийх судалгаа нь сэтгэц болон зан үйлийн эмгэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн асуудлыг тодорхойлох зорилготой байх;
3. Таниулсан зөвшөөрлийг хувь хүн бүрийн чадварын хэмжээнд тохируулж авах;
4. Судалгаанд оролцогч өөрөө зөвшөөрөл өгөх чадваргүй бол хууль ёсны дагуу гэр бүлийн гишүүн эсвэл албан ёсны асран хамгаалагчаас нь зөвшөөрөл авах;
5. Судалгаа хийхийн тулд тусгай нарийн мэргэжил эзэмшсэн байх;

/121./ Эмзэг бүлгийн хүмүүсийг судалгаанд хамруулахдаа судлаач ямар шаардлага биелүүлснээ ёс зүйн хяналтын хороонд танилцуулах ёстой вэ?

1. Судалгаа эмзэг бус хүмүүст ижил түвшинд явагдах боломжгүй байх
2. Эмзэг бүлэгт хамаардаг хүмүүст онцлон тохиолддог өвчин, эмчилгээ оношлогоо, сэргийлэлтийг сайжруулах арга замыг олж авахыг зорьсон байх
3. Судалгаанаас гарах эмчилгээ оношлогоо, урьдчилан сэргийлэлтийн ашиг тус нь оролцогчдод хүртээмжтэй, нээлтэй байх
4. Судалгаанд хамрагдсанаар гарч болох эрсдэл нь тэдний хийлгүүлдэг энгийн ажиллбар, шинжилгээний эрсдэлээс илүүгүй байх

5. Судалгаанд хамрагдагчийн таниулсан зөвшөөрөл өгөх чадвар хангалтгүй үед түүний албан ёсны халамжлагч , хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг давхар авах /122./ Хүмүүсийг хамруулсан болон хүний тодорхой эд эрхтнийг ашиглах судалгааны ёс зүйн чухал онцлог нь ямар нөхцөлд зөвтгөгдөх бэ?

1. Өөр замаар олж авах боломжгүй мэдээллийг буй болгох арга замыг дэвшүүлэх
2. Судлаачид нь өндөр чадвартай, туршлагатай
3. Туршлагаараа өөрсдийн үүргээ бүрэн гүйцэтгэх чадвартай;
4. Шинжлэх ухааны нотолгоотой
5. Хүний эрүүл мэндэд ашиг тустай шинэ арга зам нээж илрүүлсэн;

/123./ Удирдах ажилтан нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс оролцож болох уу?

- A. Болно
- B. Зөвхөн зааварчилж болно
- C. Зөвхөн шаардаж болно
- D. Болохгүй
- E. Зарим тохиолдолд болно

/124./ Эрүүл мэндийн байгууллага нь ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж, ямар хүрээнд хариуцлага тооцож ажиллах ёстой вэ?

- A. Эрх хэмжээний хүрээнд
- B. Байгууллагын хүрээнд
- C. Ёс зүйн хэм хэмжээний хүрээнд
- D. Эрүүл мэндийн байгууллагын хүрээнд
- E. Эмнэлгийн хүрээнд

/125./ Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр ,биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн , эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал эд материал , сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүдүүлэх , туган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэл нь

- A. Жендерийн шууд бус ялгаварлан гадуурхалт юм
- B. Жендерийн шууд ялгаварлан гадуурхалт юм
- C. Бэлгийн дарамт юм
- D. Жендерийн хэвшмэл үзэл юм
- E. Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах явдал юм

/126./ Хөндлөнгийн саадгүй орчин гэж

A. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед бусад эмнэлгийн мэргэжилтэн саад болохооргүй өрөө тасалгаа

B. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн саад болохооргүй зориулалтын хаалт

C. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн /бусад эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч/ саад болохооргүй өрөө тасалгаа эсвэл зориулалтан хаалтаар тусгаарлагсан өрөө тасалгаанд тусламж үзүүлэх

D. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн үйлчлүүлэгч саад болохооргүй өрөө тасалгаа эсвэл зориулалтан хаалтаар тусгаарлагсан өрөө тасалганд тусламж үзүүлэх

E. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед бусад эмнэлгийн мэргэжилтэн саад болохооргүй өрөө, хаалтаар тусгаарлагдсан өрөө тасалгаанд тусалцаа үзүүлэх

/127./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн талаархи өөрт байгаа бүх мэдээлээлийг доорхи хүмүүсийн алинд нь өөрийн нь болон хууль ёсны төлөөлөгчийн нь зөвшөөрөлгүйгээр өгч болох вэ?

- A. Сургалтанд ашиглах зорилгоор оюутнуудад
- B. Архивын ажилтанд
- C. Бусад эмч нарт
- D. Судалгаа хийж буй судлаач эмчид
- E. Өгөхгүй

- /128./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар үндэслэлээр бусад эмч , эмнэлгийн мэргэжилтний туслалцаа авч болох бэ ?
- A. Зөвлөх эмчийн заавараар
 - B. Бусадын зөвлөсөнөөр
 - C. Удирдлагын шаардлагаар
 - D. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр
 - E. Хяналт шалгалтынханы зөвлөсөнөөр
- /129./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ял эдэлж буй хүнд тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх вэ
- A. Шүүхий шийдвэрээс үл хамааран тусламж, үйлчилгээг тэгш чанартай үзүүлнэ
 - B. Шүүхийн шийдвэрээс хамаарна, тусламж үйлчилгээг тэгш үзүүлэхгүй
 - C. Тухайн нөхцөл байдлаас хамаарч тодорхой үйлчилгээг үзүүлнэ
 - D. Ял эдэлж буй хүний өвчний байдлаас хамаарна
 - E. Тухайн ял эдэлж буй хүний ухамсарын байдлаас хамаарна
- /130./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмыг юу гэж тодорхойлдог вэ?
- A. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй
 - B. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ
 - C. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим
 - D. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
 - E. Эмнэлгийн мэргэжилтний ёс журам
- /131./ Эмнэлгийн мэргэжилтэн ямар зорилгын үүднээс үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээний тодорхой хувилбарыг тулгаж болохгүй вэ?
- A. Ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд
 - B. Үйлчлүүлэгчийн биеийн бадлыг хөнгөвчлөх зорилгоор
 - C. Байгууллагадаа туслахын тулд
 - D. Үйлчлүүлэгчийн зовиур шаналгааг багасгах зорилгоор
 - E. Үйлчлүүлэгчийн амь насыг аврах зорилгоор
- /132./ Мэргэжил, мэргэшсэн давуу байдлаа ашиглан үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, саад тотгор учруулахгүй байх нь эмчийн баримтлах ямар журам вэ?
- A. Ёс зүйн хэм хэмжээ
 - B. Ёс зүйн горим
 - C. Ёс зүй
 - D. Үүрэг хариуцлага
 - E. Харилцааны хэм хэмжээ
- /133./ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй гэж
- A. Эрх зүйн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаяг , хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголт.
 - B. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой тогтсон дэг жаяг, итгэл үнэмшлийн ойлголт
 - C. Эрх зүйн үйл ажиллагаатай холботой тогтсон дэг жаяг, итгэл үнэмшилийг ойлгоно
 - D. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил , чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголт.
 - E. Эмнэлгийн мэргэжилтний хэвшсэн соёлын тухай ойлголт.
- /134./ Эмнэлгийн мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэж байхдаа бие авч явах соёлын талаархи журмыг хаанаас батлаж мөрдүүлэх бэ?
- A. Эрүүл мэнд, спортын яамнаас
 - B. Холбогдох мэргэжлийн нийгэмлэгүүдээс
 - C. Аймаг , нийслэлийн эрүүл мэндийн газраас
 - D. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс
 - E. Мэргэжлийн салбар зөвлөлөөс
- /135./ Аль тохиолдлуудад эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн зөвшөөрөл үгүйгээр эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болох бэ?
- A. Эрс шийдвэр гаргаагүйгээс үйлчлүүлэгчийн амь нас , эрүүл мэндэд ноцтой эрсдэл учирч болзошгүй
 - B. Эмч өөрөө шийдсэн тохиолдолд

- C. Ойр дотныхоны нь хүсэлтээр
D. Эмнэлгийн удирдлагуудын шаардлагаар
E. Хууль хяналтын ажилтнуудын шаардлагаар
- /136./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ял эдэлж буй хүнд үйлчилгээ үзүүлэх үү?
A. Шүүхийн шийдвэрээс хамаарна
B. Үйлчилгээг ялгавартай үзүүлнэ
C. Үзүүлэхгүй
D. Үзүүлнэ
E. Зөвхөн яаралтай тусламжийг үзүүлнэ
- /137./ Эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхдээ ямар нөхцлөөс бусад тохиолдолд тэгш эрхийн хуваарилалтын зарчмыг баримтлах вэ?
A. Яаралтай тусламж
B. Хүнд өвчтөн
C. Өндөр настан
D. 1сар хүртэлх нярай
E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- /138./ нь анагаах ухаан, сувилахуйн стандартад нийцээгүй үйлчилгээ, үйлдлийг эмчийн зааврын дагуу гүйцэтгэхээс татгалзах эрхтэй ба хэрэв ийм үйлчилгээ, үйлдэл хийхийг шаардсан, зааварласан тохиолдолд шууд харъяалах дээд албан тушаалтанд мэдээлнэ.
A. Эмч
B. Эмнэлгийн ажилтан
C. Сувилагч
D. Бага эмч
E. Тасгийн эрхлэгч
- /139./ Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрээс хамааран өөрийн хувийн ашиг сонирхлыг дээгүүрт тавих уу? Олон нийтийн ашиг сонирхлыг дээгүүрт тавих уу?
A. Өөрийн эрх ашгийг
B. Олон нийтийн эрх ашгийг
C. Хандивлагч байгууллагын эрх ашгийг
D. Байгууллагын эрх ашгийг
E. Байгууллага болон хандивлагч байгууллагын эрх ашгийг
- /140./ Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч, түүний ар гэрийн зөвшөөрөлгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болох уу ?
A. Хэзээд болно
B. Ямар ч тохиолдолд болохгүй
C. Өвчний талаарх мэдээлэл нь үйлчлүүлэгчид сэтгэл зүйн хүнд цохилт өгөх, түүнээс үүдсэн ноцтой үр дагавар учруулах эрсдэлтэй үед болно
D. Үйлчлүүлэгчийн биеийн байдал дунд зэрэг, сэтгэцийн эмгэгтэй байж магадгүй үед
E. Үйлчлүүлэгчийн эцэг эхийг сайн таньдаг үед
- /141./ Үйлчлүүлэгчийн өөрийн нь зөвшөөрөл үгүйгээр үзлэг , эмчилгээ , шинжилгээ хийж байгаа үйлдэлээ нийтийн сурталчилгаанд ашиглаж болох уу ?
A. Хүний эрх , нэр төртэй холбоотой учир болохгүй
B. Бид үйл ажиллагаагаа олонд хүргэхийн тулд байж болох үзэгдэл хэмээн үзэж байна
C. Тухайн үйлчлүүлэгчид бид тус болж байгаа учраас болох болов уу
D. Энэ бол төдийлэн анхаарал татах асуудал бус
E. Энэ бол байж л байдаг үзэгдэл
- /142./ Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн шалгуур аль нь вэ?
A. Эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны шударга ба хуурамч тал
B. Эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны үүрэг
C. Эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны хариуцлага
D. Эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны эрх
E. Эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны үнэлгээ
- /143./ Эмнэлгийн байгууллага, эмнэлгийн бусад мэргэжилтний нэр төр, мэргэжлийн ур чадвар болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу

санаатайгаар хөндлөнгийн хүмүүст дэлгэн ярих шүүмжлэн ярихгүй байх нь эмнэлгийн мэргэжилтний ямар хэм хэмжээ вэ?

- A. Ёс зүйн хэм хэмжээ
- B. Эрх зүйн хэм хэмжээ
- C. Үндсэн хэм хэмжээ
- D. Нийтлэг хэм хэмжээ
- E. Тусгай хэм хэмжээ

/144./ Хэрэв эмнэлгийн мэргэжилтэн өөрийн хувийн эмнэлэгтэй, эсвэл хувийн эмнэлэгт хавсран ажилладаг бол ёс зүйн үүдээс ямар зарчим баримтлах вэ ?

- A. Зайлшгүй илгээх тохиолдолд үйлчлүүлэгчид үнэнийг хэлнэ
- B. Зах зээлийн нийгэм юм чинь өөрийн болон ажилладаг эмнэлгэтэй илгээхэд буруудахгүй, учир нь хүний эрүүл мэнд чухал
- C. Уг асуудал хүний эрх / хувь эмнэлгийн мэргэжилтний / асуудал
- D. Одоо цагт хувийн эмнэлэг төрийн эмнэлгээс илүү үйлчлэж байгаа учир бололцоотой асуудал
- E. Би төрийн өмчийн эмнэлэгт ажилладаг учир надад хамаагүй

/145./ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим гэдэг нь

- A. Эмнэлгийн мэргэжилтэн өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмыг;
- B. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмыг;
- C. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг
- D. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцахад баримтлах зарчмыг;
- E. Эмнэлгийн мэргэжилтэн нийгэмтэй харилцахад баримтлах зарчмыг;

/146./ Яаралтай тусламж шаардагдсан үед үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч нэгэн зэрэг хэд хэдэн эмч дуудаж, ирсэн тохиолдолд хэн нэгнээр нь үйлчлүүлэх талаар онцлон хүсэлт гаргаагүй тохиолдолд яах вэ ?

- A. Түрүүлж ирсэн эмч дараагийн мэргэжилтэнд шилжүүлэх хүртэл тусламж үзүүлнэ
- B. Хэн нь ч болно
- C. Сүүлд ирсэнээр нь хийлгэнэ
- D. Улсын эмнэлгийн эмч тусламж үзүүлнэ
- E. Илүү олон жил ажилласан эмч нь тусламж үзүүлнэ

/147./ Эмнэлгийн мэргэжилтэн ялтанд ямар зарчмыг баримтлан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ёстой вэ?

- A. Батлагдсан онош , стандартын дагуу
- B. Хуулийн ажилтны заавраар
- C. Өөрийн үзэмжээр
- D. Хуульд заасны дагуу
- E. Асуудалд орооцолдохгүй гэсэн хүслээрээ

/148./ Дорхи ухагдахуунуудаас Деонтологи хэмээх ухагдахууны зөв илэрхийллийг ол.

- A. Деонтологи бол ёс зүйн тухай сургаал мөн.
- B. Деонтологи бол иргэний үүрэг хариулагын тухай сургаал мөн
- C. Деонтологи бол гүн ухааны ухагдахуун мөн
- D. Деонтологи мэргэжлийн үүрэг хариуцлагын тухай сургаал мөн
- E. Деонтологи бол зан суртхууны тухай сургаал мөн.

/149./ Үйлчлүүлэгчийн амьдрах хугацааг уртасгахад чиглэсэн арга хэмжээ цаашид үр дүнгүй нь илэрхий тохиолдолд үйлчлүүлэгчийн өвдөлт зовиур шаналгааг багасган амар тайван байдлыг хангах эмчилгээ үзүүлж болох уу?

- A. Болно
- B. Болохгүй
- C. Ар гэрийн зөвшөөрөлтэй үед
- D. Эмч нарын шийдвэрээр
- E. Зөвхөн өөрийнх нь хүсэлтээр

/150./ Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан болсноор эрүүл мэндийн ёс зүйн үүрэг хариуцлага өөрчлөгдөх үү?

- A. Өөрчлөгдөхгүй
- B. Өөрчлөгдөнө
- C. Үүрэг хариуцлага нэмэгдэнэ
- D. Үйлчлүүлэгчтэй байнга харьцахгүй тул үүрэг хариуцлага буурна
- E. Өөрчлөгдөх хандлагатай байна.

/151./ Донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбарт хэнээс зөвшөөрөл авах вэ ?

- A. Донороос
- B. Эрхтэн хүлээн авагчаас
- C. Эмчээс
- D. Эрхтэн хүлээн авагч болон донороос тус тусад нь
- E. Тасгийн эрхлэгчээс

/152./ Анагаах ухаан сувилахуйн стандартад нийцээгүй үйлчилгээ үйлдлийг эмчийн зааврийн дагуу гүйцэтгэхээс татгалзах эрхтэй субъект аль нь вэ?

- A. Сувилагч
- B. Дадлагын эмч
- C. Асрагч
- D. Асрагч болон сувилагч
- E. Бага эмч

/153./ Эмнэлгийн мэргэжилтэн нь

A. Шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төгс үзүүлэхэд өөрийн мэдлэг, чадвар, туршлагыг бүрэн зориулж, хүнлэг энэрэнгүй, шудрага ёсны зарчмыг баримтлана.

B. Эрх зүйн мэдлэгт тулгуурлан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төгс үзүүлэхэд өөрийн мэдлэг, чадвар, туршилагыг бүрэн зориулж, хүнлэг энэрэнгүй, шудрага ёсны зарчмыг баримтлана.

C. Тусламж, үйлчилгээг үзүүлэхэд өөрийн мэдлэг, туршлагаа бүрэн зориулж, хүнлэг энэрэнгүй, шудрага ёсны зарчмыг баримтлана

D. Тусламж үйлчилгээг үзүүлэхэд шудрага ёсны зарчмыг баримтална.

E. Шинжлэх ухааны болон эрх зүйн бүрэн мэдлэгт тулгуурлан хүнлэг энэрэнгүй, шудрага ёсны зарчмыг баримтлана.

/154./ Хэрэв үйлчлүүлэгчийн буруу харилцааны улмаас мэргэжлийн үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй тохиол үүсвэл эмнэлгийн мэргэжилтэн хэнд хандах учиртай бэ?

- A. Өөрийн байгууллагын удирдлагад
- B. Хууль хяналтын байгууллагад
- C. Өөрөө зохицуулна
- D. Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд
- E. Ёс зүйн хороонд

/155./ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд эмнэлгийн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчидэд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ “ давхар харилцаа “-нд орохыг хориглодог. Тэгвэл эдгээрэс аль нь хориглосон “ давхар харилцаа вэ ?

- A. Өөрийн эрхшээлд оруулах
- B. Дотно яриа өрнүүлэх
- C. Чихэр жимсээр дайлуулах
- D. Эмчилгээний талаар зөвлөлдөх
- E. Оношийг нууцлах

/156./ Эмнэлгийн мэргэжилтэн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг юу гэх вэ?

- A. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй
- B. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ
- C. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим
- D. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- E. Эмнэлгийн мэргэжилтний ёс журам

/157./ Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу ашиглуулж болох уу

- A. Тийм
- B. Үгүй
- C. Зарим тохиолдолд болно
- D. Хуулийн хүрээнд болно
- E. Ёс зүйн хэм хэмжээний хүрээнд болно

/158./ Эмнэлгийн мэргэжилтэн нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд зөвөлгөө өгч буй тохиолдолд юу хориотой вэ?

- A. Эмчилгээ, оношлогооны аргыг шууд зааварчлах
- B. Өвчний талаарх ерөнхий мэдээлэл өгөх
- C. Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар ярих
- D. Биологийн идэвхит бүтээгдэхүүний талаар ярих
- E. Тусламж үйлчилгээ авахад шаардлагатай лавлагаагаар хангах

/159./ Үйлчлүүлэгчийн нууц гэж

- A. Үйлчлүүлэгчийн яриа, өвчний түүх, шинжилгээг хэлнэ.
- B. Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал
- C. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн яриа, өвчтөний түүх, үзлэг шинжилгээ, өвчний байдалд өгсөн тэмдэглэл , зэргээс олж авсан хувь хүний нууцал хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйл.
- D. Эрүүл мэндийн тусламж үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн яриа, өвчтөний түүх, үзлэг шинжилгээ, өвчний байдалд өгсөн тэмдэглэл
- E. Хувь хүний нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйл

/160./ Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй асуудал гарвал эцсийн шийдвэрийг хэн гаргах вэ ?

- A. Эмчлэгч эмч
- B. Тасгийн эрхлэгч
- C. Зөвлөх эмч
- D. Эмнэлгийн дарга
- E. Хамгийн олон жил ажилласан туршлагатай эмч нь

/161./ Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хоорондын харилцааны тулгуур зарчмуудаас нэрлэнэ үү?

- A. Найз нөхөрийн харилцаа
- B. Дотно элэгсэг харилцаа
- C. Харилцан хүндэтгэлцсэн харилцаа
- D. Нэр төрөө харилцан хамгаалсан харилцаа
- E. Найз нөхөрийн харилцаа

/162./ Амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй , тусламж үйлчилгээ үзүүлэх тохиолдолд үйлчлүүлэгч насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүй бол хэрхэн шийдвэрлэх вэ

- A. Тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзана
- B. Үйлчлүүлэгчийн хууль ёсны төлөөлөгчөөс амаар шийдвэр авна.
- C. Үйлчлүүлэгчийн хууль ёсны төлөөлөгчөөс бичгээр шийдвэр авна.
- D. Амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй учир эмчээс шийдвэр авна
- E. Эмнэлгийн даргаас зөвшөөрөл авна

/163./ Эмнэлгийн мэргэжилтэн ялтанд ямар зарчмыг баримтлан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ёстой вэ?

- A. Хуулийн ажилтны заавраар
- B. Өөрийн үзэмжээр
- C. Хуульд заасны дагуу
- D. Асуудалд орооцолдохгүй гэсэн хүслээрээ
- E. Батлагдсан онош , стандартын дагуу

/164./ Эмч-үйлчлүүлэгчийн харилцаанаас гадуур бусад харилцаа нь ямар ойлголт вэ?

- A. Давхар харилцаа
- B. Тусгай харилцаа
- C. Шууд бус харилцаа
- D. Хэвийн харилцаа
- E. Тэгш бус харилцаа

/165./ Өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах үед ямар үйлдэл гүйцэтгэх вэ?

- A. Эмчээс зөвшөөрөл авна
- B. Өөрөө хүссэн учир шууд гарна
- C. Зөвшөөрлийн хуудас бөглөнө
- D. Эмнэлгийн даргаас зөвшөөрөл авна
- E. Эмнэлгийн ёс зүйн хороонд өргөдөл гаргана

/166./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ял эдэлж буй хүнтэй хэрхэн харьцах вэ ?

- A. Гэм буруутай тул хуулийн ажилтнуудыг дэмжинэ
- B. Тусламж, үйлчилгээг тэгш, чанартай үзүүлнэ
- C. Тарчлаан зовоохын эсрэг байна
- D. Яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно
- E. Харгис хэрцгий хандлагыг нуун дарагдуулна

/167./ Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудсан буюу үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд энэ тухай түүний хууль ёсны төлөөлөгчид үнэн бодитоор мэдээлэх үүргийг хэн хүлээх вэ

- A. Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлсэн , эсвэл мэс ажилбарт оролцсон ажилтнуудаас нэг нь
- B. Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлсэн , эсвэл мэс ажилбарт оролцсон ажилтнууд багаараа
- C. Зөвхөн эмч
- D. Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлсэн сувилагч
- E. Эмнэлгийн байгууллагын чанааны албаны дарга

/168./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ямар тусламж үйлчилгээ үзүүлхийг эрмэлзэж ажилладаг вэ?

- A. Биеийн байдлыг сайжруулах
- B. Сэтгэл санааны дэм үзүүлэх
- C. Зовлон зүдгүүрийг багасгах
- D. Нэмэлт зовиур үүсгэхгүй байх
- E. Бүгд зөв

/169./ Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг юу гэх вэ?

- A. Ёс зүйн хэм хэмжээ
- B. Ёс зүйн горим
- C. Ёс зүйн хууль
- D. Ёс зүйн дүрэм
- E. Эмчийн тангараг

/170./ Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг гэж хэлнэ

- A. Эмнэлгийн мэргэжилтэн
- B. Эрүүл мэндийн ажилтан
- C. Эрүүл мэнд, спортын яам
- D. Эрүүл мэндийн байгууллага
- E. Эрүүл мэндийн хөгжлийн төв

/171./ Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудсан буюу үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд энэ тухай түүний хууль ёсны төлөөлөгчд хэн мэдэгдэх ёстой вэ

- A. Эмч
- B. Сувилагч
- C. Эмнэлгийн захирал
- D. Тасгийн эрхлэгч
- E. Аль завтай эмнэлгийн мэргэжилтэн нь

/172./ Эмнэлгийн яаралтай тусламж гэдэг нь

- A. Амь насанд аюултай аливаа эмгэгийг яаралтай оношлох үйл ажиллагаа
- B. Амь насанд аюултай аливаа эмгэгийг яаралтай эмчлэх үйл ажиллагаа
- C. Амь насанд аюултай аливаа эмгэгийг оношлох, сэхээн амьдруулах үйл ажиллагаа

D. Амь насанд аюултай эмгэгийн үеийн сэхээн амьдруулах үйл ажиллагаа

E. Амь насанд аюултай аливаа эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах цогц үйл ажиллагаа

/173./ “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” –н тухай зөв ойлголтыг ол

A. “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, ёс суртахуун, үйл ажиллагаа, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг” хэлнэ.

B. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, мэргэжлийн чадвар, харилцааны эв дүй, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “хэлнэ.

C. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “хэлнэ.

D. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаягын тухай цогц ойлголтыг “хэлнэ.

E. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг “хэлнэ.

/174./ Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил зан үйл чиг хандлага дадал тогтсон дэг жаяг хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг юу гэх вэ?

A. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй

B. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ

C. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим

D. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

E. Эмнэлгийн мэргэжилтний ёс журам

/175./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ямар тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болох вэ?

A. Үйлчлүүлэгч болон хууль ёсны төлөөлөгч эмнэлгийн мэргэжилтэнтэй зүй бусаар харилцах

B. Бие махбодид халдах

C. Заналхийлэх

D. Айлган сүрдүүлэх

E. Бүгд зөв

/176./ Биологийн идэвхит бүтээгдэхүүн гэдэг нь

A. Хүний бие махбодийн үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчлэл бүхий бүтээгдэхүүн

B. Тухайн хүнд нэн шаардлагатай байгаа эм, тариа

C. Хүний бие махбодийг дэмжих тэжээллэг бүтээгдэхүүн

D. Тухайн хүнд нэн шаардлагатай байгаа идэвхит биологийн бүтээгдэхүүн

E. Хүний бие махбодид шаардлагатай илчлэг

/177./ Эмнэлгийн мэргэжилтэнд ёс зүйн үүднээс үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой мэдээлэлийг санаатай болон санамсаргүй байдлаар хаана ярих, шүүмжлэн хэлэлцэхийг хориглодог бэ

A. Ажлын байран дээр ярих

B. Тухайн эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцах

C. Хөндлөнгий хүний дэргэд ярих

D. Үйлчлүүлэгчийн дэргэд

E. Тасгийн эрхлэгчийн дэргэд

/178./ Эмнэлгийн мэргэжилтэнд үйлчлүүлэгчтэй холбоотой бичиг баримтын хөтлөлтөнд аль үйлдлүүдийг хориглодог вэ?

A. Устгах

B. Таталган бичих

C. Сурагчийн дэвтэрт бичих

D. Компьютрээр бичих

E. Хураангуйлан бичих

/179./ Эмнэлгийн мэргэжилтэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялантай харилцахдаа ёс зүйн үүднээс хэрхэн хандах вэ?

- A. Өлсгөлөн зарлахыг хориглоно
- B. Хуулийн ажилтнуудыг дэмжинэ
- C. Басамжлахыг эсэргүүцэнэ
- D. Эмнэлгийн мэргэжилтэн миний хувьд зөвхөн эмнэлгийн тусламж үзүүлнэ
- E. Хууль ёсны цээрлэл үзэж байгаа учир миний тангарагт харшлахгүй

/180./ Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн саад болхооргүй өрөө эсхүл зориулалтын тусгаарлагдсан өрөө тасалгаанд тусламж үйлчилгээ үзүүлдэг. Үүнийг юу гэж тодорхойлж болох вэ?

- A. Хөндлөнгийн саадгүй орчин
- B. Үл ялгаварлан гадуурхах
- C. Жендерийн тэгш байдал
- D. Мэргэжлийн тоног төхөөрөмжтэй орчин
- E. Тусгай цэвэр орчин

/181./ Мэс ажилбар хийлгэх тухай зөвшөөрлийн хуудасны загварыг хэдэн хувь үйлдэх вэ

- A. Нэг
- B. Хоёр
- C. Гурав
- D. Тав
- E. Дөрөв

/182./ Эмнэлгийн мэргэжилтнүүдэд өөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахдаа ёс зүйн үүднээс хориглосон зүйл аль нь вэ?

- A. Нэрээ нууцлах
- B. Худал ташаа мэдээлэл өгөх
- C. Ерөөс мэдээлэхгүй байх
- D. Эмнэлгийн мэргэжилтний төгссөн сургууль, ажлын дадлага туршлага
- E. Эмнэлгийн мэргэжилтний тусламж үйлчилгээ үзүүлэх байршил, хуваарь

/183./ Эмнэлгийн мэргэжилтэн нь

A. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад тухайн үйлчлүүлэгчийнхээ өвчний талаар бусад эмчийн зөвөлгөө, тусламжийг авч болохгүй

B. Зөвхөн өөрийн санаачлагаар үйлчлүүлэгчийнхээ өвчний талаар бусад эмчийн зөвөлгөө, тусламжийг авч болно

C. Зөвхөн үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлтөйгөөр үйлчлүүлэгчийнхээ өвчний талаар бусад эмчийн зөвөлгөө, тусламжийг авч болно.

D. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа өөрийн санаачлагаар буюу үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр бусад эмчийн зөвөлгөө, тусламжийг авч болно.

E. Эрүүл мэндийн тусламж үзүүлэн, зөвөлгөө өгсний дараа үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгчийн хүсэлтээр бусад эмчийн зөвөлгөө, тусламжийг авч болно

/184./ Иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахдаа ёс зүйн хүрээнд доорхи эрхүүдээс аль алиныг нь эдлэх эрхтэй вэ?

1. Эмчийн зөвлөсөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эсэхийг өөрөө шийдэх .,

2. Нийгэмд аюултай халдварт өвчтэй, сэтгэцийн хувьд өөрийгөө хянах чадваргүй болсноос бусад тохиолдолд эмчийн санал болгосон аливаа оношлогоо , эмчилгээг хийлгэхээс татгалзах

3. Нууцаа хамгаалуулах

4. Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүрэн бодит мэдээллийг өөрөө асуугаагүй тохиолдолд ч ойлгомжтой үг хэллэгээр авах

5. Тусламж үйлчилгээг хүлээн авах явцад эмчийг солих санал тавих.,

/185./ Эмнэлгийн мэргэжилтэн ёс зүйн үүднээс бие биендээ хэрхэн туслах вэ?

1. Харилцааны доголдлоос сэргийлэхэд нь

2. Ёс зүйгүй үйлдлээс сэргийлэхэд нь

3. Алдаа дутагдлыг нь шудрагаар илчлэх

4. Өмөөрч хаацайлахад нь

5. Мэргэжлээ дээшлүүлэхэд нь
- /186./ Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах ёстой вэ?
1. Хүнлэг энэрэнгүй хандах
 2. Нэр төрийг хүндэтгэх
 3. Хууль ёсны эрхийг хүндэтгэх
 4. Шударга ёсыг баримтлан
 5. Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах
- /187./ Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйд дараах хэм хэмжээ орно
1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үл ялгаварлан хүн бүрт тэгш, хүртээмжтэй үзүүлнэ
 2. Эмнэлгийн мэргэжилтэн нь мэдлэг, чадвараа байнга дээшлүүлэн, шаардлагатай үед бусад мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, тэдэнтэй мэдлэг, ур чадвараа харилцан солилцоно
 3. Эмнэлгийн мэргэжилтэн нь аливаа дүгнэлт, шийдвэрийг бодит байдалд тулгуурлан үнэн зөв гаргана ажиллана
 4. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг мөрдөж ажиллана
 5. Эмнэлгийн мэргэжилтэн нь шинжлэх ухааны ололт, нээлтийг ажилдаа бүтээлчээр нэвтрүүлэхийг эрмэлзэж ажиллана
- /188./ "Үйлчлүүлэгчийн нууцад" аль нь хамрагдах вэ?
1. Үйлчлүүлэгчийн ярианаас олж авсан мэдээ
 2. Шинжилгээ хийхээр авсан биопсийн биет зүйлүүд
 3. Өвчний хэтийн байдалд өгсөн тэмдэглэл
 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авсныхаа төлөө авилга өгөхийг завдсан тухай мэдээлэл
 5. Эмнэлгийн мэргэжилтэнтэй давхар харилцаанд орсон тухай мэдээлэл
- /189./ Эмнэлгийн мэргэжилтэн ёс суртахууны үүднээс эрхэмлэх зүйлүүд аль нь вэ
1. Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалдаг
 2. Шудрага
 3. Хүнлэг энэрэнгүй
 4. Зоригтой
 5. Дайчин
- /190./ Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, үр дүн нь тодорхойгүй, стандартын бус, чанарын баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг эмнэлгийн мэргэжилтэн нь
1. Дэмжиж сурталчлахгүй, түүнийг оношлогоо эмчилгээнд хэрэглэхгүй байх
 2. Зарж борлуулахгүй, түгээхгүй байх
 3. Үйлчлүүлэгчид санал болгохгүй, сурталчлахгүй байх;
 4. Хүнд өвчтэй учир үр дүн өгөж магад гээд хэрэглээд үзэхийг санал болгоно
 5. Хямдаар зарж байгаа газрыг санал болгож болно
- /191./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчдэд тохиолдож болзошгүй хүчирхийллийн нөлөөлөлд хэрхэн хандах ёс зүйн үүрэгтэй вэ ?
1. Уг асуудлын учир холбогдлыг сайн мэдэхгүй байна
 2. Энэ нь эмнэлгийн мэргэжилтний ажил үүрэгт төдийлэн хамаарлалгүй
 3. Энэ төрийн бус байгууллагын үүрэг
 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
 5. Энэ нь хуулийн байгууллагын ажил үүрэгт хамрагдах учраас бидэнд холбогдолгүй
- /192./ Аль тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчээс шийдвэрийг бичгээр авах вэ
1. Амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх;
 2. Мэс ажилбар, мэс засал хийх тохиолдол бүрт
 3. Гоо сайхны мэс засал хийх тохиолдолд
 4. Эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх
 5. Үйлчлүүлэгч сэтгэцийн хүнд эмгэгтэй үед
- /193./ Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа ямар зарчмуудыг баримтлах ёстой вэ?
1. Хууль дээдлэх
 2. Шударга ёс
 3. Хариуцлага хүлээх, үйлчлэх

4. Үл ялгаварлан гадуурхах
5. Үндэсний хэв заншлыг хадгалах

/194./ Эмнэлгийн хязгаарлагдмал нөөц гэж

1. Тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хангалтгүй байдал
2. Эмчилгээний тоног төөхөөрөмжийн хангалтгүй байдал
3. Эм тарианы хангалтгүй байдал
4. Өрөө тасалгааны хангалтгүй байдал
5. Гадаад харилцааны хомс байдал

/195./ Эмнэлгийн мэргэжилтний ёс суртахууны ухамсарын бүрдэлд хамаарахыг заа.

1. Ээдрээ төвөгтэй нөхцөлд үүрэг хариуцлагаа биелүүлж чадах ухамсартай байх
2. Шинэ сэтгэлгээ арга барилыг цаг ямагт эрэлхийлэх
3. Мэргэжилдээ итгэл үнэмшилтэй байх
4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартыг чанд баримтлах
5. Хүмүүст дээд зэргийн анхаарал халамжтай хандах

/196./ “Эрүүл мэндийн тухай” хуульд зааснаар эмнэлгийн мэргэжилтнүүд ямар ямар үүрэг хүлээх вэ?

1. Оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, удирдамж, технологийг чанд мөрдөх

2. Эрүүл мэндийн холбогдолтой хууль тогтоомжуудыг чанд биелүүлэх
3. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх
4. Амаржих гэж буй эхэд эмнэлгийн тусламжийг ямарч нөхцөлд үзүүлэх
5. Хүн амд эрүүл мэндийн сургалт суртчилгаа явуулах

/197./ Эмнэлгийн мэргэжилтэн тухайн хүний амьдралын төгсгөл сөрөг талруу нэгэнт тодорхой болсон тохиолдолд баримтлах ёс зүйн хандлагыг тодорхойлно уу .

1. Оношийн үнэн байдлыг хэлж ойлгуулна
2. Өвдөлт , зовиур шаналгааг нь багасгах бололцоотой бүх арга хэмжээг авна
3. Аль болох амар тайван байдлыг нь хангах арга хэмжээ авна.
4. Оношын үнэнийг хэлэх нь буруу
5. Ар гэрийнхэнд нь асарч сувилах талаар зөвлөлгөө өгнө

/198./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ямар тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө шийдвэрийг бичгээр авдаг вэ?

1. Үйлчлүүлэгчийн хууль ёсны төлөөлөгч тусламж үйлчилгээнээс татгалзсан үед
2. Амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй үйлчилгээ үзүүлэх үед
3. Эрх зүйн чадамжгүй үйлчлүүлэгчид мэс ажилбар хийх үед
4. Донорын эд эрхтэн шилжүүлэх үед
5. Үйлчлүүлэгч насанд хүрээгүй

/199./ “ Эрүүл мэндийн тухай ” хуульд зааснаар иргэн ямар ямар үүрэг хүлээх вэ?

1. Халдварт өвчин тархахаас сэргийлж , хөл хорионы журмыг сахин мөрдөх
2. Халдварт өвчний үзлэг шинжилгээнд өөрийн санаачлагаар болон эмч эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох
3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар зохиож байгаа ажилд оролцох
4. Эрүүл мэндийн боловсрол эзэмших
5. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлт зан үйлээс татгалзах, сэргийлэх

/200./ Эмнэлгийн удирдах ажилтан нь ёс зүйн дараах НЭМЭЛТ үүргийг хүлээнэ:

1. Хариуцсан нэгж, байгууллагын түвшинд үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах нөхцлийг бүрдүүлнэ
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан эмчийн хүсэлтийг хүлээн авч , шалган, нэн даруй шийдвэрлэнэ.
3. Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ёс зүйн хороо болон салбар хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
4. Эмнэлгийн хязгаарлагдмал нөөцийг шударгаар хуваарилах тухай байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлнэ.
5. Ёс зүйн хариуцлагаа өндөрсгөнө

/201./ Эмнэлгийн мэргэжилтэн нь дараах үүрэгтэй

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүний талаар ташаа мэдээлэл бүхий сурталчилгааг холбогдох байгууллагад мэдэгдэх

2. Эмчилгээний аргатай холбоотой ташаа, бүрэн бус мэдээлэл бүхий сурталчилгааны талаар холбогдох байгууллагад мэдэгдэх

3. Ойлгомжгүй, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, удирдамжид нийцээгүй мэдээлэллийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх

4. Эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, удирдамжид нийцээгүй мэдээлэл бүхий сурталчилгааны талаар холбогдох байгууллагад мэдэгдэх

5. Эмнэлгийн байгууллагаас гаргасан оношлогоо нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, удирдамжид нийцээгүй мэдээлэллийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх

/202./ Эмнэлгийн мэргэжилтэн аль тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болох вэ

1. Ял эдэлж буй хүнд

2. Эмнэлгийн мэргэжилтнээс шаардсан үйлчилгээ нь хууль бус тохиолдолд

3. Тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй байдал үүссэн

4. Эмнэлгийн мэргэжилтэний бие махбодид халдсан , завдсан, айлган сүрдүүлсэн тохиолдолд

5. Эмнэлгийн удирдлагад тусламж үзүүлэхээс татагалзсан үндэслэлээ бичгээр мэдэгдсэн ба ажлын цаг дууссан үед

/203./ Анагаах ухааны ёс зүйн үүднээс эмнэлгийн нөөцийг хэрхэн хувиарлах бэ?

1. Хуулийн заалтаар

2. Эмнэлгийн мэргэжилтэн өөрөө шийдэж

3. Эрүүл мэндийн төв байгууллагын заавараар

4. Эхэнд ирсэн иргэнд

5. Энэ асуудал төдийлөн учир холбогдолгүй

/204./ Хэрэв үйлчлүүлэгч насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй бол мэс ажилбар хийх шийдвэрийг хэнээс бичгээр авах вэ?

1. Эцэг эх , асран хамгаалагч

2. Харгалзан дэмжигч

3. Хууль ёсны төлөөлөгч

4. Тасгийн эрхлэгч

5. Эмнэлгийн дарга

/205./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчидэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ ёс зүйн үүднээс чухалчлан эрмэлзэх чанаруудыг нэрлэнэ үү .

1. Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг сайжруулах

2. Зовлон зүдгүүрийг багасгах

3. Сэтгэл санааны дэм үзүүлэх

4. Зөв оношлох

5. Санаа тавих